

Ч.Айтматов

ДАЛАЙН ХӨВӨӨНИЙ АЛАГ ХАВ ТОЛГОЙ

Нэвтрлэшгүй өтгөн манан хөвөлзсөн жихүүн шөнө Агнуурын тэнгисийн бүх эргийн дагуу, тэнгис газар хоёрын бүх фронтын дагуу мөнхийн хоёр догшин хүчин тэмцэлдэж, газар нь тэнгисийн түрэлтийг сөрж, тэнгис нь газар өөд эцэж цуцахыг үл мэдэн давшилсаар байлаа.

Харанхуйн дунд тэнгис далай энэлэн хурхирч, эргийн хавцлыг мөргөн буцна. Хатуу чулуун газар тэнгисийн давалгааны балбахыг хариулан хүчлэн уухилна.

Тэнгис газар хоёр анх бүтсэн цагаас хойш, өдөр шөнө гэж болдог болсон цагаас хойш үргэлж ингэж тэмцэлдэн ирсэн бөгөөд хойшид ч газар ус гэж байсан цагт өдөржин шөнөжин ингэж сөрөлдөж байх биз.

Өдөржин, шөнөжин...

Газар дэлхий дээр бас нэг шөнө өнгөрөв. Энэ бол түүний далайд явахын урд шөнө байв. Энэ шөнө тэр унтсангүй. Амьдралдаа анх унтсангүй, амьдралдаа анх удаа нойргүй хонож үзэв. Шалавхан өдөр болоосой тэнгэс далайд гарах юмсан гэж нэн ч хүсэмжилнэ. Тэр хав загасны арьс дэвсэж, хэвтээд тэнгэсийн давалгааны балбалтаас газар дэлхий хэрхэн үл мэдэг доргиж, тэнгэсийн буланд далайн давалгаа хэрхэн энэлэн нижигнэж байгааг чагнана. Шөнөжин чимээ чагнаж огтхон ч унтсангүй...

Эрт урьд хэзээ нэгэн цагт энэ бүхэн шал ондоо байжээ. Одоо тийм байсан гэж мэдэхийн ч арга үгүй, тэр тухай хэн ч мэдэхгүй, тэр ч байтугай эрт дээр үед Лувр гэдэг нэг нугас байгаагүйсэн бол энэ газар дэлхий гэдэг шал ондоо газар нь усны эсрэг сөрөх юмгүй, ус нь газрын эсрэг сөрөх юмгүй, санаа амар байх байсан гэж хүний санаанд ч орохгүй байсан биз. Ерөөс бүр анхандаа байгальд хуурай газар гэж байсангүй, хумхийн тоос ч байсангүй. Эргэн тойрон ус, дандаа ус л цэлэлзэж байжээ. Ус бол өөрөө үүсээд л харанхуй хар ёроолтой, хэмгүй их ойл эргүүлэгтэй хязгаар хярхаггүй их далай тогтчихсон хэрэг. Чингээд усны давалгаа хойно хойноосоо долгион, тэр үед дэлхий ертөнцөд дөрвөн зүг найман зовхис гэж байгаагүй болохоор усны долгион зүг чиггүй тал бүрд давалгаалан байжээ.

Гэтэл өнөө хүртэл бидний толгой дээгүүр нисэн өнгөрдөг сүрэг нугасны нэгэн Лувр хэмээгч ердийн хавтгай хошуут цоно нугас энэ дэлхий ертөнцийн дээгүүр цорын ганцаар нисэн нисэвч өндөглөх газар хаана ч олсон нь үгүй. Бүхэл бүтэн дэлхийд уснаас ондоо юу ч үгүй, ядахдаа үүр засчихмаар ганц хулс ч үл ёрдойно.

Лувр нугас ёроолгүй ойл эргүүлэг дунд өндгөө унагачихвий гэж тэсэлгүй айж гуаглан ниссээр байжээ. Гэвч хаашаа ч ниссэн хаана ч хүрсэн дан усны долгион цалгилян, эргэн тойрон эрэг хөвөөгүй, эх адаггүй их ус л байжээ. Лувр нугас тэнхээгээ бараад энэ бүхэл бүтэн дэлхий дээр үүр зсах газар хаана ч байхгүй гэдгийг олж мэдэж дээ.

Чингэхлээр нь усан дээр бууж, хэнхдэг цээжнийхээ өд сөднөөс зулгаан үүр засав. Чингээд л тэр үүрнээс газар гэдэг юм үүсчээ. Газар бага багаар тэлж, газар дээр аажим аажмаар элдвийн амьтан орших болов. Гэтэл тэдний дундаас хүн гэдэг амьтан анх түрүүн давамгайлж, цасан дээгүүр цанаар явах, усан дээгүүр завиар хөвөх гэж оролдох болжээ. Ан агнаж, загас барьдаг болж, түүгээр хооллон, овог омгоо олшруулан ирэв.

Тэр энгүй их усан дунд хатуу газар бий болохоор орчлон ертөнц дээр байдал бэрх болно гэж Лувр нугас даанч мэдсэнгүй ажээ. Газар гэдэг юм бий болсон тэр цагаас хойш тэнгис далай тайвангүй болж, тэр цагаас хойш газар нь тэнгисийн эсрэг, тэнгис нь газрын эсрэг нүдэлдэх болжээ. Гэтэл хүн газар тэнгис хоёрын хооронд хавчигдаж заримдаа нэн ч бэрхтэй орших болжээ. Ер хүн хуурай газарт илүү дуртай болохоор тэнгис тэдэнд дургүй юм...

Өглөө болох дөхөж байв. Энэ дэлхий дээр бас нэг шөнө өнгөрч бас нэг өдөр эхлэх гэж байв.

Үл мэдэг гэгэлзэх харанхуй дунд тэнгисийн ус газрын эрэг лүгээ шуугин нийлэх зааг саарал манан дунд бугын уруул адил бүдэг бадаг зурайн харагдах болов. Тэнгис далай уухилсаар. Тэнгис газар хоёр шуугин нийлэх заагийн дагуу цэвдэг хүйтэн усны жихүүн уур бөөн бөөнөөр хөөрч, тэнгис далайн урт эргийн дагуу хүнгэнэн хүрхрэх их чимээ үүснэ.

Тэнгисийн давалгаа газар дээр гарах гэж ихэд зүтгэх бөгөөд хүчирхэг их давалгаа хойно хойноосоо түрэн газар өөд давшлан усанд угаагдсан элсний хүйтэн хатуу цараа дээгүүр арзайсан хүрэн улаан хад чулуун дээгүүр тэнхээ мэдэн дүүлэвч сая амьсгаа тавих мэт хойно хойноосоо үелзсээр буцахдаа эцсийн удаа цалгилан, бөөн хөөс сахруулж, хөвмөл засгийн нэвшингэ үнэр үлдээх ажээ.

Тэнгисийн давалгаа заримдаа гадаад их далайн хаврын урсгалд хаанаас хөвж ирсэн нь үл мэдэгдэх мөсний хэлтэрхий эргийн дээр гарган хаях нь үзэгдэнэ. Эргийн элсэн дээр хаягдсан тэрхүү зайгуул мөс төдхөн арчаагүй нимгэн мөхөөлдөс төдий болохын сацуу дараачийн давалгаа дүүлэн ирж буцахдаа дахин хөвүүлэн аваачиж, байгалийн их хүчиндээ нийлүүлэх бөлгөө.

Үүр хяраалж улам гэгээтэй болов. Газрын бараа аажмаар зурайн, тэнгис далай ч тодрон үзэгдэв.

Шөнийн салхинд уймарсан далайн давалгаа эрэг хөвөө хавиар мөн л цайран үелзэвч эргээс цааш гүн лүүгээ долгион намдаад тэртээ цаана овор их ирэлжээ гялалзан харагдав.

Тэнгисийн зүгээс үүл нүүж далайн эргийн толгодын зүг ойртож байв.

Энд тэнгисийн Алаг хав хэмээх тохойн ойролцоо далай руу хатгаж орсон дов толгод бүхий хойгийн дээр нэгэн онцгой хавцал толгой илхэн харагдах бөгөөд тэрхүү толгойг холоос харахад далайн хөвөөгөөр шогшин яваа том гэгчийн алаг нохой лугаа адил харагдах ажгуу. Хоёр хажуугаар нь элдвийн өргөст бут сөөг ургачихсан, зуны аагим халуун болтол үл хайлах цагаан цас толгойн дээр тогтоод хоёр том чих адил унжчихсан, бас цавь суга аль сүүдэртэй газарт мөн цагаан цас тогтсон тэр Алаг хав хэмээвэл зохих толгой далайгаас ч, ойн зүгээс ч хамгийн түрүүн илхэн харагддаг авай.

Өглөө наран ургаж хоёр улиангарын төдий өндөрт хөөрөхийн сацуу тэндээс, Алаг толгойн булангаас Нивхи ястны хэлээр Каяк хэмээн бяцхан гуя онгоц далайд гарав. Завийн дээр гурван ангуучны хамт нэгэн багашиг хөвгүүн явав. Арай залуу, арай чийрэг хоёр нь онгоц ны дөрвөн сэлүүр барьж, хамгийн хөгшин нэг өвгөн онгоцны хитэг дээр суугаад модон гаанс яаралгүй сорон завийг жолоодон явав. Хүрэн царайтай, учиргүй шовх төвөнхтэй тэр туранхай өвгөний нүүр онц үрчгэр агаад ялангуяа хүзүүн дээгүүр нь гүнзгий гүнзгий нугалаа хэрчлээс тогтжээ. Үен дээгүүрээ булдруу сууж, хага хага үсэрч сорви болсон өвгөний том гар нь биедээ нэн ч зохицжээ. Үс буурал бараг цагаан хүрэн улаан нүүрт нь бор хөмсөг тун тод харагдана. Тэр өвгөн ус гүйлэгнэсэн улаан нүдээ үргэлж онийлгоод явах нь нарны туяа ойх усны мандлыг насаараа ширтэж сурсан боллолтойн дээр тэнгисийн энэ буланд мөнөөхөн гуя онгоцыг зүг таамаг залж явсан шиг

санагдана. Гуя онгоцны нөгөө үзүүрт онгоцны яг хошуун дээр арван нэг хоёр орчим насны хархан нүдтэй хөвгүүн цууцаль адил дөнгөн хавчуулдаад үргэлж хөмсөг атируулан яваа өвгөн зайсанд гологдохгүйн тул аль болохоор өндөлзөхгүйг хичээн заримдаа томцуулыг гэтэн харна.

Жаал хөвгүүний сэтгэл машид догдлон явав. Сэтгэл догдолсноос хамрын хоёр нүх сартайж, царайд нь үл мэдэг сэвх тодорчээ. Энэ бол эхийгээ дуурайсны тэмдэг юм. Эх нь ямар нэгэн юманд онц их баярлавал нүүрт нь мөн тийм нууцгай сэвх тодрон ирдэг билээ. Жаал хөвгүүний сэтгэл догдлох нь долоон зөв. Юу гэвэл энэ удаа жаал хөвгүүнийг анд сургахаар зориуд дагуулан явжээ. Эл учир Кириск хүү цууцаль адил бөндөгнөн тал тал тийш тэсгэлгүй сонирхон харж явав. Кириск бол амьдралдаа анх удаа жинхэнэ анчин улсыг дагаж, жинхэнэ их авд мордохоор отгийнхоо хамгийн том гуя онгоцонд суугаад тэнгис далайд гарч яваа нь энэ. Жаал хөвгүүн суудлаасаа өндөлзөн, сэлүүрчдийг шавдуулахсан гэж онц хүсч явав. Нөгөө далайн ан байдаг аралд бушуухан хүрэхийн тулд өөрөө сэлүүрийг шүүрэн авч байдаг хүчээрээ сэлэх юмсан гэж онц хүсч явав. Гэвч тийнхүү хүүхэд зан гаргах юм бол томоотой улсын инээдмийг хүргэх болно. Эл учир хөвгүүн догдолсон сэтгэлээ нуух гэж байдгаараа хичээнэ. Гэвч тэр байдлаа нууж явж огтхон ч эс чадна. Үнэндээ тийнхүү жаргалтай яваагаа нуух гэдэг түүнд бэрх байлаа. Чийрэг бор хацар нь өөрийн эрхгүй халуу оргин улайжээ. Ялангуяа хүүхдийн цог заль төгөлдөр ариун тунгалаг нүд нь түүний сэтгэлийн дотор оволзох баяр бахдалыг ил гаргахгүй нууж хэрхэвч чадахгүй байв. Далайд гарч ан агнах гэдэг юутай сайхан!

Орган хэмээх өвгөн хөвгүүний сэтгэлийг мэдэж байв. Нүдээ онилгоод урагш ширтэн хөвгүүний сэтгэлийг хэдийнэ ойлгож, “Ай даа! Бага насаа гэж!” хэмээн харцаараа энхрийлэн явахдаа зориуд инээмсэглэхгүй гэж хагас дутуу унтарсан гаансаа сорон сорон явав. Ер нь инээмсэглэн яваагаа мэдэгдэж болохгүй. Энэ хөвгүүн ямар тэдэнтэй эрхэлж яваа биш. Далайн анчин болох гэж яваа хүүхэд. Энэ ажлыг нэгэнт эхэлвэл хожим нэгэн цагт мөн далайдаа төгсгөх хэрэгтэй. Далайн ангуучдын хувь зохиол тийм байдаг болой. Учир нь энэ хорвоод далайн агнуураас ондоо бэрх мөртөө осолтой ажил байхгүй. Тэгвэл энэ ажилд хар багаасаа дадах хэрэгтэй. Тийм ч учраас “оюуныг тэнгэрээс заяадаг, оролдлогыг багаасаа сурдаг” гэж хуучцуул ярьдаг. Бас “Муу анчин отгийн дарамт” ч гэж ярих нь бий. Ингэхлээр эр хүн гэр орноо тэжээж явах гэвэл тэр ажилдаа хар багаасаа дадах хэрэгтэй. Тийм ээлж Кирискт иржээ. Ер энэ хөвгүүнийг далайд дагуулан явж сургах цаг хэдүйн болсон байлаа.

Үүнийг хүн бүхэн мэднэ. Чухам энэ өдрийн аян бол ирээдүйд сайн анчин болж, гэр орноо тэжээх учиртай Кирискт зориулагдаж буйг Алаг хав толгойн ёроолд орших Загас-эхнэр овгийн бууцны бүх улс мэдэж байв. Энэ отгийн дотор төрсөн эр хүн болгон хар багаасаа тэнгис далайтай анд бололцох ёстой гэж үздэг билээ. Тэгэх юм бол тэнгис далай тэр хүнийгээ мэддэг болж, тэр хүн нь тэнгис далайг хүндлэн үздэг болдог нь ёс. Тийм ч учраас отгийн тэргүүлэгч Орган өвгөн өөрөө хөвгүүний эцэг Эмрайин түүний үеэл дүү Мылгун гэгч хоёр шилдэг анчингаа авч өтгөс өвгөдөөс үр хүүхдийнхээ өмнө, энэ удаа Кириск хөвгүүний өмнө хүлээсэн ариун нандин үүргээ биелүүлэх ёсыг дагаж далайн ан авд гарч байгаа нь энэ. Кириск хүү одоо ч хойшид ч ямагт тэнгис далайтай зангаа авалцан, одоо ч хойшид ч ямагт олзтой, олзгүй ч тэнгис далайд явах ёстой болно.

Кириск хүү одоогоор хүний гараас хараахан гараагүй бяцхан хүү байг, ер нь тэр сайн анчин болох эсэх нь одоогоор хараахан мэдэгдэхгүй байг /болохыг хэн байг гэхэв/ ямар ч гэсэн өвгөцүүл тэнхээ тамир доройтон энэ ажлаас хөндийрөхийн цагт чухам Кириск хүү л

отгийн түшиг тулгуур, тэжээгч нь болно шүү дээ. Үеийн үед ингэж явж ирсэн учиртай. Ер амьдрал ч тийм байдаг.

Гэвч үүнийг ил ярих хүн үгүй. Хүн энэ тухай дотроо бодохоос биш гадагшаа ярих нь үгүй. Иймээс ч Кирииск хүүг анх удаа анд явах гэж буй энэ үйл явдлыг Алаг хав толгойн эрэгт орших Загас-эхнэрийн отгийнхны дотроос хэн ч тоосонгүй. Тэр ч байтугай Кирискийг том улстай далайд явахыг зориуд анзаарахгүй байх гэж хичээж байв. Энэ явдлыг ер онцын юм гэж үзэхгүй байх шиг байв.

Эх нь түүнийг гаргаж өгсөн боловч далайд явна гэж ганц ч үг дуугарсангүй. Далайн булан ч хүргэж өгсөнгүй салж, “За түлээнд яваад ир дээ” гэж зориуд чанга хэлэхдээ хүний урманд далай тийш харсангүй, харин ойн зүг харж, “Сайхан хуурай түлээ олж ирнэ шүү, битгий модонд төөрч орхиорой” гэжээ. Ингэж хэлдэг нь хүүгийнхээ аяны мөрийг баллаж, лус савдгаас төөрүүлж буй хэрэг юм. Бас эцгийн нь талаар ганц ч үг дуугарсангүй. Эмрайн бол түүний эцэг биш, Кирииск хүү эцэгтэйгээ явах гэж байгаа биш, зүгээр санамсаргүй улстай явах гэж байгаа юм шиг байв. Энэ нь мөн л Эмрайн Кирииск хоёр эцэг хүү мөн гэдгийг аанай сайхи лус савдагт мэдэгдэхгүй гэсэн хэрэг. Эцэг хүү хоёр анд мордоход лус савдаг маш дургүй байдаг болой. Эцэг хүү хоёр цуг явах юм бол хэн нэгний хүч зоригийг хугалах гэж, далайд явдаггүй байж, ой модонд явдаггүй байж гэж хэн нэгний амыг бариулах гэж хэн нэгнийг хорлож болно. Ер лус савдаг гэдэг дандаа хүмүүсийг хорлох аян тал харж явдаг ажээ.

Харин Кирииск нялх хүүхэд биш болохоор лус савдгаас үл айна. Гэтэл эх нь учиргүй айж, хүүгийнхээ төлөөнөө ухаан гарна. Чи нас бага, чамайг самууруулж байгаад хорлох нь нэн амархан гэдэг билээ. Энэ ч бас үнэн! Тэрхүү лус савдаг, ад албингууд бага хүүхдэд хичнээн зовлон тарьдаг гэж бодно. Элдвийн өвчин эмгэг хүргэж хорлоно. Хүүхдийг хожим сайн анчин болгохгүй гэж эрэмдэг зэрэмдэг болгож орхино. Тийм хүн хожим хэнд ч хэрэггүй амьтан болж хувирна шүү дээ. Тиймийн тул хүүхдийг ялангуяа бага балчирт нь элдэв лус савдгийн хорлолоос зайлуулж байх нь тун чухал. Хүн хэзээ том болж бие даасан цагт ямар ч лус савдгаас айх явдал огт үгүй болно. Том хүнийг лус савдаг дийлэхгүй, ер бяртай чадалтай хүнээс өөрснөө айдаг болдог гэж бодно.

Эх нь хүүгээ ингэж гаргаж өгөв. Хүүгээ гаргаж өгөөд тийнхүү айж, залбирч, итгэж байгаагаа ч тас нууж баахан дуугай зогсож байгаад гэр рүүгээ явахдаа хүний урманд далайн зүг харсангүй. Эцгий нь тухай ганц ч үг дурдсангүй, ердөө эр нөхөр нь хүүгээ аваад хаашаа явж буйг огт мэдээгүй хүн шиг байв. Уг нь энэн эхнэр тэдний аян замын хүнсийг гурван хоногийн нөөцтэйгээр бэлдэж өгсөн мөртөө одоо болоход юу ч мэдээгүй хүний дүрийг эсгэж байв. Хүүгийнхээ хойноос тийм айхтар санаа зовж байжээ. Тэгж айхтар айж байсан мөртөө айж байгааг нь бас лус савдаг мэдчих вий гэхдээ сэтгэлийнхээ тэр түгшүүрийг огтхон ч ил гаргасангүй харьжээ.

Чингээд эх нь далайн тохой хүрэлгүй харьж, хүү нь лус савдгаас нуугдан зам мөрөө буруулан бутан дундуур сүлжин явав. Эх нь тэгж яваарай гэж захисан тул тийм өдөр эхийн сэтгэлийг хугалахыг огтхон ч хүссэнгүй. Хүү түүнээс хол түрүүнд яваа гурвын хойноос харайлгав.

Тэднийг даруй гүйцэн очив. Цаадуул нь ачаа үүргээ, буу зэвсгээ, аргамж татлагаа үүрээд яаралгүй алхаж байв. Хамгийн тэргүүнд омгийн тэргүүлэгч Орган өвгөн, хойноос нь өндөр нуруутай, өргөн ханхар цээжтэй, бавгар сахалтай Эмрайн алхах нь онц бараатай харагдана. Хойноос нь хожуул шиг тагдгар бөөрөнхий биетэй Мылгун маажигнаж явав. Тэд хүйтэнд дулаан, усанд норохгүй гэж дандаар ангийн арьс савхиар хийсэн хуучин хувцас өмсчээ. Тэдний дэргэд Кирииск нэн ч гоё харагдана. Эх нь далайд явахдаа өмсөг гэж

аль хэдийнээс хувцас зэхэхдээ хармаан ууттай, эргэн тойрон эмжээр хамжлагатай их л гоё хувцас зэхжээ. Далайд явахад түүний хэрэг юу байхав. Гэвч хүний эх бол эх шүү дээ. Кирискийг зэрэгцэн ирэхэд Мылгун

-Хүүе чи юу, чамайг гэртээ үлдсэн гэж бид бодлоо шүү. Ээж чинь хөтлөөд харьчихсан байх гэж бодсон шүү гэж гайхаж дооглосонд,

-Яалаа гэж тэр билээ? Амьд байсан цагт хэзээ ч тэгэхгүй! Энэ чинь би шүү дээ гэж гомдохдоо арай л багтарсангүй.

-За за тоглож байхыг мэдэхгүй юу. Ингэж болохгүй шүү. Далай дээр үг ярилцах гэдэг найз найзтайгаа үг ярихтай огт адилгүй. Май, үүнийг үүрээд явсан чинь дээр байхаа гэж Мылгун ангийнхаа бууг үүрүүлсэнд хөвгүүн их л урамтай баяртай зэрэгцэн явав.

Тэдэнд одоо ачаагаа ачаад л хөдлөх ажил үлдэв.

За тэд ингэж далайд гарав. Харин хэрвээ аз дайрч олз омогтой иргэж ирвэл байдал шал өмнөө болно. Хөвгүүнийг зүй ёсоор хүндэтгэж залуу анчинг угтах баяр болно. Тэнгис далайн өгөөмөр баялгийг дуулах болно. Тэнгис далайн хязгааргүй гүнд зоригтой, бярайтууд баригдах тавилантай загас жараахай, ан амьтан зөндөөн! Тэр дуундаа омгийн элэнц хуланц болох Загас-эхнэрийг өргөн дуулах болно. Тэрхүү элэнц хуланцаас газар дэлхий дээр Загас-эхнэрийн удам судар бий болсон болохоор аргагүй! Тэгээд хэц хэнгэрэг нижигнэн олон бөө бууж тэдний дотроос хамгийн их ухаантай нь Газар, Усыг дуудан, Кириск гэгч нэгэн шинэ анчин бий болсныг даатгах болно. Энэ хөвгүүнд газар дэлхий ямагт өгөөжтэй байгаарай, энэ хүүг их том анчин болгож өсгөж үзээрэй, энэ хөвгүүн Газар, Усны аль алинд их олз омогтой яваг, олз омгоо их бага улсад адил тэгш хуваадаг сайн чанарыг соёрхон хайрла гэж мөргөн гуйх болно. Кириск хөвгүүнд олон үр хүүхэд заяаж, тэд нь цөм өсөж, агуу их Загас-эхнэрийн омог нь удмаас удамд улам өнөр өтгөн болог гэж мөргөн гуйх болно. Их найран дээр улс бүжиг наадам хийж,

Агуу их Загас-эхнэр чи хаана хөвнөм?

Чиний халуун хэвлийд амьдрал үүсмүй

Чиний халуун хэвлийгээс бид тэнгисийн хөвөөнд төрсөн билээ

Чиний халуун хэвлийгээс сайхан газар энэ хорвоод байхгүй

Агуу их Загас-эхнэр чи хаана хөвнөм?

Чиний цагахан хөх хав загасны толгой лугаа адилхан

Чиний цагахан хөх биднийг тэнгисийн хөвөөнөө тэжээсэн

Агуу их Загас-эхнэр чи хаана хөвнөм?

Хамгийн чийрэг эр чам руу хөвж явнам

Халуун хэвлий чинь дэлгэрэх болтугай

Хамаг омог чинь өнөр өтгөн болтугай.

Гэж дуулах болно. Тэрхүү баяр дээр Кирискийн хувьд бас нэг чухал үйл болно. Юу гэвэл бөө буухдаа тэнгэрийн оддын нэгийг залуу анчингийн хувь заяаны од гэж зааж өгөх болно. Анчин бүрд өөрийн нэг бие хамгаалагч од байдаг. Харин Кирискийн хувь заяаны од ямар од болохыг хэн ч мэдэхгүй. Үүнийг гагцхүү өнөө бөө, өнөө түүний амь насыг далд хамгаалагч заяаны нь од хоёр л мэднэ. Ондоо хэн ч мэдэхгүй. Тэгвэл тэнгэрт од олон...

Мэдээжийн хэрэг ээж охин дүү хоёр нь бүхнээс илүү баярлан, бүхнээс чанга дуулж бүжих болно. Эцэг Эмрайн нь ч хотол олны өмнө ёстой эцэг гэгдэж, туйлаас баярлан бахдах болно. Эмрайн яагаад хүний эцэг биш байх билээ. Далайд явахад эцэг хүү гэж байхгүй, далайд хүн бүхэн адил тэгш байж гагцхүү ахлагчдаа захирагдана. Ахлагч нь юу

гэвэл түүнийг дагах ёстой. Эцэг гээд хүүгийн хэрэгт оролцож болохгүй, хүү нь гээд эцэгтээ гомдол санал тавих ёс байхгүй. Ер тийм байдаг болой.

Бас хар багаасаа тоглон наадаж өссөн Музлук охин ч ихэд баярлах болно. Тэд нийлж наадах нь энэ хэр бага болжээ. Одоо бол Кириск анчин болсноос хойш юун түүнтэй наадаж тоглох...

* * *

Анчдын гуя онгоц далайн давалгаанд үл мэдэг намалзан их л зохистой хөвж байв. Тэд мөнөөхөн алаг хав толгойг хэдийн ардаа орхин, Уртын хошууг өнгөрч, задгай тэнгист гарч ирвэл далайн давалгаан тэнгисийн булангийнхыг бодвол тиймчиг хүчтэй биш, нэгэн жигд намалзана. Тийм тогтвортой давалгаанд хурдан сэлж болно.

Учиргүй бүдүүн улиас төнхөж хийсэн гуя онгоц их л хичээнгүй хөвнө. Эгц долгионд ч хөндлөн долгионд ч маш дуулгавартай, найдвартай хөвж байв.

Орган өвгөн хэдийн унтарсан гансаа сорон сорон явахдаа түүний гуя онгоц тийнхүү бат найдвартай хөвж явахад сэтгэл дүүрэн агаад өөрийн биеэр завь болоод хагас дундуур усанд дүрэгдэн тэнгисийн хүйтэн усыг зүсэн явсан шиг сэлүүрийн нэгэн жигд хяхнах болхи дууны дор тэнгисийн уудмын дээгүүр өөрөө хөвж явсан шиг, үелзэн ирэх уян долгионыг цээжээрээ зүсэж, өөрийн биеэр үл мэдэг найгалзан хөвж явсан шиг сэтгэлд нэн зохистой явлаа. Энэ бодол нь завийн урагш тэмүүлэх хөдөлгөөнтэй нийлж урьдын нь явдлыг эрхбиш санагдуулна. Тэр гуя онгоцыг өөрөө цавчиж, өөрөө төнхөж хийсэн болохоор сэтгэл даанч тэнэгэр явав. Нэг хүн байтугай дөрвөн хүн ч дийлмээргүй бүдүүн гэгчийн улиас олуул хамжин унагаж, гурван жил хатаагаад цавчаад үзсэн чинь, ай даа насандаа олон гуя онгоц хийсний нь дотор хамгийн сайн онгоц болох шинж даруй мэдэгдсэн байжээ. Гэвч тэр тухай бодож байтал энэ онгоц миний амьдралын сүүлчийн онгоц байвал юу болно гэж эрхбиш сэтгэл гуниж иржээ. Бас нэг хэдэн жил амьд явах юмсан. Тэнгисийн авд бас нэг хэд явах юмсан. Нүдний хараа болиогүй, ухаан санаа буураагүй дээрээ бас хоёр нэг гуя онгоц төнхөх юмсан гэж бодогдоно.

Ингэж бодтол мөнөөхөн гуя онгоцтойгоо сэтгэлдээ үг ярилцах болдог байгаа. “Миний хайртай Каяк минь ээ би чамдаа хайртай, чамдаа итгэдэг шүү. Чи бол далайн хэл мэднэ, чи бол давалгааны аашийг мэднэ, үүнд л чиний чадал байгаа юм. Чи бол хоёр эр нэг эм хав загасны мах багтдаг том онгоц шүү. Чи бол маньд их олз омог олж өгдөг болохоор би чамайг ихэд хүндэтгэдэг юмаа! Чи бидний агнасан олзыг дааж ядталаа ачаад хагас дундуур ус утгаж, ирмэгтээ хүртэл цайчихаад агнуураас буцаж ирэхэд чинь бид их хайрладаг шүү. Тэгэхэд хүн бүхэн чамайг тосох гэж далайн хөвөөнд гүйж ирдэг.

Хэрэв намайг үхэх юм бол чи олон жил байж, ан гөрөө аль элбэгтэй хол газар явж байгаарай. Хэрэв намайг үхэх юм бол залуу чийрэг анчингуудтай явж байгаарай. Хэрэв би үхэх юм бол чи надад зүтгэсэн шигээ бусдад зүтгээрэй. Чи энэ завины хошуун дээр суугаад ийш тийш тэсгэлгүй харан яваа манай удмын энэ хүүг эрийн цээнд хүртэл хүлээж үзээрэй. Энэ хүү ан агнах гэж тэсэж ядан явна. Хэрэв усанд биш хуурай газар явсан бол энэ хүү даруйхан ангийн хойноос гүйнэ дээ. Ганцаараа ч чадах бололтой. Энэ хүү өсөж, хол ойрын авд чамтай явах цагийг хүлээж үзээрэй. Өнөөдрийн хувьд бол энэ хүү анх удаа бидэнтэй далайд гарч үзэж яваа юм. Далайд явж сураг. Бид үхээд өгөхөөр энэ хүү олон жил амьд явах болно. Эцэг Эмрайн шигээ болоод ирвэл их л овсгоотой хүн болно доо. Эмрайн бол одоогийн улсын дотор хамгийн сайн анчин юм. Хоосон чалчдаг хүн биш.

Алсын бодолтой чанга хүү шүү. Би ч гэсэн идэр залуудаа ийм л эр явлаа. Ид бяр амтагдаж явлаа. Тэгэхэд эхнэр хүүхнүүд надад дурладаг байлаа. Тэгэхэд би тэр чигээрээ л явах юм бодож явжээ. Юм тэр чигээрээ байдаггүй гэж хожим л мэдсэн дээ. Жишээ нь энэ Эмрайн, Мылгун хоёр одоо ч тэгж бодож яваа биз. Гэвч яахав дээ, юм мэдэх болноо гайгүй. Эд их л даацтай сайн сэлүүрддэг улс. Мылгун бол Эмраинтай ёстой таарах хүн шүү. Хатуужилтай, найдвартай эрчүүл юм. Одоо үзвэл гуя онгоц маань өөрөө л хөвөөд байгаа юм шиг санагдана. Гэвч тийм биш. Далайд явна гэдэг гараараа явна гэсэн үг. Сэлүүрдээд л байна, сэлүүрдээд л байна, барагдах гэж ер үгүй. Жишээ нь өнөөдөр харанхуй болтол сэлүүрдэж байж Гурван мээм гэдэг аралд сая хүрнэ. Маргааш буцаад өдөржин сэлүүрдэх болно. Өглөөнөөс аваад өдөржин сэлүүрдэнэ. Би хэн хэний нь гарыг жаахан амрааж л явна л даа гэхдээ бүхэл бүтэн далайг сэлүүрдэж туулна гэдэг тиймчиг амар ажил биш. Гэвч харин маргааш олз омогтой харивал найр наадам болно.

Хайртай Каяк минь ээ, чи миний үгийг дуулж байна уу, миний үгийг ойлгож байна уу? Чи биднийг өнөө их ан оршдог Гурван мээмийн арал хүргэх болно. Бид чинь тэнд л хүрэх гэж хөвч явна шүү дээ. Тэндхийн эрэг дээр л бид хав загас олж үзэх болно. Удахгүй тэдний зулзаглах цаг, өдийд сүргээрээ цугласан байгаа.

Сайхан Каяк минь ээ, чи миний хэлийг ойлгож байна уу? Чи миний үгийг ойлгох л ёстой доо. Чамайг далай гэдгийг үзээгүй, чамайг ойд нэг том улиасны хэвлийд байхаас би чамтай үг ярьж эхэлсэн юм шүү. Чамайг би модны хэвлийгээс суллан гаргаад одоо хөвж явна.

Намайг дугжирвал намайгаа бүү мартаарай. Далайгаар хөвөх болгондоо намайгаа санаж яваарай..”

Орган өвгөн тэнгисийн хөвөөний гол тэмдэг болох Алаг хав толгойн тэндээс гарснаас хойш ингэж бодож явав. Тэр хавцал толгойд нэг ер бусын чанар байдаг. Гийм ч учраас тунгалаг нартай өдөр эргээс холдох тусам Алаг хав толгой улам ургаад байдаг гэж далайд явсан улс бүхэн ярилцах нь бий. Алаг хав толгой үнэхээр хоцрохыг үл түвдэн, хойноос дагаад байгаа юм шиг санагдана. Тэгэхлээр эргэн харахгүй байхын аргагүй. Чингээд эргэн харахад Алаг хав толгой харагдаж л байна. Их хол явтал харагдана. Тэгснээ усны эргүүлэг ойлд орсон мэт гэнэт үзэгдэхгүй болно. Энэ бол өнөө Алаг хав гэртээ буцсан хэрэг, өөрөөр хэлбэл эрэг газар ард хол хоцорсон гэсэн үг.

Тэгэхлээр Алаг хав толгой аль зүгт хоцров гэдгийг тун сайн тогтоож авах хэрэгтэй. Салхины чигийг тогтоох хэрэгтэй. Нар тэр толгойн чухам хаахна байсныг тогтоох хэрэгтэй. Тэгээд л тэнгис далайд төөрөхгүйн тулд өнөө арлыг хүрэн хүртлээ Алаг хав толгой чухам аль зүгт байдгийг дотроо үргэлж санаж явах хэрэгтэй.

Анчид бараг өдөржингийн газар орших өнөө гурван арлыг чиглэн явав. Тэр арал гэдэг нь хязгаар хярхаггүй их усан дунд цухуйж тогтсон хад асга бүхий гурван жижигхэн бараан газар юм. Эл учир түүнийг Их мээм, Дунд мээм, Бага мээм гэж нэрлэжээ. Түүнээс цааш явах юм бол ёстой гадаад их далайд орно. Түүнд хэмжээ хязгаар гэж байдаг эсэхийг тэд үл мэднэ. Нэрий нь ч үл мэднэ. Тэр бол дэлхий ертөнц тогтохоос өмнийн, өнөө Лувр гэдэг нугас үүр засах алгын чинээ газар эрж энэ нартад тийм өчүүхэн газар эс олохоос өмнийн өөрөө үүсэн тогтсон хязгаар хярхаггүй, хүн амьтан явдаггүй асар их ус. Харин өнөө тэнгис далай хоёрын зааг болох гурван арал дээр хаврын энэ өдрүүдэд хав загас эрэг дээр гарч наранд ээж хэвтэцгээдэг болой. Эд гагцхүү түүний төлөө тэр арал руу явж байгаа нь тэр...

Гэтэл тэнгис гэдэг өнөө жаал хүүгийн Алаг хав толгойн эгц эрэг дээр наадаж байхдаа бодож байснаас шал өмнөө юм байв. Нөгөө далайн булан тохойд завиар зугаалан явж

байсантай нь ч адил төсөөтэй юм алга. Ялангуяа тэнгисийн булангаас гартал гэнэт тэртээ тэнгэрийн зах хүртэл ямар ч хуваарь хязгааргүй их ус цэлийн гарч ирэхэд бүр ч гайхах сэтгэл төржээ.

Кириск тэнгис гэдгийг үзээд үнэхээр хирдхийн цочив. Тэнгис гэдэг тийм юм байдаг гэж үнэндээ бодсонгүй явжээ. Одоо үзвэл тэнгис гэдэг зөвхөн ус, мяралзсан их ус, зөвхөн үелзэн замхрах их долгион, зөвхөн сэтгэл түгшим харанхуй хар гүнзгий ус ажээ. Түүний дээгүүр зөвхөн хүршгүй хөнгөхөн цагаан үүлс тэнгэрт нүүж явах нь үзэгдэнэ. Задгай тэнгист тэр их уснаас ондоо тэр их тэнгис далайгаас ондоо юм огтхон ч үгүй. Тэнд өвөл ч байхгүй, зун ч байхгүй, дов толгод ч байхгүй, гуу жалга ч байхгүй ажээ.

Дэлхий ертөнцийг нэг захаас нь аваад нөгөө захыг хүртэл дан ус бүрхжээ.

Гэвч гуя онгоц долгионы дээгүүр намалзан хөвсөөр л байв. Жаал хүү тэр гуя онгоцонд суугаад их анд сэтгэл яаран явахдаа мөн ч үзэх харах юмтай, баяртай хөөртэй явав. Жаал хүү эргэн тойрон усан дээр, усан дотор буйг харж ажиглан явавч энэ удаа баяр наадамд явж байсан шиг хөөрөөд анхаарал дундуур, тэр бүрийг хальт хальт сонирхон явав. Учир нь жаал хүү ондоо нэг юм болно гэж сэтгэл маш яаран явав. Тэрнээс биш ондоо цагаар явсан бол усны мандал дээр нарын түг түмэн туяа наадан, усны өнгө нэгэн үе үл мэдэг ягаавтар, нэгэн үе хар ногоон болж, завины ёроолоор бүр гүн харанхуй хар болж, үзэгдэхийг сонирхон явах байсан биз. Завины ёроолоор санамсаргүй бужигнах хачин сониуч загас жараахайг үзэхдээ нэн ч баярлан хөхих байсан биз. Үй олноороо сүрэглэн явах тэрхүү олон загас онгоцтой тааралдаад сандран тарж алга болохын оронд улам олноор нягтран бөөгнөж уснаас дээш цовхрон гарч агаарт хийлэн нуруугаар буцан унаж байхыг үзэхдээ учиргүй инээх байсан биз.

Гэтэл тэр бүхнийг онц эс анхаарна. Ер дэмий юм шиг санагдах ажгуу. Гагцхүү өнөө аралдаа бушуухан хүрэх юмсан, ав авлах ажилдаа бушуухан орох юмсан гэж тэсгэлгүй бодож явлаа.

Гэвч хүүгийн сэтгэл санаа гэнэт хар аяндаа нэг л хачин болоод иржээ. Үүнийгээ ил гаргасан ч үгүй. Юу гэвэл, эргээс улам холдож, ялангуяа өнөө Алаг хав гэнэт үзэгдэхгүй болж тэнгисийн гүвгэр хар нурууны цаана далд орсноос хойш тэнгис далай гэдэг нэг л аюултай осолтой юм шиг бодогдож, тэнгисийн эрхшээлд ороод, байгалийн энэ аварга үзэгдлийн өмнө даанч өчүүхэн даанч арчаагүй юм шиг санагдаж иржээ.

Энэ бодол түүний хувьд анх төрөв. Алаг хав толгой гэдэг хичнээн эрхэм уул болохыг жаал хүү сая ойлгов. Урьд нь түүнийг бодож байсан удаа үгүй. Алаг хавын байц хавцлын дээгүүр аймшиггүй дүүлэн дамжиж явахдаа тэр өндөр дээрээс тэнгисийг харахад тэнгис далай гэдэг ямар ч аймшиггүй юм шиг харагддаг билээ. Тэгвэл Алаг хав толгой газар дээр бат бөх зогссон, ямар хүчирхэг, ямар сайхан уул байсныг сая ойлгов.

Газар тэнгис хоёр ямар ялгаатайг жаал хүү одоо сайн ойлгов. Газар дээр явахад газрын тухай бодогддоггүй. Тэгвэл тэнгис далайд явахад ондоо юм бодож байсан ч ялгаагүй үргэлж тэнгис бодогдоно. Энэ шинэ бодол нь жаал хүүгийн сэтгэлийг баахан зовоох болов. Тэнгис далайд түүний тухай арга буюу юм бодуулахад хүргэдэг нэг үл үзэгдэх шургуу, эзэрхэг ноёрхог юм байх шиг санагдав...

Гэтэл томцуул нь их л тайван явна. Эмрайин, Мылгун хоёр нэг хүн адил жигдхэн хөдөлж завийг сэлүүрдэн явна. Дөрвөн сэлүүр ч уснаа нэгэн зэрэг буух агаад их л хөнгөн чөлөөтэй татаж байх шиг санагдана. Гэвч завь сэлүүрдэх гэдэг үргэлжийн бяраа чадал заана гэсэн үг. Сэлүүрчид буруу хараад суусан болохоор Кириск тэдний нүүрийг олж эс харавч тэдний дал мөр нэгэн үе оволзон нэгэн үе бууж байхыг харж байв. Тэд хааяа ганц нэг үг

ярилцана. Харин хүүгийн эцэг заримдаа эргэн харж, “За ямар байна? гэж асууж байсан шиг сахал дороо жуумалзан инээмсэглэнэ.

Тэд тийнхүү хөвсөөр л байв. Томчуул нь их л тайван, их л итгэл дүүрэн явав. Орган өвгөн бол огтоос бухимддаггүй хүн. Модон гаансаа сорон сорон завиа залж явав. Хүн болгон өөрийн ажил явдлаар оролдоно. Кириск хүү заримдаа Мылгунтай, заримдаа эцэгтэйгээ хос болж ганц нэг удаа сэлүүрдэж явав. Тэдний хэн нэг нь өрөөсөн сэлүүрээ дуртайяа өгнө. Яхав ажил хийж л байг. гэвч жаал хүү хэдийгээр хоёр гараараа татавч тиймчиг удаан сэлүүр дээр сууж эс чадна. Уул завь онгоц түүний хувьд арай хэтэрхий хүнд, сэлүүр нь арай томдоод байв. Гэвч хүүг хэн ч зэмлэх нь үгүй, өрөвдөх нь үгүй, дуугай л өөрсдийн ажлаар ороодон явна...

Гэтэл Алаг хав далд ормогц тэд яагаад ч юм сэргэж,

- Алаг хав минь гэртээ харьчив шив! Гэж хүүгийн эцэг өгүүлэхэд Мылгун
- Нээрэн харьчихлаа шүү! гэж батлан хэлэв.
- Нээрэн үү? Тэгвэл харьчиж л дээ гэж Орган өвгөн тэр зүгт эргэн харж – нэгэнт тийм бол бидний явдал бүтэмжтэй явна гэсэн үг. Хүүе Кириск! Гэж хүүгийн зүг их баяртай урамтай харж, - Чи алаг хаваа дуудах юм биш үү, эргээд ирж юунай магад гэв.

Тэд инээлдэв. Кириск ч инээв. Чингэснээ хүү бодож,

- Тэгвэл одоо буцаад явъя л даа. тэгвэл Алаг хав маань гараад л ирнэ гэж чанга хэллээ. Орган өвгөн мушилзан инээж,
- Хүүш чи чинь яасан яаруу юм. Алив ажлаа бодоцгоовол дээр байх аа! гэв. Алив чи наашаа мөлхөөд ир. Ус харж суугаад яах юм. тэнгис далайг хараад хараад гүйцэхгүй шүү гэв.

Кириск завины хошуун дээрээс босож онгоцны ёроолд хэвтээ бугын арьсанд ороолттой хоёр ангийн буу, төмөр жад, эвхээстэй олс, усны жижиг торх, хүүдийтэй хүнс, бас бус боодолтой юм, хувцас хунар тэргүүтэн дээгүүр алхан, онгоцны хэдгэ тийш дөхөв. Сэлүүрчдийн хажуугаар чихэлдэн сэлүүрийн дээгүүр алхан гартал тэдний нойтон хүзүү, нуруунаас чийрэг эрсээс ханхалдаг хөлс, тамхины үнэр ханхална. Тэр бол эхийн нь үнэрлэх дуртай эцгийн нь хувцаснаас ханхалдаг үнэр байв. Эцгийг нь далайд явахад эх нь түүний хуучин муу арьсан дээлийг аваад нүүрэндээ аваачиж үнэрлэн суудаг билээ.

Эцэг нь хүүдээ толгой дохин мөрөөрөө ялигүй нудраад авсан боловч сэлүүрээ тавьсангүй. гэвч Кириск эцгийнхээ тийнхүү эрхлүүлж байхад огтхон ч тоосонгүй. Бас яах нь вэ дээ! Далайд явахад эцэг ч гэх юмгүй хүү ч гэх юмгүй. Далайд явахад зөвхөн ахлагч байна. Түүний захиргаагүйгээр хуруугаа ч хөдөлгөж болохгүй.

Орган өвгөн болхи, урт гараа хүүгийн мөрөн дээр тавьж,

- Энд наашаа суу. Чи ингэхэд айж яваагүй биз? Анхандаа дажгүй юм шиг байгаад сүүлдээ... гэхэд нь Кирискийн царай улайв. Энэ бол түүний жаахан мятарч явааг Орган гадарлав гэсэн үг юм. гэвч Кириск
- Аتكычх аа, ер зүрх алдсан юм үгүй. Би юунаас айх юм гэв.
- Тэнгис далайд анх удаа явж үзэж байгаа юм чинь
- Анх удаа л биз, тэгээд юу гэж?! Би юунаас ч айхгүй байна.
- Тэгвэл яхав. Би бол тээр жил анх далайд гарахдаа үнэнийг хэлэхэд учиргүй айсан юм даа. нэг харахнаа тэнгсийн эрэг хэдийн далд ороод өнөө Алаг хав минь ч гүйгээд явчиж. Эргэн тойрон харвал зөвхөн далайн давлагаа Гэртээ буцмаар санагдаж байв шүү. Эдэнд анх ямар байсныг эн Эмрайн, Мылгун хоёроос асуу л даа...

Цаад хоёр учрыг мэдэн инээмсэглэж толгой дохин сэлүүрийн дээр тонгойв. Кириск нэгэнт хэлснээрээ зүтгэж

- Тэгвэл би айхгүй байна гэв.
- Тийм бол их сайн хэрэг гэж өвгөн өнөө хөвгүүний санааг амруулан –“ За тэгвэл Алаг хав аль зүгт үлдсэн бэ? Чи хэл л дээ гэв.

Тийм асуултанд санаандгүй тулгарсан Кириск бодож

- Тээ тэнд! Гэж гараар заав.
- Лав уу? Гар чинь чичирч байна уу даа?

Кириск гараа чичрүүлэхгүйг хичээн арай баруугаар

- Тээ тэнд! Гэв.
- Одоо яг зөв дөө! Манай завины хошуу энэ зүг эргэвэл Алаг хав хаана байхав?
- Тээ тэнд?
- Хэрэв бид зүүн тийшээ эргээд явбал?
- Тээ тэнд байна!
- Сайн байна. Эргэн тойрон юу ч үзэгдэхгүй, эргэн тойрон дан ус байхад чи яаж мэдэж байна! Тайлбарлаж чадах уу?
- Надад бас нэг ондоо нүд бий гэж Кириск хэлэв.
- Ямар нүд?
- Ямрыг мэдэхгүй юм, миний гэдсэн дотор байдаг болов уу, юмыг харалгүй хараад байдаг юм.
- Гэдсэн дотор гэнээ?! гэж цөм инээлдэв.
- Тэр ч үнэн шүү. Тийм нүд байдаг. Гагцхүү гэдсэн дотор биш, толгой дотор байдаг юм гэж өвгөн хэлэв.

Тийм хардаг нүд байвал толгой дотор л байж болно гэж Кириск бодсон боловч өөрийн хэлснээр зүтгэн

- Минийх л гэдсэндээ байдаг юм гэв.

Нэг хэдий болсон хойно өвгөн өнөө хүүг дахин шалгаж задгай тэнгист зүг тогтоох чадвартайг нь олж мэдээд сэтгэл дүүрэн болж,

- Чиний гэдсэнд байдаг нүд чинь муугүй нүд байна гэж амандаа үглэв.

Тийнхүү магтуулж баяссан Кириск өөрөө өөрийгөө шалгаж өөрөө хариулж явав. Тэнгис далай тийм харьцангуй тайван байгаа цагт энэ бол тиймчиг бэрх юм биш. Өнөө үнэнч агуу Алаг хав нь онцын түвэггүй сэтгэлд бууж, өнөө л үлдэж хоцорсон яг тэр чигт нүдэнд нь илхэн харагдж байв. Толгойн хоёр хажуугаар сэгсийтэл ургасан ой мод, “толгой” дээр нь “цавинд” нь тогтсон цасан толбо тэр чигээрээ нүдээр үзсэн юм шиг сэтгэлд нь ургаж байв. Өнөө тэнгисийн эргийн эцэж цуцахыг үл мэдэгч их давалгаа хавцлын ёроолыг балбаж байгаа нь сэтгэлд харагдаж байв. Жаал хүү Алаг хавыгаа бодтол түүний эргэн тойрон байдаг толгодын дунд орших бяцхан хөндий, тэр хөндийд ойн цоорхойн захад горхийн дэргэд оршдог бууц нүдэнд нь илхэн харагдав. Тэнд байдаг огтолсон мод, бүхээг, нохой, тахиа загас хатаадаг дүүжлүүр, айлын утаа хүртэл цөм харагдаж хүн ярилцах нь сонсдох шиг болов. Тэнд ээж нь бий, тэнд охин дүү Псулк нь бий. Тэд одоо юу хийж байгаа бол гэсэн бодол хүүгийн сэтгэлд гялсхийн оров. Эх нь дотроо хүүгээ, эцгий нь өнөө далайд явсан анчингуудыг цөмийг бодож байлгүй яхав. Тэднийгээ одоо лав бодож байгаа даа. Бодож байгаа мөртөө өнөө ад албингууд бодлыг нь мэдчих вий, айж байгааг нь харчих вий гэж тун айж байгаа даа. Кириск хүүг нодоо хэн бодож байгаа бол, Лав л Музлук бодож байгаа. Музлук охин Псулк дүүтэй нь тоглох нэрийдлээр манайд гүйж очсон биз. Далайд явсан хүүгийн нь талаар санаандгүй үг

дуугарах юм уу юм асууж орхивол ээж нь уурлаж загнаж болно. “Чи юу гэж дэмий үг ярина, цаадхи чинь ойд түлээнд явсныг чи мэдэхгүй гэж үү?” гэж лав аашлах болно доо. Ингэж бодтол Кириск хүү, Музлук охиныг өрөвдөх сэтгэл төрөв. Музлук охин намайг бодоосой гэж хүсэвч түүний төлөөнөөс хүнд битгий аашлуулаасай гэж онц бодож байв.

Завь давалгааны дээгүүр үл мэдэг намалзан хөвсөөр байв. Эргэн тойрон өнөө л энгүй тэнгис, өнөө л давалгаа үл мэдэг буцлан гялтагнана. Нивх омгийн анчид үдээс хойхон, их оройдоо нар жаргахаас өмнө түрүүчийн арал (салхи гурван арлын хамгийн ойрын Бага мээм) хүрч болбол ганц нэг ан эргүүлэх бодолтой явав. Дараа нь гэгээ тасрахаас өмнө дунд мээм хүрч хонох хэрэгтэй. Тэр аралын хөвөөнд завь уяж хоноход тохиромжтой дөлгөөн газар бий. Тэгээд өглөө эрт дахин далайдаа гарах хэрэгтэй болно. Харин хэрвээ үдэш нь аз таарч тэндээс гурвын зэрэг хав загас унагавал өглөө нь буцах замдаа ум хумгүй орж болно. Ер ямар ч байлаа гэсэн үдээс өмнө нар хоёр улиас хэртэй өндөр хөөрөхөөс өмнө тэндээс буцах хэрэгтэй. Тэнгисээс хэдийчинээ эрт гарвал төдийчинээн сайн байдаг.

Энэ бүхнийг Орган өвгөн урьдаас бодсон байв. Энэ хүн бол юм бүхэн дээр өөрийн тооцоотой явна. Өвгөний туслагч Эмрайн, Мылгун хоёр ч гэсэн Гурван мээмийн аралд анх удаа хүрч байгаа улс биш. Юмны учир холбогдлыг тэр хоёр тун сайн мэднэ. Гол нь тэнгэр сайхан байхад хав загасны хэвтэр газар хүрэх хэрэгтэй. Энэ бол хамгийн чухал, хүн болгон дор бүрнээ ажлаа мэдэх тул бусад нь яахав болно.

Орган өвгөн далайд явахдаа зайлшгүй гачигдалтай болоод (тэнгисээс хоол олж идэхгүй бол амьд явахгүй) зөвхөн явдаг хүн биш, бас далайд явж байх дуртайдаа явдаг хүн. Тэнгист алс гараад их л нандин юмаа бодож явна. Түүнд өөрийн бодож явдаг нандин юм бий. Тэнгист юм бодоход саад болох юм огт үгүй. Учир юу гэвэл хуурай газар дээр өдөр тутмын ажлаар хөөцөлдөн явахдаа юм бодох зав ямар ч хүнд гардаггүй. Далайд бол гарна. Тэр их нандин юмаа дотроо бодож явахад нь Орган өвгөнд саад болох юм тэнд нэгээхэн бээр үгүй, Орган бол тэнгист явахдаа өөрийгөө далайтай ч, тэнгэртэй ч садан гэж бодно.

Хязгааргүй их далайд завьтай ганц хүн юу ч биш өчүүхэн юм гэж өвгөн мэднэ. Гэвч хүн сэтгэж чадна. Түүгээрээ сүрлэг их Тэнгис, сүрлэг их Тэнгэрийн өөдөөс ч явж чадна. Түүгээрээ байгалийн түмэн энхэл донхлын өмнө өөрийгөө батлан чадна. Хүн бол далайн гүн, тэнгэрийн өндөртэй ав адил юм. Тийм учраас хүн амьд яваа цагтаа сэтгэлээр тэнгис шиг хүчирхэг, тэнгэр шиг уужим явдаг. Яагаад гэвэл хүний санаа бодолд хязгаар гэж байдаггүй. Хэрэв нэг хүн үхэхэд ондоо хүн түүний бодлыг цааш нь үргэлжлүүлэн сэтгэнэ. Дараачийн хүн цааш нь сэтгэнэ, ингээд үзэхэд бодолд хязгаар байхгүй... Өвгөн ингэж ухамсарлахдаа эвлэрэх, үл эвлэрэхийн гашуун жаргалыг эдлэх бөлгөө.

Үхэл гэдэг зайлшгүй, өөрөө хөгшин хонины насгүй болсныгоо Орган ойлгодог байв. Хүн үхэхээр юм бүхэн төгсгөл болдог гэж тэр ойлгодог. Гэтэл бас яагаад ч юм, түүний хамгийн ариун нандин зүйл болоа өнөө Загас-эхнэрийн тухай зүүд нь үхсэн хойно нь ч хамт байх болов уу гэж горилно. Өвгөн зүүдээ бусдад дамжуулж үл чадна. Зүүд дамжих гэж байхгүй. Эл учир түүний зүүдэлдэг зүүд ул мөргүй алга болох ёсгүй гэж тэр үзнэ. Агуу их Загас-эхнэр бол мөнхийн юм. тэгэхлээр түүний тухай зүүд мөнх байх ёстой.

Далайд явахдаа ингэж олон дахин боддог байв. Тийм үедээ хамт яваа улстайгаа ганц ч үг ярихгүй, гүн бодолд дарагдан их л удаан сууна. Юу харж буйг бүү мэд, тэнгисийн ус ширтэн явахдаа өнөө агуу их Загас-эхнэрийн тухай зүүдэлдэг зүүдийг нь хамт үлдээхийг мөргөн гуйн явна. Хүн нирваан дүр болоход зүүд нь хамт одож болохгүй

гэж үү? Ингэж бодоод хариу олж чадахгүй болохоороо тэгж болно доо, хүн үхсэн хойноо ч зүүдээ зүүдэлж болно гэж өөртөө итгүүлэхийг оролдох ажгуу.

... Эрт урьдын цагт далайн хөвөөнд Алаг хавын ойролцоо ах дүү гурав суудаг байжээ. Хамгийн их ах нь үсрэхдээ хөнгөхөн, их хурдан, хаана ч юмын түрүүнд хүрч чадна. Бугын омгийн нэг хүний охиныг гэргий болгон авч, олон сүрэг бугатай болоод тунд рүү нүүгээд явчихжээ. Хамгийн бага дүү нь их мэргэн харваач мөрч хүн байжээ. Бас л ойн омгийн нэг хүүхнийг гэргий болгон аваад тайгад нүүж, тэр чигээрээ тайгын их гөрөөчин болжээ. Гэтэл дундхи нь төрөлхийн хазгар, их азгүй хүн байж. Бусдаас эрт босож, бусдаас орой унтавч ямар тус байхав. Буга хариулж гүйцэхгүй, ан гөрөө хийж чадахгүй болохоор тэр хавьд хэн ч охиноо түүнд эхнэр болгон өгсөнгүй. Ах дүү хоёр нь хаячад явчихсан болохоор хөх далайн хөвөөнд ганцаар үлдээд загас гохдож амьдрах боловчиг мэдээжийн хэрэг хэдий загас гохдох билээ.

Хазгар төрсөн хөөрхий зовлонт хүү нэг өдөр завиндаа суугаад далайд очиж хахуулиа усанд тавиад байтал нэг юм хүчтэй чангаах шиг болжээ. Загас баригдав гэж учиргүй баярлан чангаасаар байгаад завиныхаа хажууд аваад иржээ.

Тэгээд харсан чинь яасан хачин юм бэ! Эхнэр хүний дүрд хувилсан загас байжээ! Ус балбан мурилзаж, алдуурахыг хичээж байхыг үзвэл сартай шөнийн голын хайрга шиг гялтагнасан цалин мөнгөн биетэй гацуурын боргоцой адил том товчтой дун цагаахан хөхөтэй, нүднээс нь ногоон гал гялалзсан урьд хожид үзээгүй сайхан эхнэр байжээ. Хазагар хүү тэр Загас эхнэрийг уснаас татан гаргаж шүүрэн автал цаадхи нь урдаас нь тэврээд авчээ. Чингээд хоёулаа завины ёроолд хэвтэн жаргав гэнээ. Хазгар хүү тийм жаргалыг эдлэн эдлэн элий балай болов. Юу болж байгаагаа мэдсэнгшгүй, нэг мэдэхэд завь нь тэнгэрт хүртэл, тэнгэр тэнгист хүртэл савлан найгаж байж дээ. Тэгж байтал далайн шуурга намдсан адил нам жим болж, өнөө Загса-эхнэр завинаас үсрэн буугаад адлайдаа хөвөөд явчихжээ. Хазгар хүү хойноос нь ухасхийн дуудаж, буцаж ирэхийг мөрнөг мөргөн гуйфсан боловч цаадхи нь далай гүнд шумбан алга болжээ.

Далайн хөвөөнд орь ганцаар орхигдсон өнөө хазгар хүүд нэг ийм явдал тохиолдож л дээ. Загас-эхнэр түүнээс хойш хэзээ ч дахин гарч ирсэнгүй, хөөрхий хазгар хүү тэр өдрөөс хойш ихэд гуниг уйтгарлаж, өдөр шөнөгүй далайн хөвөөгөөр уйлан хайлан явж Загас-эхнэр минь холоос ч гэсэн нэг харагдаач! Гэж мөргөн мөргөн гуйдаг болж

ДАЛАЙН УС НЭМЭГДСЭН Ч ТҮҮГЭЭР ЯВЖ

Агуу их Загас-эхнэр чи хаана хөвнөм

Гэж дуулж

ДАЛАЙН УС ТАТАРСАН Ч ТҮҮГЭЭР ЯВЖ

Агуу их Загас-эхнэр чи хаана хөвнөм

гэж дуулж,

САРТАЙ ШӨНӨ БАЙСАН Ч ТҮҮГЭЭР ЯВЖ

Тэнгис гэдэг миний гуниг юм

Ус гэдэг миний нулимс юм

Гэж дуулж,

ХАРАНХУЙ ШӨНӨ БАЙСАН Ч ТҮҮГЭЭР ЯВЖ

Ая, газар болоод миний толгой адилхан

Агуу их Загас-эхнэр чи хаана хөвнөм?

Гэж дуулж явдаг болжээ.

Далайн ус нэмэгдсэн ч явж дуулж, далайн ус татарсан ч явж дуулж байдаг болж гэнэ.

Нэг өвөл өнгөрч гэнэ, нэг хавар өнгөрч гэнэ. Зуны нэг өдөр өнөө хазгар төрсөн зовлонт хүү өвдөг татам давлагаан дунд далайн хөвөөгөөр явж, Загас-эхнэр гэнэт хүрээд ирдэг болов уу гэж далай руу ширтэн, Загас-эхнэр гэнэт намайг дуудах болов уу гэж дуулан дуудаж явтал гэнэт эргийн нэгэн харгианд нялх хүүхэд орилж чарлаж байх шиг. Тийш гүйж очвол яг далайн хөвөөнд нэгэн нялх хүүхэд суугаад уйлж байхад Далайн давалгаа нэгэн үе дээгүүр нь хальж, нэгэн үе буцаж явахыг үзээд нүдэндээ ч итгэсэнгүй. Гэтэл тэр нялх хүүхэд “Хэн миний эцэг вэ? Миний эцэг хаана байна?!” гэж чанга чанга бахирч байхад бүр ч гайхаж хоцроод хөөрхий яах ч арга ухаанаа олохгүй байтал өнөө нялх хүү түүнийг харж, “Чи миний эцэг мөн. Би чиний хүү мөн, намайг гэртээ аваач гэжээ.

Ийм нэгэн жигтэй явдал болж гэнээ! Хүн өөрийн хүүг олж гэртээ аваачиж!

Нэг мэдэхэд хүү өсөж, далайгаар аялдаг болж, Эрэмгий зоригтой лут анчин болж дээ. Ер өөш дүүрэн загас барьдаг сум тоолон гөрөөс намнадаг нэн ч азтай төрсөн хүү гэнэ. Удалгүй хүүгийн алдар ой тайгаа уулнаас цааш нутагт цуурайтаж ойн омгийн хэн нэгэн охиноо түүнд дуртайяа эхнэр болгон өгч гэнэ. Тэр хоёроос олон хүүхэд төрж, тэндээс Загас-эхнэрийн омгийнхон үржиж өнөр өтгөн болжээ. Эл учраас,

Агуу их Загас – эхнэр чи хаана хөвнөм?

Чиний халуун хэвлийд амьдрал үүсмүй.

Чиний халуун хэвлийгээс бид тэнгисийн хөвөөнд төрсөн билээ.

Чиний халуун хэвлийгээс сайхан газар энэ хорвоод байхгүй

Агуу их Загас – эхнэр чи хаана хөвнөм?

Чиний цагаахан хөх хав загасны толгой лугаа адилхан!

Чиний цагаахан хөх биднийг тэнгисий хөвөөнөө тэжээсэн!

Агуу их Загас-эхнэр чи хаана хөвнөм!

Хамгийн чийрэг эр чам руу хөвнөм!

Халуун хэвлий чинь цэцэглэн дэлгэрэх болтугай

Хамаг омог чинь өнөр өтгөн болтугай!

Гэж баяр наадам дээрээ дуулдаг болжээ.

Энэ зүүд нь гадаад далайн ус үл мэдэг нэмэгдсээр нэг мэдэхэд эргийн газра, өвс ногоо сэвхүүл тэргүүтнийг жигтэй тунгалаг усанд живүүлж орхидог адил нэн ч алгуурхан ирдэг ажээ.

Энэ зүүдээ зүүдлэх бүрийдээ өвгөн машид гайхах тул сэтгэлээс нь нэгэн хэсэгтээ эс ховхорно. Орган өвгөн энэ зүүдэндээ хачин итгэх тул Загас-эхнэртэй уулзан зүүдэлснээ хэнд ч, энэ хорвоогийн нэг ч амьтай голтой хүнд эс ярихыг нь зүйрлэвэл ерийн амьдралд тиймэрхүү явдал тохиолдсон хүн түүнийгээ нэг ч хүнд үл ярихтай чанар адил юм.

Энэ бол үнэхээр Органаас салдаггүй зүүд байлаа. Орган энэ зүүдээ байн байн зүүдлэн баяр, гуниг, ер бус сэтгэлийн зовлон эдлэх бөлгөө. Тэр зүүдний нь гайхалтай нь гэвэл, зүүдэнд нь гардаг байж болзошгүй хачи хачин хувьслын утга учир нь эцэс төгслгөлгүй, далд битүү байдал нь олон утгатай байхад Орган өвгөн зүүдлэх бүрийдээ хачин гайхна. Энэ тухай бодож, битүү далд утга үл үзэгдэх зөн ёроороо хүнийг үргэлж зовоодог зүүд ба жинхэнэ амьдралын хоорондын мөнх хувьсагч холбоо тэрхүү хэзээ ч эс тайлагдах нууцын нууцыг тайлах гэж оролдон байхдаа сэтгэл уймрах бүрийдээ өнөө зүүдээ зүүдлэх юмсан өнөө агуу Загас-эхнэртэй дахин уулзах Юмсан гэж тэсэшгүй уйтгараар ямагт хүсэмжлэн байдгаа олж мэдлээ.

Орган бол зүүдэндээ мөнөөхөн Загас-эхнэртэй ямагт далайд уулзан учирдаг билээ. Агуу Загас-эхнэрийг гарч ирхэийг хүлээн далайн хөвөөнд очиж, эргийн эзгүй элсэн дээгүүр явж байхад хөлийн нь мөр эс гарах боловчиг далд орж буй нарны бүдгэрэх туяанаас үл хөдлөх хар сүүдэр хэвээр тусаж байх нь үзэгдэнэ. Тэрхүү сүүдэр хар цас адил үзэгдэх бөгөөд Орган хүний тэсэшгүй уйтгар гунигт дарагдан тэр хар цас шиг юман дээгүүр явна. Хайр сэтгэлийн зовлон, хүслэн найдварын зовлонг дүүрэн эдлэн явахад харин тэнгис далай эзгүй, ажиггүй байна. Тэрхүү бэрх чив чимээгүй бөайдлын дотор ядахдаа салхи ч үгүй, дуу чимээ ч үгүй, хөлийн чимээ ч үгүй. Гагцхүү Орган далай тийш нүд салгалгүй ширтэж, ямар нэг гайхамшгийг горьдож өнөө Загас-эхнэрийг хүлээнэ.

Чив чимээгүй давалгаан үелзэн ирж түүний мөрийн дагуу тэнгисийн чим чимээгүй цагаан хөөс сахруулж байхад Органы дотор улам ч хэцүү болно. Түүний толгойн дээгүүр цахлай шуувуу асар том цасан ширхэг адил чив чимээгүй эргэлдэнэ. Тэрхүү дүлий хэлгүй уудмын дотор Орган орох байх газраа олж ядах бөгөөд түүнийгээ хүсэн хүлээх тусам лотор нь зөөлөршгүй бэрх уйтгар гуниг улам хурц, улам шаналгаатайгаар зовоох тул Загас-эхнэрийг олж үзэхгүй, хэрэв тэр нь гарч ирэхгүй бөөл бие муудаж, тэрхүү эзгүй хоосны дотор үзэж ч болно гэж Орган зүүд нойрон дундаа боловчиг боддог байв. Тэгэхлээр нь түүнийгээ дуудаж, хашгирч үзнэ. Гэтэл өөрийнхөө дууг өөрөө эс олж сонсчээ. Тэрхүү хачин жигтэй зүүдэнд нь юм бүхэн дуу чимээгүй болдгийн нэгэн адил өөрийн дуу хоолой бас гарахгүй зовооно. Тэнгис далай ч чив чимээгүй. Гагцхүү өөрийн нь хүндээр амьсгаалах амьсгаа, зүрх нь гайхалтай чанга түг түг цохилон хоёр санчигт нь лугших чимээ амар заяа эс үзүүлэх ажээ. Үүнд өвгөний уур

хүрэх гэдэг жигтэйхэн. Өөрөө өөрөөсөө яаж ангижрахыгаа, ер хаашаа орохыгоо мэдэхгүй болно. Гань галзуу юм шиг гагцхүү загас-эхнэрийг хүлээж, усанд живсэн хүн аврагдах эцсийн горьдлого эрж байсан шиг үхэн зүтгэн хүлээнэ. Гагцхүү Загас-эхнэр л түүнд жаргалыг авчирч чадна гэж мэдэхдээ эцсийнхээ тэнхээ шавхан хүлээх ажээ.

Гэтэл Загас-эхнэр усны мандал дээр түргэнээ гарч ирээд Органыг ширтэн ширтсээр өөдөөс нь хөвөхөд нүүр ам нь давалгааны хоорнодуур их л бүдэгхэн харагдана даа. Тэгээд өнөө дүлий, хэлгий ертөнц гэнэт уул нурж байсан шиг нижигнэж гарах нь тэр! Далайн давалгаа гэнэт дахин нижигнэж, салхи шуугин, толгойн дээр цахлай шувуу чанга чанга дуугарахад Орган ихэд баярлан хашгиран угтана. Орган баярлан хашгиран далайд үсрэн орж, халим загас адил хамгийн хурдан сэлдэг амьтан болж, урдаас нь хөвөх нь тэр!

Загас-эхнэр түүнийг хүлээн нэгэн дор ус бужигнуулан эргэлдэж, уснаас цовхрон, гарч гулжилзсаар агшин зуур хийд дүүлэгдэхийг үзвэл ерийн нэгэн сайхан гуятай эмэгтэй далайн усанд гэнэт орж цочихдоо цовхорч байсан шиг сайхан амьд бие махбод нь агшин зуун тодхон зурайн харагдана.

Орган өөдөөс нь хөвсөөр нийлж хоёулаа гадаад далай тийш одно доо хөөрхий Хоёулаа зэрэгцэж аваад онь холбон хурдлахад хурдан хөдөлгөөний дунд хочр бие нь үл мэдэг хавирч аятайхан санагдахыг яана. Орь ганцаар огт дуу хэлгүй гунин зовж байсан Орган санасан зорьсондоо хүрэх нь тэр.

Тэд хоёулаа болж аваад алс тэртээ жирвэлзэх шөнийн гадаад их далай тийш ухаанд оромгүй их чадал заан нэн ч хурдан жирэлзэж гарна. Алс тэртээ тэнгэрийн хаяанд их гүнээс ойх ер бусын хачиг жигтэй туяа татна. Тэд дараагаар үелзэн ирэх давлагааны хөөсөрсөн хярыг бизэрээ зүсэн мөнөөхөн баригдашгүй тэнгэрийн хаяа тийш хөвж гарна даа хөөрхий. Тэд эцэс төгсгөлгүй нижигнэх далайн давалгаан дундуур баярлан нисэх сэтгэлдээ автан далайн давалгааны хяраас хярд, нижигнээнээс нижигнээнд нэгэн үе дээш элин гарч, нэгэн үе доош гулган буусаар хөвж байхад уснаа тусаан шаргал сарны толь шиг туяа тэдэнтэй зэрэгцээд, тэднийг огтхон ч салалгүй дагаж, далайн давалгааны дээгүүр мөн хушуу даран хурдалж гарна. Тэрхүү сүнс сүггүй гадаад их далайн уудмыг энэхэн үес зөвхөн сар, зөвхөн Орган, Загас-эхнэр, зөвхөн тэр гурав эзэмдэх ажээ. Энэ бол тэдний жаргалын оргил байв. Энэ бол тэдний эрх чөлөөний бахдал, тэдний учирсны баяр жавхлан байв!

Тэд өөрсдийн оноо тавилантай орчлонгийн нэгэн хязгаар газар бушуу хүрэх тэсгэлгүй хүслэнд захирагдан маш их чадал заан, зогсолтгүй жирийлгэсээр байдаг гэнэ. Тэд бүхий л амтат жаргал, амьдралын эх үүсвэр ба төгсгөлийгн бүхий л гашуун гунигийг цахилгаан гялбах адил агшин мөчийн дотор олж танихын тулд хаана ч юм тэр нэгэн газар тэсэшгши их шуналаар нийлэх ёстой байжээ.

Тэд хүслэн болсон зорилгодоо түргэн хүрэхийг найдан хар хурдаараа хөвсөөр байв гэнэ.

Тэд хэдийчинээ яарах тусам бие махбодын нь шунал төдийчинээ ихээр оргилон буцална. Яргай загас түрцээ орхих газартаа хүрэх гэж яаран амьдралынхаа бүх хүчин чадлын хамгийн эцсийн дуслыг тас шавхан сэлдэг шиг Орган эцэж цуцахыг огтхон ч мэдэхгүй байдаг чадлаараа урагш тэмүүлсээр байна. Хайр сэтгэлээсээ болж амь тавихад бэлхэн болно. Гэтэл үлгэрийн загас-эхнэр улам гижигдэн дагуулж гадаад их далайд улам цааш хөвөн уян шаламгай дун цагаахан биеэрээ Органы бахдах сэтгэлийг даллан даллан давалгааны харанхуй түсэргээн дундуур, нялтагнан туяарах солонгын дундуур долгионы дээгүүр ниссээр л байна. Хөх цагаанаар хуйлрах усан шүршүүрт угаагдсан сайхан биеийг харахдаа Органы амь тэмцэнэ.

Тэд хоорондоо юу ч ярихгүй гагцхүү усны урсгал, түсэргээн дунд бүдэгхэн үзэгдэх нүүр нүүрээ олж харахыг хичээн бие биенээ ширтэн, мөнөөхөн тавилангаар заяасан орон,цагийг улам ихээр тэсгэлгүй хүлээн гадаад их далайгаар зогсолтгүй хөвсөөр байдаг гэнэ.

Гэвч тэр газартаа хэзээ ч хүрсэн нь үгүй, тэр цаг хэзээ чирсэн нь үгүй...

Орган өвгөний энэ зүүд юугаар ч дуусахгүй, гэнэт бүх юм тасран утаа адил замхран алга болдог байжээ. Тийм үед Орган бүр гайхаж хоцорно. Тийм үед үнэнээсээ сэтгэл гуньж, нэг юм хангагдаагүй, дуусаагүй юм шиг санагдан хожим нь их мөрөөдөх нь бий. Заримдаа олон хоногийн хойно өнөө зүүдээ эхнээс нь санахдаа энэ бүхэн нэг л учиртай даа, ямар учиртай юм бол гэж үнэнээсээ бодно. Юу гэвэл түүний зүүдэлсэн зүүд зүгээр биш их учиртай гэж сэтгэлдээ үнэхээр итгэх ажгуу. Ерийн нэг зүүдийг санавч таг мартау орхино. Ер аль зүүдлэхийг тэр гэх вэ. Гэтэл Орган өнөө Загас-эхнэрийг хэзээ ч эс мартаж бөгөөд үнэхээр амьдралд болсон юм уу болох нэг явдлыг бодож байсан шиг түүнийг үргэлж бодно. Эл учир өнөө зүүдэн дотроо Загас-эхнэртэй учраад санамсаргүй салснаа үнэн болсон явдал шиг санаж, тэр зүүдээ санах бүрийдээ үнэнээсээ сэтгэл шаналах ажээ.

Заримдаа өнөө зүүд нь айхтар муухайгаар төгсөх үед бэр ч ихээр сэтгэлийнг там эдлэх нь бий. Тийм үед өнөө зүүднийхээ битүү далд утгатай төгсгөлийн учрыг олохгүй бүр ихээр цөхрөн гуниж хоцорно.

Тэр юу гэж зүүдэлдэг вэ гэвэл, тэд мөнөөхөн ариун газартаа харуигүй хүрэх дөхөж, алсад ямар нэг эргийн бараа харагдана гэнэ. Тэр бол хайр сэтгэлийн эрэг вч. Тэд тэр эрэгт бушуухан хүрэх галзуу мэт хүсэлд автан байдгаараа яаран. Тэнд хүрвэл тэд нэг нэгэндээ биеэ тушаах болно. гэтэл өнөө эрэгт хариугүй хүрдгийн даваан дээр гэнэт ус нимгэрээд өвгөөр татаж, хөвж болохгүй болоод ёроолын элсэнд шаагдаж хоцрох нь тэр. Орган сая сэхээ авч эргэн харвал Загас-эхнэр эвгүй муухай харгианд газрадаад түүнээсээ гарах гэж учиргүй улайран, байдгаараа савчиж байна. Органы хамаг хүйтэн хөлс цутгаж туслахара ухасхийнэ гэнэ дээ хөөрхий. Гэтэл огт бүтэх юм биш. Балчиг намаг шиг юманд шигдээд өөрийн мэдээгүй хөшиж хоцорсон хөлөө чирсээр мөлхөж гарах нь тэр. Загас-эхнэр гар хүрэм газар барга дэргэд нь харагдавч түүнд хүрэх

гэдэг нэн шаналгаатай. Орган амьсгаадан хахаж цацан зүтгэж яваад нялцгар шавар элсэн дотор унаж, усны ёроолын өвс ургамалд орооцолдож орхидог гэнэ. Гэтэл түүний сайхан Загас-эхнэр гүехэн усанд газардчихаад байдгаараа савчиж тийчилж байхыг харах гэдэг бүр ч тарчилгаатай. Зүтгэсээр мөлхсөөр байж нэг юм арайхийн хүрч толгой эргэн найгалзавч цаадхийгээ элгэднээ тэврээд эргийн зүг явахад хүни йгарт баригдсан шувууны ангаахайн зүрх учиргүй түг түг цохилон байдагчлан Загас-эхнэрийн зүрх хагарах гэж байсан шиг цохилохыг сонсохоос бэрх юм үгүй.

Чингээд цаадхийгаа элгэндээ тэвэрч гар дээрээ өргөөд явахдаа арчаагүй жаахан үрээ вэтрээд явсан шиг үнэн цаанаасаа зүрх сэтгээл өвдтөл энхрийлэн хайрлаад хоолойд нь гашуун нулимс зангираад ирдэг юм байжээ. Гэсэн ч Загас-эхнэрээс ичээд биеэ барьж арай л цурхиран уйлдаггүй. Орган түүнийгэжэ тэврээд зүрх шимшрэн санд мэнд явавч алхам бүрийд түүнийгээ бодсоор явна. Гэтэл цаадах нь намайг тэнгис далайд минь буцаан аваачиж дураар минь тавиач гэж нүдний нулимс бөмбөрүүлэн мөргөн гуйдаг ажээ. Загас-эхнэрийн амьсгаа давхцан амь тавиахад хүрдэг юм гэнэ. Тэр тэнгис далайн гадна түүнтэй амраглаж чадахгүй байжээ. Загас-эхнэр уйлу өршөөл гуйсан мэт нэвт шувт харцаар дув дуугай Органыг ширтэхэд Орган тэсэлгүй буцаж өнөө эргийн гүехэн усыг туулан далайн гүнд очоод Загас-эхнэрийг тэврээсээ аяархан тавьж орхино.

Загас-Эхнэр ч далайдаа хөвөөд явчина. Орган өвгөн орь ганцаар дөжрөн хоцроод хойноос нь харж

Агуу их Загас-эхнэр чи хаана хөвнөм?

Тэнгис гэдэг миний гуниг юм

Ус гэдэг миний нулимс юм

Аяа газар болоод миний толгой адилхан

Агуу их Загас-эхнэр чи хаана хөвнөм?

Гэж цурхиран хайлан дуулж байна гэж зүүдэлдэг ажээ.

Энэ тухай санахад нь тэр үнэхээр өөрөө Загас-эхнэр гэдгийг тэврээд явсна юм шиг, өөрөө үнэхээр далайд аваачиж дураар нь тавьсан юм гшиг их л тэсэшгүй бэрх байдаг ажээ. Яагаад тэгдэг вэ? Хүн аливаа хүслэнгээ зүүдэндээ биелүүлж болохгүй гэж үү? Энэ хэнээс шалтгаалах хэрэг вэ? Үүний цаана хэн байна, ву байна, утга нь вунд байна, энэ юунд хэрэгтэй ямар үлгэр юм бэ? Ийнхүү олон битүү оньсого дотор бүр алмайрч мартаж түүний тухай юм бодохгүйг хичээдэг авай.

Гэвч тийнхүү анд явж байгаагаа гэнэт сэхээрэхдээ түүний тухай, ер тэр бүхний талаар яагаад бодож орхив, юу бодож яваад санаанд орчив гэдгээ өөрөө боловч үл мэднэ. Ер Орган бол далайд явахдаа тэрхүү хачин зүүдэнд гардаг бүх явдлыг өөрийн биеэр дахин амсаж өнгөрүүлсэн шиг болдог бөгөөд түүнийгээ эрүүл ухаанаар тунгаан бодоод би энэ тухай юунд бодно, хий хоосон Загас-эхнэрийг мөрөөдөн уйтгарлаж байх бол миний мэтийн өвгөдийн явдал мөн үү?

Гэж өөрөөсөө асууна. Чингээд өөрийгөө буруушаах боловчиг, тэр Загас-эхнэр гэдэг байхгүй бол надад үнэндээ хүнд бэрх байх биз гэж дотроо зөвшөөрөн хүлээнэ. Би одоо өтөллөө, тэнхээ муудлаа, хараа буурлаа, шүд уналаа, алдар нэрээ мандуулж явсан цаг өнгөрлөө, хөгшин хонины насгүй боллоо, ганцхан сэтгэл санаа буурахгүй юм. Хүслэн гэдэг цээжин дотор залуугийн шиг хэвээрээ оргилох юм. Сэтгэлээр хөгшрөхгүй гэдэг бэрх. Тийм ч учраас ийн юм бодож, ийм юм зүүдэлдэг биз. Тийм болоод ер хүн зүүдэндээ л сэтгэл бодолдоо л үхэшгүй мөнх, эрх чөлөөтэй байдаг болов уу. Хүн бол хүслэнгээрээ тэнгэрт гарч, тэнгисийн гүнд орж чадна. Түүгээрээ хүн агуу их юм, үхэн үхтлээ амьдралд буй юм бүхнийг бодож чадна. Гэтэл үхэл бол түүнийг агуу юмандл хүрсэн% ямар зүүд зүүдэлдэг байсан, оюун ухаанаараа хэдий хэрийн хүн байсагн гэдэг бол үхэлд ямар ч падгүй. Орчлон гэдэг яагаад тийм байдаг вэ? Загас-эхнэр зүүд ч гэсэн ямар хамаатай юм, хүн тэр зүүдээ үхсэн хйонооч зүүдэлж л байг... гэж бодно.

Орган бол Загас-эхнэр гэдэгт итгэдэг шигээ тэнгис намайг анхаара соёрхоно доо гэж итгэнэ. Тэнгис далайд явахаараа л өөрийн дураар амьсгалж өөрийн дураар юм бодож явна. Дотроо уужиртал юм бодно. Тийнхүү хүнд дүнсгэр бодолд дарагдан явахдаа заримдаа “Загас –эхнэр бид хоёр яг үүгээр хөвж яваагүй байгаа даа?” гэж өөрөөсөө асуух нь бий.

Тийм мөчид гансандаа дахин дүүрэн тамхи нэрж, тамхины утаанд мансуурахдаа, “Тамхи гэдэг ийм өвч хаана ургадаг юм бол, хортой юм шиг мөртөө сэтгэл уужруулах юм... худалдаачингууд Манжуурт ургадаг гэдэг. Тэд үүнийг манжуураас л тээдэг байна. Манжуур гэдэг бол тун хол газар. Манай эндээс нэг ч хүн хэзээ ч тийш явж үзсэнгүй... Тэнд бол тамхи ойн өвс шиг ургадаг байхдаа, хачин юм. энэ нартад байхгүй юмгүй...” гэж бодож явдаг билээ.

“”””

“”””

“”””

“”””

Нар хэдийн үд дундаас өнгөрөв. Энэ завсар тэнгэрийн хаяанаас хаанаас ч юм гэнэн, гэнэ үүл гарч нарыг хэдэнтээ халхлан өнгөрөхийг үзвэл тэнд тэнгэрийн хаяаны цуана тэнгэр аягүйтэхийн урхаг нуугдаад байсан шиг санагдана. Нар үүлэн цаагуур орохтой зэрэг усны өнгө бүдгэрэн харанхуй бараан болж, эргэн тойрон давчуу юм шиг болж байжээ. Хаврын элбэг тунгалаг нар үүлний цаанаас дахин гарахтай зэрэг энгисийн дээгүүр нүд гялбам хурц туяаны түг түмэн гялбаа наадан, сэтгэл дахин зугаатай болно.

Кирииск тэнгист дасаж, тэр ч байтугай яльгүй залхуу хүрэвч далай гэдэг ийм зах хязгааршгүй асар уужим өайдаг ажээ гэж гайхсаар явав. Хичнээн ч явав даа зах хязгаар гэж үзэгдэх юм алга. Хэрэв хуурай газар явсна бол хичнээн ч уудам цэлгэр байлаа ч гэсэн Кирииск ингэж гайхахгүй биз.

Харин томцуул нь огтхон ч хачирхсан шинжгүй явна. Эмрайн Мылгун хоёр сэлүүрийг их л идэцтэй даллан мөнөө л жигд айзмаар сэлүүрдсээр байв. Тэд эцэж цуцахыг мэдэхгүй сэлүүрдэх бөгөөд тэдний гарыг жаахан амраага гэж Орган өвгөний хэлэхэд маргааш хүнд ачаатай буцах болно, тэгэхэд жаахан туслалцаарай. Одоо та өөрийгээ л мэдэж яв гэцгээв. Хурц төвөнхтэй, урт хүзүүтэй Орган өвгөн үлий сахисан бүргэд адил завины хитэг дээр бөгцийн сууна. Үг ярихаасаа илүү дуугай юм бодож явна.

Тэдний завь онгоц давалгааны дээгүүр үл мэдэг намалзан хөвсөөр л байв. далайн давалгаа ч өнөө хэр тааруу хэвээр үелзэж, салхи ч тогтвортой их доогуур үлээж байв.

Тэд ийнхүү хөвсөөрл байв...

Гэтэл Кириск гэнэт өвгөний гараас татаж,

- Аткычх аа! Аткычх аа! Тэнд арал байна. Бага мээм арал! гэж баярлан хөхин дуу алдахад Орган өвгөн тийш саравчлан харж,
- Хаана арал байна гэж? гэв. Сэлүүрчид ч гайхаж хөвгүүний заасан зүг харцгаав. Кириск хүү санаанд оромгүй шал ондоо зүгт зааж байхад өвгөн
- Арал байх ёсгүй дээ гэж амандаа бувтнав.

Гэвч хөвгүүн худал хэлсэнгүй. Тэртээ алсад тун хол муухай хүрэн өнгөтэй арзгар зурвас далайн дунд нэгэн дор бараантан харагдана. Үзвэл яг л усан дундаас цухуйсан мөргөцөг шиг харагджээ. Өвгөн харж харж,

- Үгүй, арал биш. Бид энэ чигтээ шулуун явсаар нар жаргах үед Бага мээм хүрэх ёстой. Тэр чинь огт ондоо зүгт харагдаж байна. Арал бишээ. Надад бол арал биш шиг л бодогдоод байна гэв.
- Энэ хавьд тийм арал хэзээ ч байгаагүй. Бид тийм арал хэзээ ч хараагүй. Бага мээм арал бидний зүүн гар талд байгаа. Харин тэр харагдаж буй юу болохыг мэдэхгүй байна гэж Мылгун дуугарав.
- Манан юмуу, үүл биш үү? Эсвэл давалгаа юу, тэгвэл яагаад нэгэн дор хөдлөхгүй байна? гэж Эмрайн хэлэв.
- Тэр үнэхээр юу юм бол? Манан юм уу үүл болохыг хэн мэдэхэв. Их хол юм, ямар чгэсэн арал биш байх. Харин манан бол базаахгүй шүү гэж Орган өвгөн бодож хэлэв. Эмрайн сэлүүрийн дээр навтайж,
- Зүгээр, салхины чиг л битгий өөрчлөгдөөсэй. Нэг байрандаа хөдлөхгүй юм. Тэр чиг бидэнд ямар хамаатай юм. Юу л байвал байг... гэв.

Олж харсан зүйл нь юу болох нь эс мэдэгдсэнд Кириск анхандаа урам алдарсан боловч даруй мартаж орхив.

Анчид андуурсангүй, Бага мээм арал удалгүй зүүн гар талд харагдав. Үүнд ямар ч эргэлзээ алга. Бага мээм арал үнэндээ яг мээм дэлэн адил товгор, их чулуутай жаахан хуурай газар юм.

Тэр арлыг хараад хүн болгоны ялангуяа Кирискийн сэтгэл сэргэв. Далай гэдэг бас ч эцэс төгсгөлгүй юм биш байх нь. Даруй хамгийн сонирхолтой явдал эхэллээ.

Орган өвгөн Кирииск хүүгийн юүдэнгэс татаж,

- Алаг хав маань гэртээ үлдсэн боловчиг биднийгээ энэ аралд хүргэлээ дээ. Биднийг дагаж шогшсон бол лав усанд живих байсан биз дээ? гэв. Наадам хийж буй гэж Кирииск мэдээд
- Тэгэлгүй яахав гэв.
- Алаг хав маань гэр орноо сахих гэж үлдсэн ч гэсэн бидэнд хэрэг боллоо. Бид түүнийгээ дотроо санасаар явж ан хийх газартаа төөрсөнгүй ирлээ шүү дээ. Алха хав маань одоо бидэнд хэрэг болох уу? үгүй юу? Чи юу гэж бодож байна.
- Одоо хэрэггүй. Бид чинь очих газраа одоо өөрснөө харж байна биш үү! Гэж Кирииск бас л тун ч итгэл дүүрэн хариулав.
- Чи сайн бод. Би их цовоо хүүхэлд, юм бодох л ёстой гэж Орган зэмлэнгүй өгүүлэв.

Энэ алсын холын арлын тэнд Алаг хав толгой яагаад хэрэг болдог билээ гэж Кирииск хүү ухаарсангүй.

- Алаг хав маань энд ямар хэрэг болох юм?
- Тэгвэл чи яаж гэртээ буцах вэ? Хаашаа, аль зүгт явах вэ? За бодож үзэв үү? Олов уу? Бид аль зүгээс ирэв, энэ арлын аль тал нь Алаг хав толгой тийш харж байна сайн тогтоож ав. Тэгвэл чи буцахдаа аль зүгт явахыгаа мэдэж авна.

Кирииск дотроо дуугай зөвшөөрөх боловч биедээ эрдсэнээс юм уу дотроо жаахан дүрсхийж

- Тэгвэл харанхуй болбол яах вэ? Шөнө далайд юу ч харагдахгүй биз дээ, аан? Тэгвэл яах юм?! Тэгвэл Алаг хав толгой хаана, аль зүгт байгааг яаж мэдэх юм! гэв.
- Тэгвэл бас мэдэж болноо. Түүний тулд тэнгэрт од байдаг юм. Од гэдэг чинь хүнийг хөөдөхгүй, хэзээд яг зөв заана шүү! Харин хаана ямар од байдгийг өөрөө сайн мэдэж авах хэрэгтэй. Чи жаахан том болохоороо их юм мэдэж авнаа. Чи Лувр нугасны одны ордыг мэдэх үү? Гэж Орган их тайван шалгаж байв.
- Мэдэх л юмсан гэж Кирииск итгэл муутайхан хариулж эцэг рүүгээ харав. Эмрайн, хүүгээ бажигдаж буйг мэдээд,
- Бага сага мэднэ байх аа, би зааж өгсөн л юмсан. Гэхдээ энэ юу ч биш, бам их юм мэдэж авах хэрэгтэй гэв.

Тэд ийнхүү аралд алгуурхан дөхөв. Эргийн хад чулуу ялгаран харагдаж ирэхээр тэд арлыг алсуур тойрч хав загасны хэвтэр газар харцгаав. Кирииск хамгийн түрүүн олж харах гэж туйлын хичээнгүйлэн ширтэж явав. Гэтэл чи хэрэв олж харвал битгий их бахираарай гэж сануулав. Орган өвгөний хэлэх нь

хав загас наранд ээх гэж уснаас гарч эргийн хад чулуун дотор хэвтэж байдаг. Тэднийг хаахна суурилан буйг мэдэж тогтоож аваад ондоо газар харагдалгүй бууж, огт үргээлгүй алсаас мярааж ойртдог гэжээ. Гэвч Кириск юу ч олж харсангүй. Нэг л эзгүй уйтгартай эрэг харагдана. Цагийн эрхэнд элэгдсэн арзгар хад ондоо юу ч үгүй, Далайн давалгаа арлыг эргэн тойрон бүслээд тэрхүү хад чулуун дээгүүр давж гарах гэж шуугин шуугин балбаж байна. Кириск юу ч олж харсангүй. Тэнд зөвхөн чулуу, хад харагдана. Амьд амьтын зүйл огтхон ч эс үзэгдэв.

Гэтэл Мылгун хамгийн түрүүнд олж харлаа. Хав загас чухам хаана нь нуугдан хэвтээг ялгаж харах гэж Кириск эргэн эргэн харж байх зуур тэдний завь тэр газраасаа холдон зайлав. Хав загаснууд тэднийг харва үргэж алга болно.

Кириск хүү юу ч олж харсангүйг Орган өвгөн мэдээд,

- За чи олж харав уу? гэв. Кириск худал хэлэх зүрх хүрсэншүй.
- Үгүй үзсэнгүй гэв.
- Дараа дахин нэг ирэхдээ хав загасыг хадан дундаас ялгаж хардаг болноо гайгүй. Тэгэхгүй бол сайн анчин болж чадахгүй шүү гэв.

Сэлүүрчид тэндээ эргэх гэдэг осолтой байсан боловч өвгөний үгэнд орж завиа өнөө явж байсан зүг рүү аваачив. Хав загаснуудын нэгий нь л үргээж орхивол бусад нь цөм даруй усандаа орчих байлаа. Гэвч азаар сайхи загаснууд анчдыг олж харсаншүй. тэд яг усны хажууд энд тэндгүй арсайн харагдах асга хадан дунд чулууны цаана үелэн хэвтэцгээж байв.

- Чи тэр хугархай соёо шиг хурц ирмэгтэй чулуу харж байна уу? түүнээс холгүй мөстсөн гялгар улаавтар гүвгэр юм харж байна уу? Тэр хоёрын завсраар хар гэж Мылгун хэлэв.

Кириск тэр зүг ширтэв. Энэхэн үес Мылгун Эмрайн хоёр завиа нэгэн байранд тогтооож байх гэж дор дор нь сэлүүрдэж байв. Кириск ч даруй мундаг голигор сүүтэй, овор том биетэй далайн амьтны нурууг олж харав. Ов тов толботой, гялтганасан саарад нуруунууд огт хөдлөхгүй байна. Урьд нь үзээгүй хүнд бол тэр чулууны хооронд байгаа амьтдыг ялгаж харахад бэрх ажээ.

Энэ мөчөөс хүүгийн сэтгэл булиглан эхлэв. Ёстой тэнгисийн ан гэдэг энэ ажээ! Ёстой их агнуур гэдэг энэ ажээ!

Тэд эрэг дээр буухад хүүгийн сэтгэл ихэд хөөрөв. Кириск энэхэн үес эрэлхэг зориг, бахархах сэтгэлээр дүүрэн байв. Эрэлхэг зоригтой болдог нь Кириск хүү энэхэн үес өөрийгөө их бяртай чадалтай чухал хүн гэж бодно. Бахархах сэтгэл төрдөг нь цаадуул нь хэрхэн бузгай, эмхтэй ажиллаж байхыг үзээд тийм сэтгэл төржээ. Тэд завиа хэрхэн эргийн дэргэд аваачиж, Эмрайн, Орган хоёр сэлүүрээр завиа эргийн давалгааны ирмэг дээр тогтоож байхад Мылгун хэрхэн эвийг олж харгианы захад үсрэн буугаад завин дээрээс шидэж өгсөн олсны үзүүрийг мөрөн дээгүүрээ хэтрэн, завиа эргийн тийш чангааж, эцэг нь хэрхэн ангийн буунуудаа тэврэн эргийн дээр үсрэн буухыг Кириск харж

байв. Дараа нь өөрөө Орган өвгөнөөр дэмжүүлсэн ч үгүй үрсэн буув. Гэвч энэ удаа эрэг хавийн давлагаанд гутлаа норгоод эцэгтээ яльгүй аашуулсан нь бий.

Эрэг хавийн давлагаан дээр завиа тогтоож байх гэж Орган завин дээрээ үлдэж. Эмрайн, Мылгун, Кириск гурав өнөө хаь загасны хэвтэр рүү яаран оров. Тэд төрөлхийн зөнгөөр яльгүй бөхийлдөн нэг чулуунаас нөгөө чулууны ард нуугдан гүйлдэв.

Том анчдыг дагаж далайн ан агнахаар ийнхүү бушуу түргэн яваа Кириск хүүг энэхэн үес Загас-эхнэрийн осгийнхон хардаг бол юу гэх бол! Энэхэн үес эх нь харсан бол ирээдүйд том анчин болж, отог омгоо тэжээх хүүдээ хэрхэн бахдах байсан бол! Энэхэн үес түүний тоглон наадан өссөн Музлук охин харсан бол юу гэх бол! Кириск одоо анчин гэдэг нэрийг олсноос хойш түүнтэй тоглон наадаж суух завгүй болжээ. Кириск хүүг төрсөн Алаг хав толгойгоосоо алс хол далайн давалгаа шуугин буцлах танихгүй эргийн хөвөөнд зэрглэг онгон хад чулуун дундуур хав загасны хэвтэр рүү мярааж явааг нь энэхэн үес тэр нь харсан бол юу гэх бол. Мылгун, Эмрайн хоёр ангийн буутай, өөрөө буугүй яваа нь гайгүй хэрэг. Буудах цаг ирэхээр буугаа өгч буудуулна гэж эцэг нь ам гарсан юм чинь.

Тэд ийнхүү нэлээн дөхөж очоод цааш элгээрээ мөлхөцгөөв. Кириск л мөлхөв. хатуу чулуу, арзгар мөсөн дээгүүр мөлхөх гэдэг эвгүй, бэрх байсан боловч ингэх хэрэгтэй гэж Кириск мэдэж байв. Тэд хүнд ихээр амьсгаадан, хөлсөө гоожуулан мөлхсөөр байв. Заримдаа нам болж, заримдаа өндийн ийш тийш харсаар явав. Буу шийрлэн буудах газартаа хүрээд тэд амьсгаа даран таг чимээгүй болов.

Кириск хүү энэ цаг хаврын энэ өдөр хязгааргүй их тэнгисийн дунд орших энэхүү хүйтэн чулуутай арал ийш тийш цацагдсан юм шиг хэвтэх эзүгүй газрын бараан шаргал чулуу одоо хүртэл мөс нь хайлаагүй нүцгэн цэвдэг газар энэ бүхнийг насан турш мартаггүйгээр сэтгэлдээ тогтоон авав. Тэрхүү элчилгүй хатуу цэвдэг газар Кириск эцгийн хамт, Мылгуны хамт түрүүлгээ хараав хэвтэв. Тэдний өмнө далайн эргийн эвэр газар шуурга, салхинд элэгдэж эвдэрсэн барзгар сарзгар хад чулуун дунд цөөн тооны хав загасны сүрэг огт чимээ авсан шинжгүй байр байрандаа амар тайван хэвтэнэ. Тэдний дээр хав загасны хэвтрийн ддэр арлын дээр тэнгэисийн үл мэдэг бүүдгэр тэнгэр дүнсийж, түрүүчийн буун дууг түгшин хүлээж байх шиг санагдана.

Кириск эцгийнхээ ангийн бууг мөрлөн хэвтэхдээ “онох л юмсан” гэж бодно.

Ихэд хүлээсэн энэхэн агшинд Кириск өөрийгөө нэртэй цуутай, эрэлхэг анчин болов гэж биедээ бахдах сэтгэл төртөл бас өнөө хаврын нарны ядуухан илчийг горилон чулууны хонорт шахалдан хэвтээ болхи тарган амьтдын амьд нуруу, амьд бөөрийг харахад даанч арчаагүй дорой санагдаж гайхжээ. Гэвч зөвхөн минутын тыдий ингэж саатан бодсон хэрэг. Тэр даруй би анчин хүн, намайг ан агнаж ирнэ гэж улс хүлээж байгаа, ер хав загасны мах өөхгүй бол аж

амьдрал өлөн зөлөн байдаг гэж санатал бас хамгийн түрүүнд буудаж өөрийгөө үзүүлэх хэрэгтэй гэсэн бодол гялсхийн орж иржээ. Кириск хүү сэтгэлээ чангалан, эцгийн заасан ёсоор нэг ов тов цоохор мундаг том хав загасны зүүн сэрвээнээс арай доогуур, арай баруугаар яг зүрхэн тус газар баттай шагайв. Гэтэл тэр хав загас анчдыг олж хараагүй, салхи далайн зүгээс салхилж байсан болохоор үнэр авах ёстой байтал гэнэт нэг базаахгүй явдал болох нь гэж мэдсэн юм шиг сэрхийж, сэрэмжлээд орхилоо. Кириск яобгүй жаахан дөхөх хэрэгтэй байв. Бууны овоо хараа тааруулахад урд нь ямар нэг сүүдэр шиг юм саад хийгээд байв. Гэтэл маш болгоомжтой дөхөх хэрэгтэй болов. гэтэл Кирискийн тохой дороос нэг чулуу газрын уруу өнхрөхдөө замдаа бас нэг чулууг дайрчээ. Өнөө цоохор хав загас хуцаж байсан шиг огцом дуу гартал цаадуул нь бужигнан ус руугаа түргэн түргэн өнхрөн мөлхөцгөөв. гэтэл тэрхэн үес тэднийг далайдаа орохоос урьдаж буун дуу тас бууж, хамгийн захын нэг бүдүүн хав загасыг унагав. Энэ удаа Мылгун аминд оржээ. Кириск сандарч хоцорв.

- Бууд! Гэж эцэг нь тушаав.

Дал мөрийг нэг юм маш хүчтэй нударч буун дуу тас бууж, хүүгийн чих дөжрөв. Кириск оносонгүй, алдаж орхиод өөрийн буруугаар ангийн ажлыг таслав гэж тэсгэлгүй ичив. Эцэг нь сум өгч,

- Май сумлаад бууд гэв.

Буу тавьж сурах гэж хоосон буугаар сургууль хийэ байхад буу сумлах гэдэг тиймчиг түвэгтэй ажил биш шиг санагдаж байсан атал одоо болохоор болдоггүй! Бууны замаг даруй мултарч өгсөнгүй. Гэтэл энэхэн үес Мылгун өнөө ус руугаа ум хумгүй зугадаж явсан хав загаснуудыг өвдөг дээрээсээ хоёр буудаж нэгийг шархдуулж орхив. Шархтсан ан эргийн яг ирмэг дээр хөлбөрч харагдав. Анчид тийшээ гүйлдэв. Мөнөөхэн сүрэг хав загас хэлийн далайдаа алга болж, шархадсан нэг нь эрэг дээр үлдээд ус руу орох гэж байдгаараа оролдов. Анчид гүйлдсээр очтол шархтсан амьтан усандаа хүрч амжжээ. Мурилзсан улаан цусан зам татуулан, хавтаг сэлүүрээ хөдөлгөн хөвсөөр тэнгисийн тунгалаг усны гүн рүү орчив. Түүний айж бүтийсэн нүд, сэрвээнээс аваад сүүлийн үзүүр хүртэл, нурууг нь дагаж тогтсон уайвар хөх зураас нь хүртэл тунгалаг Усанд тодхон харагдана. Мылгун буугаа доош буулгав. Тэр хав загасыг нэрмэх гэдэг бол утгагүй хэрэг байлаа.

- Боль, боль, тэртэй тэргүй живнэ гэж Эмраийн чанаг дуугарав.

Харин Кириск сэтгэл ман дундуур гаслан аахилан зогсов. Тэр үүнээс хамаагүй илүү юм бодож байв. Ай чааваас, мөн ч лут анчин бол доо!

Кириск гэнэт өөртөө гомдон уйлмаар болсон авч хамаг сэтгэлээ чангалан дуугай өнгөрөв. Тэд алсан хав загасныхаа гэдэс дотрыг гаргах үед Мылгун, хүүгийн сэтгэлийг амруулан

- Зүгээр, чамд аз таарна. Одоо бид дунд мээм орно, тэнд ан эндээс элбэг гэв.

- Би даанч яараад... гэж Кириск ярих гэтэл эцэг нь тас дайрч

- Биеэ бүү өмөөр. Анх буу бариад анчин болсон хүн гэж байдаггүй_ Сайн буудаж сурвал ан амьтан чамаас зайлахгүй гэв.

Кириск дуу гарсангүй боловч томцуул зэмлэсэнгүй гэж дотроо талархав. Кириск харин анд яарах хэрэггүй, ондоо юм бодох хэрэгтэй, эцгийн заасан ёсоор хараа, амьсгаа хоёр “овоо хараанд багтсан” цагт л лавтай будах хэрэгтэй юм байна. тэгсэн цагт сая сум тавьж байя! гэж өөртөө ам тангараг өгөв.

Мылгуны алсан хав загас их лут, хүнд загас байв. Мылгун сэтгэл ханасан мэт алга үрчиж хав загасны өрийг яруу хараач “дөрөвөн хуруу өөх байна шүү. Сайн байна!” гэнэ. Кириск гутарч байснаа ч матраж орхиод түүнд дуртайяа тусалцав. Эмрайн энэхэн үед завиа эрэгт дөхүүлж ир гэж Орган өвгөнд хэлэхээр явав. Удалгүй ихэд санаа зовсон янзтай яаруу буцаж ирээд

- Алив шалавлая, цаг хүлээхгүй шүү! гэж тэнгэр өөд хараад хэнд ч зориулалгүйгээр – Тэнгэр нэг л аягүй санагдаад байна... гэв. Тэд даруй хав загасныхаа гэдсэн дотрыг гаргаж, элэг зүрх хоёроос бусдыг хаяж тураг махыг нь шургааганд дамнан завь руугаа дөхөв. Кириск хоёр буу үүрээд хойноос нь даган алхана.

Орган өвгөн эрэг дээр завиныхаа дэргэд тэднийг хүлээж байв. Өвгөн их л баяртай.

- Бидний сэтгэл дүүрэн байгааг дээд тэнгэр таалаг! Иймэрхүү эхэлбэл ч муугүй шүү! гээд ангийнхаа хутгыг гаргаж ирэв. Хав загасны түүний элэг газар дээр нь иднэ гэдэг бол ан алсны дараагийн хамгийн гол чухал зүйл байдаг юм! Орган хав загасны махан дээр сандайлж байгаад элгийг хэрчиж хүн хүнд хувь хүртээв. Анчид нуугисан зөөлхөн элэг хэрчин, давс үрж байгаад их шүлтэн үмхэлж сэтгэл хангалуун тамшаацгааж байв. Зөөлхөн, бүлээхэн, өег тун сайхан элэг байв. Аманд орохтойгоо зэрэг рарж амаар дүүрэн өөх тос амтагдах ажээ. Кирискийн хүсэл төрөөдөл биелэгдэж, жинхэнэ анчид адил түүхий элэг идэж үзэв.
- Том томоор үмх! Шөнө хүйтэн хононо, даарна шүү, харин элэг бол хамгийн илтчэй идээ байгаа юм. Бас өвчин болгонд хамгийн түрүү эм болдог гэж Орган өвгөн хөвгүүнд зөвлөн ярьж байв.

Элэг гээг үнэхээр сйхан эд байв. Хэд үнхмэгц цадаж дороо ам цангах боловч тэдний умдны жижиг торхтой ус завин дээр бий.

Цөм идэж цадмагц Эмрайн бас л тэнгэр өөд сэтгэл тайвангүй харж

- Махаа энд хуваах явдалгүй шүү гэв. Өвгөн зөвшөөрч
- Амжина даа. дунд мээмэн дээр бугаад шөнө цай халааж ууна. Одоохондоо ингээд дөнгөөд аваал явчихъя. За махаа завиндаа ачих уу даа гэв.

Анчид тэндээс хөдлөхийн өмөн газар дэлхийд хишиг хүртээхээ мартсангүй. Хавзагасны зүрхийг жижиг жижиг хэрчиж дахиад ирэхэд олз омог хайрлаарай гэж арлын эзэнд залбиран тал тал тийш цацан өргөв.

Чингээд тэд дахин далайдаа орж хөдлөв. Бага мээм арал ард хоцров. Баргар их усан дунд өнчин ганц арал хоцрохыг үзэхэд эрхбиш өрөвдөх сэтгэл төрнө. Тэд дунд мээм арлыг чиглэн явав. Ер үдэш орой болох дөхөж байв. Сэлүүрчид сэлүүрийн дээр улам навтайн гэгээтэй байхад Дунд мээм арал хүрэх гэж яарав. Тэнд далд газар завиа татаж хоноглох ёстой байв. Бага мээм арал удалгүй гэнэт далайд орсон мэт үзэгдэхгүй болов. Гэтэл Дунд мээм арал бас л бараа алга байв. Бас л эргэн тойрон ус хүрээлэв.

Тэднийг өнөө хав загас агнаж байх хооронд тэнгисийн байдал мэдэгдэхүйц хувирчээ. Давалгаа улам нягт, улам ширүүн болжээ. Далайн ус хуучин чигтээ гүвэлзэх боловч салхины чиг хэдийн өөрчлөгджээ. Завь сэгсрэх, найгуулах нь улам ч ширүүн болжээ. Гэвч тэнгэрийн байдал анчдын сэтгэлийг илүү зовоов. Тэнгэр юу ёрлох нь энэ вэ? Жилийн энэ улиралд тэнгэр ийм байна гэдэг нэг л учир ойлгогдохгүй, нэг л санаанд оромгүй ажээ. Хаанаас гарсан нь үл мэдэгдэх харанхуй булингар агаараар нисэж, хаана нэгтээ харанхуй шугуй ширэнги дотор дүрэлзэх алсын ойн түймрээс салхинд хөөгдсөн хөөнгө адил сиймхий цагаан хөшиг тэнгэрийг бүрхэв. Тэрхүү утаа зөвхөн тэнгэрт татаж, хэнд ч саад хийгээгүй авч анчдын царай баргар болов.

- Энэ утаа шиг юм хаанаас гарна вэ? гэж Орган амандаа үглэн, сэтгэл дундуур янзтай эргэн тойрон харав.

Тэд одоо сэлүүрийг даллах бүрийдээ мөд газар харагдана, гурван арлын дотроос хамгийн аятай, найдвартай Дунд мээм арал харагдана гэж амьсгаа даран ширтэн явав.

Гэтэл тэрхэн үед тэнгэр дахин цэлмэж, тэнгисийн хязгаараас, санаанд багтамгүй их алс хол харагдахыг үзвэл дэлхийн хязгаараас ч магадгүй нар шагайна. Нар өөд эргэж хургалгүй эгц харж болохоор байв. гэтэл дугуй улаан нар тэрхүү алс холын утаа манан дотор бүдгэрсээр шингэв. Тэнгэр гийсэн болохоор дахин гэгээтэй болж, орчин тойрон амар жимэр болов. Далайд явсан улсын дотор онгойж, мөнөөхөн арал дээр хүрч тохитой төлөвтэй амрах нь гэж урьдаас баярлалдана. Орган өвгөн хажуудаа суусан Кирикийн сэтгэлийг илбэн засаж нурууг нь алгадан

- Жаахан тэсэж үз. дунд мээм арал одоохон гараад ирнэ гэв.

Хүүгийн ам хэдийнээ цангаж явсан боловчиг эцгийн хориглосон үгийг хүүхдийн гэнэн хонгор зангаар ягштал баримтлан дугай л явав. Анд гарахын өмнө эцгийн нь хэлсэн нь, далайд явахад амны ус илүүч үгүй, дутуу ч үгүй авч явдаг. Гэртээ байсан шиг дандаа ууж болдоггүй юм. Далайн өнөөх гурван арал дээр ч гэсэн цэвэр ус дусал ч байдаггүй. Завинд илүү их ус тээж бас болдоггүй. Зөвхөн цөмөөрөө умдаалах үед л ууж болно гэсэн билээ.

Мөнөөхөн хэсэгхэн гэгээ орж алсад гэнэт тэнгэр цэлмэн наран шагайх үес Орган өвгөнийг үзвэл сайхан зантай харагдсанд Кириск,

- Аткычк аа! Ам маш их цангаж байна гэж зоригтой хэлээд эцгийгээ гэтэн харжээ. Орган учрыг мэдэж мушилзан инээмсэглэж,

- Уухай мөн дөө! Түүний элэг идсэн хойно энэ ч зүйн хэрэг. Аргагүй! Ингэхлээр цугаараа жаахан юм ууцгаах уу даа, аан? гэв.

Эмрайн Мылгун хоёр ч суудлаасаа дуртайяа толгой дохив. Би ганцаараа биш хүн болгон юм уухыг хүсэж байгаа ажээ гэж Кириск дотроо баярлаж байв.

- За тийм бол яахав, жаахан ус ууцгааж, дараа нь сайхан тамхиа татъя даа гээд Орган залуурын сэлүүрийг чагталж орхиод завины ёроолоос жижиг торхтой ус гаргаж эвтэйхэн тавиад дотрыг тугалгаар зайлсан зэн шаганад торхны ховилыг дагуулан гоожуулав. Тэр бол алаг хав толгойн цаад талын булгаас авсан хүтйэн тунгалаг ус байлаа. Тэнд ямагт ариун аагтай, хүний хамгийн дуртай ус байдаг. Зун бол тэр булгийн уснаас цэцэг, ногоо, бас чийгтэй шорооны үнэр ямагт анхилж байдаг.

Кириск шанага тосож байхдаа бушуухан бушуушхан залгилахыг нэн ч хүсэж байв. Орган шанаганы тал дундуур хийгээд бөглөөг бөглөж,

- За өөрөө уу. Дараа нь бусаддаа өгөөрэй. Битгий цалгиагаарай гэж сануулав.

Кириск анхандаа ховдгоор залгилж байснаа сүүлдээ аажуухан амтлан үзвэл уснаас дарагшсан модны үнэр ханхалж байв.

- Ууж ханав уу? гэж Орган асуув.
- Ханалаа.
- Нүдий чинь харвал арай ханаагүй шиг байна. Бас жаахан хийж өгье дөө. Түүхий элэг гэдэг цатгалан эд, газар дээр байсан бол хувингаар ч ус уумаар байна гээд шанаганы ёроолд жаахан ус гоожуул өгөв.
- Кириск сая ханаж, тийм үед томцуул хоорондоо за нэг дотор онгохй шиг боллоо гэж ярилцдаг шударга үгийг санав.

Дараа нь хоёр сэлүүрчинд шанганы тэхий дундуураас дээгүүр дээгүүр хийж өгөв. Тэр шанагатай усыг нь Кириск тус тусад нь дамжуулж өглөө. Өөрөө ханатал уусан болохоор Эмрайн Мылгун хоёр хичнээн ч уусан огт санаанд орохгүй байлаа. Гэтэл Орган өвгөн тэг хоёрт яагаад шанганы тэхий дундуураас дээгүүр өгч байгааагийн учрыг хүүд тайлбарлан хэлж өгөх нь хэрэгтэй гэж үзжээ.

- Чи биеэр бага, энэ хоёрыг хар л даа, ямар байна. тэгээд бас их хүнд ажилтай яваа. Завль сэлүүрдэхэд тун их ам цангадаг юм.

Цаад хоёр нь үнэндээ шанагатай усыг дор нь хөнтөрч орхисонд дахин нэмэх хэрэгтэй болов. Энэ удаа ахлаг Орган өас тэр хоёрыгоо үглэх нь зүйтэй гэж үзжээ.

- Та хоёр ч гэсэн дэндүү юм. Ямар глын эрэг дээр байгаа биш дээ гэв.

Эмрайн Мылгун хоёр хариуд нь дарвайтал инээмсэглэхийг үзвэл, ойлгож байна, ойлгож байна, гэхдээ даанч ам цангаад аргагүй байна шүү дээ гэж хэлж байсан шиг ажээ.

Гэтэл Орган өөрөө хувиа хийж уугаад мушилзан толгой сэгсэрч,

- Голын эрэг дээр сууж байвал ч зүгээр л байна. Түүхий элэг гэдэг ийм л хүйтэй эд дээ... гээд гаансандаа тамхи нэрж асаагаад утааг их л тамшаан татаж байхад ийм жаргал дахин хэзээ ч амаж эдлэхгүй гэдгээ огтхон ч тухайлсангүй ажээ.

Тэрхүү гай зовлонг Кириск хамгийн түрүүнд харжээ.

“”””

“”””

“”””

Энэ явдал болохын өмнө гайхмаар амгалан байлаа. Тэд цөм цангаага гаргаад сэтгэл дүүрэн, нэн ч жаргалтай байв.

Анхныхаа олзыг олосн, одоо өнөө арал хүрч амарч хоноод маргааш өглөө эрт гарч, ангаа агнамагц шалавхан буцах хэрэгтэй байв. Юм бүхэн жин тан.

Тэдний завь мөн л долгионы дээгүүр намалзан урьдын адил хөвсөөр байв. Орган өвгөн завины хитэг дээр суугаад гаансаа сорсоор залуурдан явахыг үзвэл магадгүй өнөө л Загас-эхнэрийнхээ тухай бодож явсан биз. Эмрайн Мылгун хоёр сэлүүрийг жигдхэн далла сэлүүрдэхийг үзвэл нэг их бяр гаргалгүй, хөнгөхөн, гоё ёсэлүүрдэж явах шиг санагдана. Кириск эднийг харж өөрийн эрхгүй сонирхон явна. Хүүхдийн ямар нэгэн сониуч зангаар тэднийг тус бүрий сонирхон харж, тусбшүрийн талаар юм бодож явав. Кириск тэдэнд ухаангүй хайртай бөнөөд далайн анд тэдний хамт явж байгаадаа улам бахдах сэтгэл төрнө.

Кириск эднийгээ ондоогоор бодож эс чадна. Орган өвгөн ийм л хурц шовх төвөнхтэй урт хүзүүтэй, модны үндэс адил булдруутай урт гартай, бүхнийг танигч ус гүйлэгнэсэн нүдэй нэгэн билээ. Үүнээс ондоо хүн байж болоа байсан гэж үү? Хүн бүхний хүндлэн хайрладаг энэ ахлагч энэ хүнгүйгээр амьдарч болох байсан гэж үү? Чингэж болох байсан гэж үү? Хачин юм.

Кириск эцэгтэйгээ туйлын адилхан, том болохоороо Эмрайныг цутгасан юм шиг адилхан болно гэж ээж нь ярьдаг билээ. Нүд нь яг эцгийнх шигээ царсны борогоцой шиг хар, нүд нь бат бөх, бас үүдэн хоёр шүд нь яльгүй дорсгой гэнэ. Том болоод мөн эцэг шигээ өтгөн, бавгар хар сахалтай хүн болно гэнэ. Кирискийн эцгийг сахалт Эмрайн гэдэг нь санамсаргүй юм биш. Кирискийг бүр жаахан, голын усанд шалдан умбаж байхад эх нь эгчийгээ нударч, хараач, эцэгтэйгээ яг адилхан хүү гэлдэг байжээ. Тэд хоорондоо наргиж, унан тусан хөхрөлдөн чанга чанга шивэглэлдэхийг үзвэл манай Кирискийг том болсон хойно над шиг эхнэр тааралдвал тэр эхнэр ямар ч зовох юмгүй их сайн сууна даа, би мэдэж байна гэж эх нь ярьжээ. Жигтэй юм, хэн ячаж сайн суух хэрэг вэ? Би эцэгтэйгээ адилхан байвал яагаад миний эхнэр тийм сайн суух хэрэг вэ? Хачин юм гэж Кириск боддог байв.

Хар сахалтай цав цагаан шүдтэй эцэг нь одоо өмнө нь суугаад завью сэлүүрдэн явна. Өргөн ханхар цээжтэй өөртөө итгэлтэй олон таван зангүй хүн. Эцэг нь бусдын адил чанга бахирч загнаж юм уу өрөвдөж өмөөрч явсныг

Кириск үл мэднэ. Харин үнэндээ царсны боргоцой шиг хархан, гялбалзсан тунгалаг нүдтэй хүн авай.

Түүний шилийг хараад хоёр дахь сэлүүр дээр нагац ах Мылгун сууж явав. Мылгун бол Кирискийн эцгээс хоёр дүү юм. Дүү нь гэхэд эрүүндээ барга сахалгүй зөвхөн далайн илжигний сахал адил хэдэн шөрөвгөр үс гозойжээ. Өөрөө ч далайн илжигтэй ихэд адилхан хүн. Эвгүй юм болбол ямагт хэлцэх, маргах дуртай хүн. Хүнийг гомдоох гэж үе үгүй, явуулын нэг худалдаачинтай ганцхан удаа зодоо хийсэн нь бий. Тэгэхэд бүх омгоороо өнөө худалдаачны өмнө уучлал эрж аргадацгаасан ыбилээ. Харин Мылгуныг аргадах гэж яджээ. Намхан тагдгар нуруутай, хожуул адил бөөрөнхий биетэй атал тэр худалдаачин хүнд үнэн гэж юу байдгийг үзүүлнэ гэж давшлан байжээ. Жаахан балгаж согтсон доо трэ. Урьд нь бол дандаа ан гөрөө хийнэ. Тэгэхэд Эмрайн бас бус хэлэн хүн түүнийг хүлэх гэж арайхийж дийлсэн гэдэг. Баавгай шиг бяртай хүн, ШКириск бол түүнийг Мылгун аки гэж дуудна. Кирискийн аавтай их эвтэй найртай, дандаа цуг анд явна. Яагаад гэвэл тэд хэн хэнийгээ хэзээ ч хөөдсөн удаа үгүй, ер хоёулаа адимлхан найдвартай анчид юм. Мылгуны хүүхэд даанч бага% дөнгөж хөлд орсон нэг хүү түүнээс эгчмид хоёр охинтой билээ. Хэн нэгэн тэднийг шоглох гэвэл Кирискийн өмөөрөх гэдэг учиргүй. Кирискийн эх ч Мылгуны охин хүүхдийг амь шигээ хайрлана. Мылгуны охин хүүхдүүд Кирискийн охин дүү Пусультай тоглох гэж дандаа ирнэ.

Гэвч тэр омгийн бүх бага охидын дотроос хамгийн хөөрхөн нь Музлук юм! Харамсалтай нь Музлукийг том болохоор ондоо тийш айл хөрш нутагт хадамд өгөх ажээ. Түүнийг л авч бусдад өгөхгүй юмсан...

Кириск гэнэтхэн өнөө Алаг хав толгойн цаана голын хөндийд, ойн цоорхойд орших далайн хөвөөний нивх ястан, өөрөөр хэлбэл Загас-эхнэр омгийн хуучин бууцанд гэртээ харих юмсан гэж нэн ч хүсэв. Ээж дээрээ очих юмсан гэж бодохоос зүрх шимшрэх шиг болов. Гэтэд тэд төрсөн далайн эргээс, мөнх тэнгисийн хөвөөгөөр мөнхөд шогшигч өнөө Алаг хав толгойгоос харихын аргагүй холдсон байлаа. Кириск тэр ч байтугай өөрийн эрхгүй эргэн харж, магадлах гэсэнэ шиг огт санаадгүй ийш тийш сүрхий харав.

Гэтэл тэнгисийн дээгүүр бараг тэнгэрийн талыг бүрхсэн өтгөн зузаан бор манан тэднийг чиглэн хоёр өргөн хэл нийлэх гэж байсан шиг айсуу. Тэр манан усны хар мандал дээгүүр жигтэйхэн хүчтэй хуйлран% орчны юм бүхнийг нөмрөн ирэв. Мана ойртон ирэхийг үзвэл сайхь анчдыг завьтай нь хамт тэнд буй үзэгдэгч, үл үзэгдэгч болгоны хамт эзлэн залгих санаатай яваа ямар нэг амьд амьтан, мангас шиг үзэгдэнэ. Манан мөнөөхөн тэдний ямар нэг арал юмуу гэж ярилцан байсан тэр зүгээс нөмрөн ирэв. Кирискийн харсаар байтал далайн дунд хөөрсөн бөөн Бор саарал юм нөмрөн ирэхэд хөвгүүн сандарч,

- Хараач та минь! Хараач! гэж дуу алдан хашгирав.

Анчид цөм тэвдэж хоцров. Агшин зуур залуургүй болсон завь давалгааны дээр бүжиглэж гарав. Гэтэл өтгөн нягт манангийн цаанаас их давллагааны

догшин чимээ дуулдав. Давалгаа хучин нөмөрч, салхинд уймарсан ус улам ихээр нижигнэн хуйлраад хөөрөн намалзаж байв.

- Завиа эргүүл, хошууг давалгааны өөдөөс харуул! Гэж Орган цөхрөн бахирав.

Сэлүүрчид завины хошууг долгионы эсрэг амжин харуултал далайн хар салхины түрүүчийн уохилтонд золтой хөмөрч орхисонгүй. Хүчит давалгаа ардаа тэнгисийн усыг хуйлруулсаар өнгөрөхөд манан ч бүрхээд ирэв. Их манангийн хормой усан дээгүүр чирэгдсээр дэргэд ирэхийг үзвэл тулах ч аргагүй, тойрох ч аргагүй амьтай юм шиг айхтар бөөн харанхуй хар юм нөмрөн ирэх нь нэн ч тодхон харагдана.

- Салхи хаанаасаа байсан, салхины чигийг тогтоож аваарай! Гэж Орган хашгирч амжив. Тэд юу юугүй харанхуй манан дотор живэв. Манан уул нурсан адил харанхуйлж, тэднийг цаглашгүй харанхуйн эргүүлэгт хийчив. Нүд ирмэхийн зуур тэд нэг ертөнцөөс ондоо ертөнцөл орчих нь тэр. Юм бүхэн алга болов. Тэр мөчөөс хойш тэнгэр ч тэнгис ч, завь ч үзэгдэхгүй болов. Тэд нэг нэгнийхээ нүүр царайг ялгаж үзэхгүй болов. Тэр мөчөөс хойш тэд амар заяа үзсэнгүй. Тэнгис далай буцлан бургилав. Усны цалгиа, түсэргээнд хамаг хувцас шалба нурууд даагдахгүй болов. Гэвч хамгийн гайтай юм бол өтгөн манан дотор ороод ойр тойрныгоо ялгаж харахгүй, нэг үгээр хэлбэл юу ч харж үзэхгүй болохоор далай дээр юу болж буй түүнээс гарахын тулд явал зохиыгоо мэдэхгүй болж хоцров. Ганцхан завиа хөмрүүлж орхихгүй, ямар нэг аргаар тогтоож бахын тулд сохор таамгаар тэмцэх хэрэгтэй байв. Гуя онгоцоо нэг тийш залж гаргах гэж одоо ярихын ч хэрэггүй болжээ. Догшин адайр давалгаа тэдний давийг хааш нь тууж буйг бүү мэл, хэдий болтол туухыг бүү мэд!

Анчид алсын далайд явж байхад тэнгэр аягүйтэж, тэд чигээрээ алга болох явдал байдаг гэж Кириск урьд өмнө нь дуулсан билээ. Тийм үед эхнэр хүүхдүүд цөм уй гашуудал болж, тэднийгээ гэнэт хүрээд ирэх юу магад гэж дэмий горилохдоо Алаг хав толгойн хажууд хэдэн хоногоор түүдэг гал ноцоон байдаг билээ. Задгай далай дунд амь үрэгдэх гэдэг ямар аймшигтай, ямар зэрлэг болохыг тэгэхэд Кириск дүй багцаа төдий бодож чадахгүй байв. Өвлийн цагт чимээгүйхэн хүрээд ирдэг гэм зэмгүй манан ид хувилгааны сүүн цаган өнгөөр дүнсийгч дэлхий ертөнцийг жигдхэн цуагаан будан зэрэглээгээр бүрхэж, газар дээр оршдог бүхнийг хөлсөлж орхисон шиг агаарт тунгалаг цан хүүрэг тогтоод үлгэрийн сайхныг хүлээх сэтгэлийн дотор яагаад ч юм айдас, алжаал хүрч байхад Кириск ихдэ дуртай билээ. гэтэл тэр манан ийм салдаггүй догшин дайсан болж эргэдэг гэж Кириск бодоогүй явжээ. Чангаран гаарах тэнгисийн дээгүүр бөөн бөөн харанхуй хар манан эрчлэн хуйлран, задран нийлэн гулган хөвөх нь могой мурилзаж байсантай адил ажээ.

Кириск суудлаасаа зуурч, айхдаа Орган өвгөний хөлд наалдан чичирч байв.

- Чи надаас бариад яв. Бөх барь гэж өвгөн хүүгийн чихэнд хэлэв. Онодоо юу ч хэлж чадсангүй, юу ч хийж чадсангүй.

Тэдний хэн нь ч Кирииск хүүгийн хувь заяаг хөнгөжл чадахгүй бхйв. Яагаад гэвэл байгалийн тэр догшин аюулын өмнө ав адилхан эрстэх байлаа. Тэр ч байтугай Кирииск хүү улийж, бахирч эцгийгээ дуудлаа гэхэд Эмрайн байрнаасаа босож очиж чадахгүй байлаа. Учир нь гуя онгоц зөвхөн түүний хүчинд дулдуйдан тогтож байв. Эмрайн Мылгун хоёр давалгааны уулзан салахыг зүг таамгаар мэдрэн сэлүүрийн хүчээр давь онгоцоо арайхийн тэнцүүлж байв.

Далайн давалгаа нэвтлэшгүй харанхуй манан дотор гуя онгоцыг зогсолтгүй туусаар байв. Завь онгоцыг тогтвортой хэвээр байлгах гэж Орган жолоодож залахыг оролдовч цаашлах тусам далайн хар салхи улам чангарна.

Шөнө дунд хэдийн болсон байж болно. Тэр манан дунд хоног цаг хэрхэн өнгөрч байгааг мэдэхэд бэрх. Зөвхөн манан дотор бүр пад харанхуй болоход сая шөнө болов гэж тэд таав. Бараг амьд гарах горьдлогогүй байсан боловч тэд тэрхүү пад харанхуйн дунд байгалийн давамгай хүчинтэй хэдэн цагийн турш туйлдталаа тасралтгүй үзэлцэв. Тэр хэдэн нивх хүн ямар ч гэсэн тэсэж, далайн хар салхи гэнэт салхилсан шигээ гэнэт намдаж манан арилбал цаашид яах арга бодож болно гэдэг цөхөрсөн горьдлого хараахан алдаагүй л байлаа. Гэтэл нэг удаа тэр горьдлого нь бараг биелж эхлэв. Нэг хэсэг салхи татарсан шиг давалгааны зайлж сэгсрэх нь намдаад ус цалгих, үсрэх нь ч гайгүй болов. Гэвч эргэн тойрон өнөө л хар занар адил тас харанхуй хэвээр! Органы дуу хамгийн түрүүнд тэнгисийн шуугианыг дийлж,

- Би байнаа! Кирииск бид хоёр энд байна! Дуулж байна уу? гэж хашгирав.
- Дуулж байна, дуулж байна. Бид ч байрандаа байна гэж Эмрайн дуугарав.
- Салхины чиг хэн тогтоож авсан бэ? гэж Орган бахирав.
- Тэр ямар ашиг байна? гэж Мылгун ууртай бархирав.

Орган таг дуугүй болов. Үнэндээ одоо тэдэнд салхины чиг мэдээд ямар ч хэрэг байхгүй. Тэдийг далайн давалгаа хааш нь хөөж аваачсан, одоо хана байга, тэдний баттай баримжаа хийдэг арал хол юм уу ойр байгааг тааж мэдэхгүй аргагүй. Тэднийг их хол тууж аваачсан байж болно, тэд сайхь гурван мээмээ хэзээ ч дахин олохгүйболсон байж болно. Орган харанхуй манан, давалгааны сэгсрэлтэнд дарлагдан дув дуугүй сууна. Агуу их Орган хүнд дүнсгэр бодолд дарагдан дуугүй сууна. Аз дайрч болох ганцхан найдлага гэвэл заяаны эрхээр өнөө арлын дэргэдүүр өнгөрч, бүр тэнгисийн эргийн байц хад мөргөж гуя онгоцоо хэмхлэн салж болно. Гэвч тэр гурван арал үзэгдэхгүй, тэнгэрийн од үзэгдэхгүй байхад шөнийн харанхуй манан дунд зүг чиг багцаалах ондоо ямар ч арга байсангүй. Өвгөн ямар нэг санаа оноо хэлэх чадалгүй болжээ. Хэдий тийм боловч нэг хэдий болоод

- Биднийг завиныхаа хошууг давалгаа өөд харуулахад салхи Тланги-ла байсан даа гэж хашгиран хэлэв.

Гэвч хэн ч хариу дуугарсангүй. Сэлүүрчид, дуугарах ч завгүй байв. Орган дахин дуугай болов. Кирискийн хамаг бие дагжин чичирч өвгөний хөлд наалдан суув.

- Кирииск бид хоёр завины утгасан ус жаахан юулүүд орхиё. Та нар завиа тогтоогоод бай гэж өвгөнн сануулан хэлэв. Орган харанхуй дотор Кирискийг тэмтрэн үзээд зүв зүгээр сууж байхад,
- Кирииск чи бүү ай, хоёулаа завинд юүлсэн ус асгя, тэгэхгүй бол муу юм болно. Ганц ховоогоо би энэ оллоо, чи шанагаа аваад утгавал дээр... Чи юмнаас барьж байна уу? Шанагаа ав гэж байна.
- Аткычх аа, би юмнаас барьж байнаа. Хэдий болтол ингэж явах юм бэ? Би айгаад байна!
- Би ч йаж байна. Гэхдээ бид бол эр улс ингэж явах учиртай ул...
- Бид живчихгүй юу? Аткычх аа!
- Живэхгүй. Хэрэв живэх учиртай бол живж ч болно. Харин чи нэг гараараа надаас бариад нөгөө гараараа завины ёроолын ус шавхаж асга...

Орган цаг тухайд нь сэхээ авсан нь сайн хэрэг. Тэнгисийн хар салхи өчүүхэн амьсгаа авахыг ашиглан завины ёроолд дүүрсэн усыг нэлээн шавхаж амжив. Орган өвгөн тийнхүү таамгаар тэмтрэн шавхаж байхдаа мөнөөхөн бйцхан торхтой усаа Кирискт анхааруулан түүнрий ханцуйнаас татаж

- Кирииск аа, бидний торхтой ус энэ байна. Тэмтэрч үзэв үү? Ямар ч гэсэн энэ торхтой усыг аямгадаж бай. Үүнээс сайн зуурч бариад битгий тавиарай. Явдал болбол амын усгүй хоцорсноос зхсэн нь дээр шүү! Ойлгов уу?... ондоо хэнд ч найдаж болохгүй шүү. Дуулав уу? гэжээ

Орган энэ тухай санаж, жаал хүүд цаг тухайд нь энэ тухай сануулсан нь мөн сайн хэрэг. Тэр нь тун удалгүй жаал хүүд хэрэг болсон билээ.

Далайн салхи шуурга яльгүй намдсанаа дахин сэгсчиж эхлэв. Энэ удаа бүр ч хүйтэй, харанхуй шөнийн мананд юу ч үзэхгүй яваа хөөрхий арчаа тасарсан улсыг далимдуулах гэсэн шиг галзуу юм шиг үлээж гарав. Энэ удаа хүмүүст агшин зуур амсхийлгэснийхээ өшөө хариуг авах гэсэн шиг далайн давалгаа дахин улангасан дайрав. Органы гуй онгоц үл үзэгдэх давалгааны хооронд тал тал тийш хайр найргүй шигдэдэн холбирон холбирон эргэлдэж байв. Ус цалгин завины ирмэгийг давж хагас дундуур ус утгасан завь онгоц живж эхлэв. Орган өвгөн өвдөг дээрээ сөхрөн сууж ганц ховоогоор хичнээн утгавч улам нэмсээр бөйгаа усыг шавхаж барна гэдэг сэтгэшгүй хэрэг байлаа. Гэтэл хоёр сэлүүрчин гэнэт

- Бүх юмаа авч хая! Живлээ! Гэж хорсон сандран бахиралдав.

Кирииск айхдаа чанга уйлсан боловчиг хэн ч дуулсангүй. Хэн ч ртүүнийг анхаарах сэхээ байсангүй. Жаал хүү завины хитгэний мухарт шигдэн бяцхан

торхон дээр хажуугаараа чанга гэгч дарж хэвтээд байдгаараа атийж хамаг биеэ чичрүүлэн уйлав. Ямар боловч жнэ миний хийх ёстой гол чухал ажил мөн гэж Кирист санаж байв. Далайд живж буй гэдгээ Кирииск сайн мэдэж байсан авч нэгэнт тэргүүлэгч Орган хэлснээс хойш яасан ч хамаагүй өнөө устай торхоо хямгадсаар авай.

Бараг тал дундуур живсэн гуй онгоцыг яаралтай аврах хэрэгтэй байв. Мылгун завиа хөмрүүлэхгүй гэж байдаг хүчээ гарган хоёр сэлүүрээр зогсоо зайгүзй галзуу вm шиг сэлүүрдэж байхын хооронд Орган Эмрайн хоёр завинд явсан хамаг юмаа ус руу шидэлж гарав. Ондоо арга мөр байсангүй. Хоёр ангийн буу оосортой төмөр жад, эвхээстэй олс, бас бус юм тэр ч байтугай Органы гуулин данхыг хүртэл усанд хаяв. Мөнөөхөн хав загасыг авч хаях гэдэг хамгийн бэрхтэй ажил байв. Норж хүндэрсэн загас гарт гулгаад ер даагдахгүй болжээ. Түүнийг бүр завины ёроолоос өргөж завины цаад руу өнхрүүлэх ёстой байв. Зориут хэрэг болгож хүн амьтангүй арал хүрч агнасан олзоо авя хаях хэрэг гарав. Орган Эмрайн хоёр аахилан янцаглан бас хараал ширээл тавьж байж өнөө хав загасыг арайхийн завины ирмэг дээр өргөн гаргаж цааш нь өнхрүүлж орхив. Тэнгис далайтай тэгэж зэрлэрг юм шиг үзэлцэж, уймарч сандарч байхад л хав загасны махан хүнд ачаанаас салсан завь онгоц хөнгөрөх шиг болох нь илт байлаа. Магадгүй, энэ явдал уг байдлыг аварсан байж болно.

“”””

“””””

“”””

Орган хамгийн түрүүнд сэрэв. Сэрээд хов хоосон цагаан амна дотор анхандаа хана яваагаа даруй мэдсэнгүй. Эргэн тойрон татсан тэр нэвтлэшгүй бүрэг цагаан юм чухам юу болохыг даруй ухаарч чадсангүй. Тэр цагаан юм манан байлаа.

Тэр цагаан юм бол гадаад их далайн бүх мандал дээгүүр чив чимээгүй бат сууж авсан хязгаар хярхаггүй Агуу их манан байлаа.

Харанхуй манан дотор Орган өвгөний нүд жаахан дасаж харвал завь нь байна, цаадуул нь байна. Эмрайн, Мылгун хоёр суудалдаа сэлүүрийн дэргэд дэрийн хэвтэнэ. Тэд урд шөнө далайн хуй салхитай тулалдсан тулалдаанд нам цохиулсан юм шиг хачин эвгүй гулдайн хэвтэх бөгөөд гагцхүү их л давчуу, тасалдангүй амьсгаалахыг үзвэл эрхбиш амьтай голтой байгаа бололтой. Кирииск хүү өнөө торхтой усаа дараад хөлийн нь дэргэд атийн хэвтээд, далайн чийг, хүйтнээс нойрон дундуу чичирч байв. Орган түүнийг өрөвдөх боловчиг тус болох арга байсангүй.

Шөнийн далайн шуугианд чих дөжирсөн Орган завины хүтгэн дээр буурал тэргүүнээ унжуулан сууна. Өвгөний хамаг бие шархиран өвдөнө. Өнөө булдруу болсон урт гар нь ташуур өлгөсөн шиг сул унжжээ. Орган өвгөн насандаа элдвийн зовлон зүдүүр амсаж үзсэн боловчиг ийм догшин харгис явдлыг үзсэн нь үгүй. Тэр одоо хаана байгаа, далайн хар салхи тэднийг хааш нь тууж

аваачсан, эх газраас хол яваа юу ойрхон яваа юу, тэнгист байна уу, аль эсгүүл бүр гадаад их далайд байна уу гэдгээ огтхон ч мэдэх юм алга. Чухам хэдэн цаг болж буйгч бүү мэд. Тэл ч байтугай битүү суусан харанхуй манан дунд өдөр юм уу, шөнө юм уу мэдэгдэхгүй болжээ. Ер нь далайн хар салхин голдуу өглөө намддагийг бодож үзвэл өдөр болсон байлтай. Үд өнгөрсөн ч байж болно.

Азаар амьд гарав гэж хэдийгээр бөөрөх авч сээхэлзэх юм огтхон ч үгүй. Явуулын нэг худалдаачнаас зуун булганы арьсаар авсан ангийн буунас өгсүүлээд анд авч гарсан хамаг юмаа далайд хаясан болохоор ердөө хоёр хос сэлүүр, бяцхан торхтой ус л үлджээ. Цаашдаа бас юу болохыг бүү мэд!

Сэлүүрчид нойрноос сэрэхээр одоо яахав, ийхэд гэж бүгдээрээ ярилцах болно. Гэтэл тэд аль зүгт хөвж явааг хэн мэдэх юм бэ?

Юуны өмнө үүнийг мэдэх нь чухал байв. Хоёрт үөнө болохыг хүлээж, хэрэв тэнгэр цэлмэг байх юм бол од мичдээр зүг чигээ олох гэж оролдож болох л юм. Гэтэл хэдий болтол ингэж дэмий хөвөх юм бэ? Хичнээн хүч, цаг зарцуулах вэ? Шөнийг хүлээж чадах юм уу, тэсэж чадах юмуу?

Ямар манан гэж тийм байдаг вэ? Тэнгисийн дээгүүр жигтэй өтгөн манан арилшгүй лав суужээ. Газар сайгүй ийм гэж үү? Бүх дэлхий ийм мананд дарагдсан гэж үү?

Тамхи татаж, юм уумаар санагдана. Гэтэл юун тамхи татах, биедээ авч явсан тамхи нь шалба норжээ. Уух ус яах вэ? Идэх юм яах вэ? Орган энэ тухай бодохоос айдас нь хүрч байв. Харин одоохондоо бас ч тэсэж, энэ талаар бодохгүй явюж болохоор байжээ.

Тэнгисийн дээгүүр жигтэй нам гүм, зөвхөн тогтуун ирэлзэн мяралзана. Завь нэг байрандаа завхан үл мэдэг найгалзана. Тэдний завь хаашаа ч хөөгдөх туугдахгүй, хаашаа ч үл хөвнө. Усан дээр орхисон сэлүүрүүд сул хөвж байв. Эмрайин Мылгун хоёр бүр шалчийтлаа ядраад сэлүүрээ татаж авах чадалгүй нойрондоо дийлдэн үхсэн юм шиг унтаад өгсөн нь илт байв.

Өчүүхэн иөдий ч үлээх салхигүй болохоор манан дотор юм бүхэн, чив чимээгүй, юм бүхэн эс хөдөлнө. Тэнгис ч сууж, манан ч сууж завь ч зогсжээ. Одоо хаашаа ч яарах явдалгүй, хаашаа ч хөвөх явдалгүй болжээ.

Өвгөн тийнхүү гуниглан сууж байснаа дахин зүүрмэглэжээ. Түүнийг Кириск сэрээв. Жаал хүү өвгөнийг нударч,

- Өвөө, өвөө! Юм уумаар байна гэжээ

Өвгөн давхийж, хөөрхий нэг угсааны цаад гурав нь түүний гарыг харж суугаа ажээ гэж ойлгов. Орган бол тэдний тэргүүлэгч хүн. Одоо амны ус хуваарилан хувь хүртээх хамгийн бэрх ажил эхлэх нь тэр гэж ойлгов.

Огтхон ч үл хөдлөх өтгөн манан тунасаар байв. Тэнгис далай жигтэйхэн анир чимээгүй дүнсийнэ...

“”””

“”””

“””””

Тэд тэр өдөр үдэш болтол ямар ч зорилгогүй, хаашаа явж буйгаа ч эс мэдэвч яаралгүй хөвсөөр байв.

Тэд нэгэнт сэрж, ямар байдалд орсноо мэдсэн болохоор нэг дор зогсоод байж ямар ч гэсэн чадсангүй.

Ингээд сэлүүрээ өөд татан авч нэг тийш яаралгүй хөвж гарав. Эргийн тийш явж байгаа юм уу аль эсвэл бүр эсрэг чигт улам холдож яваа юм уу бүү мэд!

Гэвч энэ бол нэг ч бүтэлгүй явдал гэдэг нь ил байв.

Ганц найдах юм гэвэл, хэрэв манан арилах аваас цаашид яах ийх нь тодорхой болох байлаа. Ямар ч гэсэн амнан арилах юм бол шөнө од олж харж болно. Юуны түрүүн од мичдээр нэг баримжаа олж авах нь хамгийн чухал байв.

Ондоо нэг горилох юм бол чингэсээр явтал ямар нэг арал тааралдаж юуны магад! Арал тааралдвал чиг баримжаагаа олоход аялбар болно.

Эл учир тэд одоохондоо хав харанхуй манан дунд хаашаа ч хамаагүй таамаг сэлүүрдсээр байв.

Ингэж явах зууг Орган өвгө юу ч гэсэн юм хумыг жаахан өөд татаж эмхэл гэв. Завины ёроолд тунасан усыг тас шавхаж, ямар ч гэсэн хөлийн дор ус шалчигнахгүй болгов. Кирискийг завины хитгэн дээр хажуудаа суулгав. Хүүг тийнхүү бөөрөндөө аваад суувал нэгд дулаан, хоёрт хувцас нь түргэн хатна. Хүн болгонд адилхан жаахан жаахан ус хийж өгөв. Анхны удаад хүн бүрд шанаганы дөрөвний нэгд арай хүрэхгүй хүрэхгүй оногдов. Далайн салхинд ядарч хоносон болохоор ганц удаа ч гэсэн ханатал увал хэрэгтэй л байв. Гэтэл Орган өвгөн одо ундны усыг миний өгсөн цагт, миний хийж өгсөн хэмжээгээо уух хэрэгтэй гэж урьдаас сануулан хэлжээ. Тэр үгээ үнэмшүүлэх гэж бяцхан торхтой усаа өргөн зайлж үзүүлэв. Ус торхны тал дундуур шалчигнаж байв.

Гэтэл санамсаргүй нэгэн баяр болов. Юу гэвэл, өнөө торхтой усаа автал завины хитгэний бүр мухарт суудал дороос хав загасны арьсан ууттай жаахан давсалсан борц гарчээ. Тэд том ууттай идэх юмаа далайд хаясан билээ. гэтэл Мылгуны эхнэрийн замдаа идээрэй гэж өгсөн бяцхан хүүдийтэй борц санамсаргүй үлдсэн байв. Харин арьсан хүүдийд далайн ус юүлж, тэртэй тэргүй их давстай борц улам шорвог болоод аманд хүрэхийн аргагүй болжээ. Гэвч тэр бол ямар ч гэсэн хүнс юм. Хангалттай их ус ундтай байсан бол тийм борц ч уг нь сайхан л даа.

Ам цангахаас айж одоохондоо борцноос хэн ч идсэнгүй.

Хүн болгон гагцхүү манан арилахыг хүлээж байв.

ЧИВ чимээгүй дүнсийх өтгөн манан дотор гагцхүү сэлүүрийн чагтага гунигтай хяхнах чимээ гарна. Тэрхүү ямар ч дуу шуу үгүй, анир чмээгүйн дунд сэлүүрийн чагтаганы хяхнах дуун хэн нэгэн төрөөснө хүн “Би хаана байна? Би хаана байна?” би одоо хаачих вэ” гэж алжаасан янзтай мөргөн залбирч байх шиг сонсдох ажээ.

Хүн болгон гагцхүү манан сарнихыг хүлээнэ....

Гэвч манан сарнисангүй, сарних шинж ч алга. Тэр манан өчүүхэн ч сэвэлзэн эс хөдлөхийг үзвэл, энэ дэлхийд байдаггүй, ямар нэг ондоо, санаанд оромгүй хачин амьтан чийг нэхэшмэл, агаараар амьсгалан нарт ертөнцийн юм бүхнийг, газар дэлхийг, агаар, тэнгэрийг, тэнгис далайг залгиж орхисон мэт санагдана.

Манан дунд дахин шөнө болов. Эргэн тойрон тас харанхуй болж ирэхээр л сая шөнө болов гэж тэд мэдэв. Тэдний дээр од ч алга, тэнгэр ч алга.

Гагцхүү нэг тийш явж байхын тулд дэмий хөвж явах гэдэг хэдийн утга учиргүй зүйл болов.

Тэнгэрт од үзэгдэх болов уу гэж хүн болгон найдан, горьдон хүлээнэ. Цаг мөч тутам хүлээж байв. Салхи гарч, тэр үзэшгүй муу ёрын мананг хөөгөөсэй гэж хүлээнэ. Тэд унтсангүй. Хан хурмастынхаа одыг нээж өгөөч гэж тэнгэрийн сахиусанд залбирав. Гадаад их далайн цаана байдаг их дэлтэй сэгсгэр араатан шиг салхи чи сэрэж үзээч гэж слахины эзэн хаанд мөргөн залбирав.

Гэвч ямар ч нэмэр алга. Тэдний мөргөл залбиралыг хэн ч дуулсангүй, манан сарниж арилсангүй.

Од гарахыг Кирииск мөн ихэд хүлээж байв. Тэнгэрт хүүхдийн тоглоом өлгөсөн адил харагддаг ерийн тэр олон од одоо түүнд юу юунаас илүү хэрэгтэй байв. Өчигдөр оройноос хойш үзэж амссан бүхэн хүүгийн сэтгэлийг донсолгож, айх сүрдэх сэтгэгдэл төрүүлжээ. Хүүхдийн сэтгэл санаа цөхрөх, мохох, эвдрэх гэдэг юухан байхав дээ харла гэж. Гэвч түүнтэй нэг завинд яваа гурван том хүн бүгдээрээ үхлийн өмнө тулгарч ингээд далайн аялал төгсдөг байжээ гэж санагдаж байсан үед байгаалийн тэрхүү улангассан догшин аюулыг тэсвэрлэн давсан явдал ямар ч гэсэн амь мэнд гарах арга мөр олдож болно гэсэн сэтгэлийг жаал хөвгүүнд төрүүлжээ. Гагцхүү тэнгэрт л од үзэгдэх юм бол тэдний зовлон эцэс болно гэж хүү бат итгэж байв.

Гагцхүү од бушуухан үзэгдээсэй тэгвэл эх газар руугаа, Алаг хав толгой руугаа бушуухан буцфах юмсан. Юу гэвэл жаал хүү тун ч цангаж тун ч өлсөж, юм уух юмсан, юм идэх юмсан гэж тэсгэлгүй хүсэж байв. Цааш явах тусам улам өлсөж улам цангаж, гэртээ харих юмсан, ээж дээрээ очих юмсан, төрөл садан дээрээ очих юмсан, утаа үнэртсэн гэр орондоо харих юмсан өвс ногоог дээрээ очих юмсан гэж тун ч хүсэв.

Шөнөжин тийнхүү тарчлан хүлээвч ондоо болсон юмгүй, манан ч хөдөлсөнгүй, тэнгэрт од мичид ч гарсангүй, тэнгисийн дээгүүр өнөө л пад харанхуй манан.

Шөнөжин учиргүй ам цангаж, хэдийгээр чийгтэй, жихүүн байвч Юм уухыг нэн ч хүсэж байв. Кирииск би л ганцаар юм уух юмсан ингэж тарчилж явна даа гэж бодох авч бусад нь мөн жигтэйхэн цангаж маш зовж явжээ. Гэвч кирииск бусдаас илүү ихээр цангаж юм уух юмсан гэж бусдаас илүү тэсгэлгүй хүсэв.

Гэтэл ахлагч Орган ус хийж өгсөнгүй Кириск аргаа бараад жаахан ус хийж өгөөч гэж гуйсанд

- Өгөхгүй, унд уух болоогүй тэс! Гэжээ.

Давстай борц идсэнээс хойш хичнээн их цангаж явааг Орган өвгөн мэддэг ч болоосой. Кириск, Кирискийн эцэг, Мылгун гурав анхандаа нэлээд тэсэж явсан ыболовч орой тийшээ тэсэлгүй өлсөөд өнөө борцноос жаахан хэмлэсэн билээ. Борц идэхдээ жаахан ус уусан боловч юу ч болсонгүй, харин нэг хэдий болсон хойно улам айхтар цангажээ. Гэтэл Орган өвгөн тэсээд борцонд ам хүрсэнгүй бас авч явсан усаа гамнаад өөрөө балга ч ус уугаагүй билээ. Тэр өдөр Органаас бусад нь өглөө үдэш хоёр удаа ус уув. Үдэш нь тун бага, зөвхөн шанаганы ёроолоор жаахан ус уужээ.г Торхтой ус улам улам бага болсоор байв.

Шөнөжин тийнхүү тарчлав. Өнөө царцанги манан огтхон ч хөдөлсөнгүй хонов.

“””””

“””””

“””””

Маргааш өглөөнь бас л бахь байдаг янзаараа. Нэгэнт өдөр болсон тул бор саарал манан дотор арай гэгээтэй, арай уужуу юм ши г болов. Тэд бие биеийнхээ нүүр амыг ялган харж болмоор болов. Эргэн тйоронхэдхэн алд газар мөнгөн ус адил гөлгөр тогтуун ирэлзэж бүдэгхэн гялтганана. Далайн ус тийм тогтуун байхыг Кириск хэзээ ч үзээгүй билээ.

Гэтэл тэр өглөө томцуулын нь царай айхтар ондоо болсныг үзээд Кириск машинд гайхав. Тэд цөм айхатвар царай алдаж, арзгар ширүүн сахал үс ургаад нүдний нь гал бөхөж гархиран, бузар аюултай өвчин туссан юм шиг болчжээ. Аав нь их эрдүү бие чийрэг хүн гэхэд бүр айхтар ондоо болжээ. Ердөө бавгар сахал л үлджэ. Уруулаа зуусаар хөх няц болгож орхижээ. Ялангуяа Орган өвгөн улам бөгцийж, улам цонхийж, өнөө хурц төвөнхтэй хүзүү нь улам сунаж урт болоод нүдний нулимс улам ихээр гүйлгэнэн бүр больж хоцорчээ. гагцхүү харц нь хэвээрэ үлджээ. Овгийн ахлагчийн мэргэн, ширүүн харцанд нэг л учиртай, гагцхүү өөрт нь илэрхий хүртээлтэй нэг юм нуугдаж байх нь харагдана.

Өглөө болмогц өнөө балга усаа хуваах гэж нэг бэрх ажил эхлэв. Орган аанай өөрөө аягалав. Тэр сайхь бяцхан модон торхоо сугандаа хавчуулан шанаганы ёроолд нарийхан гоожуулж байхад гар нь учиргүй чичирч үзэгдэв. Хамгийн түрүүнд Кирискт өгөв. Кириск ч тэсч ядан хүлээж байв. Шанаганы ирмэгт шүд нь таг таг хавшиж байв. Уснаас хэд балгатал гол дэвтэх шиг нэг агшин зуур сайхна болж, өнөө дотор халуу шатаж байсан нь намдаад толгой сэргэж ирсэн атал хоосон шанагаа буцаан өгөхийн төдий дотор нь ямар нэг араатан орчоод маажиж бйасан шиг дахин халуу оргиод иржээ. Дараа нь Мылгун уув. Дараа нь Эмрайин уув. Тэдний уухыг харахаас аймаар байжээ. Салганасан гараар шанагтай усыг шүүрэн авч ганц мөснө хөнтөрч, Органы нүүд өөд харалгүйгээр савыг буцаан өгч байв. Ундны ус тийм бага болсон нь тэдний

буруу юм шиг харагдав. Гэтэл Органы ээлж болоход өвгөн өөртөө дусал ч ус хийсэнгүй, дуугүй торхоо бөглөж орхив. Энэ бол байж болшүгүй юм шиг Кирискт санагдав. Хэрэв Кириск тэр торхтой усыг мэддэг байсан бол юуны урьд өөртөө дүүрэн дүүрэн шанага хийж ухаан алдталаа ууж орхих байсан бизээ. Тэгэд сүүлд нь юу л болбол болог. Ямар ч гэсэн нэг удаа л ханатлаа уувал барав. Гэтэл орган өөрийнхөө хувийг ч уусангүй. Шанаганы ёроолын шавхрууг ч уусангүй.

Эмрайн тэссэнгүй,

- Аتكычх, та юунд ингэнэв? Адилхан хийгээд уугаач. Та өчигдөр уугаагүй, үхсэн ч сэхсэн ч хамт үхье гэж сөөнгө хоолойгоор хүчлэн хэлэв.
- Би болноо! Гэж Орган хэнэггүй хариулав.

Эмрайн дуугаа өндөр болгож,

- Тэр буруу! Гэхдээ илт эгдүүцэн, -тэгвэл би ч уухгүй! гэв.
- Уучмаар ч юм алга. Хэл ам хийгээд юу хийхэв! Гэхдээ Орган өвгөн та нар яасан ухаан муутай улс вэ гэсэн шиг мушилзан толгой сэгсэрч, өнөө бяцхан торхныхоо тагийг дахин авч шанаганы ёроолд жаахан гоожуулж – Миний орнд Кириск ууг гэв.

Кириск мэгдэж орхив. Цаадуул нь уём луугай болов. Орган шанагатай усаа хүүд сарвайж,

- Май, Кириск, чи уу, Юсм санах явдалгүй гэв.

Хөвгүүн дуугарсангүй.

- Уу! гэж Мылгун хэлэв.
- Уу! гэж Эмрайн хэлэв.
- Уу! гэж Орган өвгөн хэлэв.

Кириск тээнэгэлзэн зогсов. Уг нь үхтэлээ цангаж байх тул тэр хэдэхэн балга усыг ганц мөсөн хөнтөрч орхимоор санадавч зүрхэлсэнгүй.

Кириск хүү оргилсон хүслээ арайхийн дарж,

- Үгүй, аткычх та өөрөө уу гэхдээ толгой нь эргэжээ.

Энэ үгийг сонсоод өвгөний гар салганан чичирч, их л дороос санаа алдав. Харц нь зөөлөрч, хөвгүүнийг тун эелдгээр энхрийлэн таалж,

- Хүү минь, би энэ насандаа ай даа мөн ч их ус уужээ. Одоо чи олон жил амьд явах хэрэгтэй. Яагаад гэвэл... гэж үгээ дутуу орхин, - Кириск чи миний хэлснийг ойлгож байна уу? Үүнийг чи уух ёстой, уу, Миний төлөө битгий санаа зов гэв.

Кириск хүү дахин хэдэн балга ус уутал агшин зуур бас л гол дэвтэх шиг болж, өнөө дотор халуу шатах нв намдаж бие хөнгөрөх аятай болсон авч дороо улам ихээр цангажээ. Энэ удаа айхтар нэхшингэ амт амтагджээ. Гэвч тэр ямар хамаа байна. Ямар ч гэсэн зөвхөн ус байвал барав, амны ус байвал барав. Гэтэл тэдний ундны ус улам бага болсоор байв.

Энэхэн үес Орган цаадуулдаа хандаж,

- За та минь, одоо яах вэ? Ингээд хөвөөд байх уу? гэв.

Тэд цөм эргэн тойрныг харж ажиглан баахан дуугай сууцгаав. Гэвч хочр сажингаас цааш нэвтлэшгүй манан, энэ ертөнц дээр ондоо юу ч үзэгдэх юм алга. Эмраийн сая санаа алдан ам нээж,

- Ингэхэд хаашаа хөвөх гэж? гэв. Мылгун яагаад ч юм гэнэт дүрсхийтэл уурлан,
- Хаашаа гэсэнэ чинь юу гэсэн үг вэ? Явна даа, зогсож үхсэнэс явж үхсэн нь дээр гэв.
- Явна уу, нэг дороо зогсоод байна уу ямар ялгаа байна? Ийм манантайд хаана ч хүрэхгүй шүү дээ, ямар ялгаа байна? гэж үгэндээ оруулах янзтай дуугарав.
- Энэ мананг би тоохгүй. Энэ муу мананг чинь тоохгүй. Эндээс явна даа! Хэрэв ямадхгүй гэх юм бол энэ муу ёрын заюийг чинь би одоо хөмрүүлнэ. Тэгээд бүгдээрээ загасны хоол болно доо! Сахалт Эмраийн чи миний хэлснийг мэдэж байна уу, эндээс явна даа, хөвнө дөө! Чи мэдэж байна уу? гэж их л шазруунаар өдөж эхлэв.

Кирикийн дотор аягүй болов. Мылгун акийн өмнөөс ичиж байв. Мылгуны ийнхүү муухай аашглахыг үзвэл эцгээс нь аргагүй л дүү болох нь мэдэгдэж байв. Мылгуны сэтгэлийн дотор, аль эсвэл нэгэ завинаа сууж яваа дөрвөн нивх хүний нийтийн дотор нэг юм аягүйтэж нэг юм болохгүй болж дээ. Цөм бодол, гуниг хоёрт дарагдан дувдуугай болов. Эмраийн уруу харчив. Мылгун ч шуугитал амьсгаадан дуугай болов. Харин Оргөн өвгөн хажуу тийш нэг зүг ширтэх бөгөөд түүний царай мөнөөхөн дөрвөн зүг намайна зовхист суусан дүлий цайвар манан адил барайжээ. Нэг хэдий дуугай сууцгаасны хойно Эмраийн ам нээж,

- Мылгун чи тайвшир, би санаандгүй тэгж хэлж орхижээ. Нэг дор зогсож байснаас явж байсан нь дээр байлгүй яахав. Чиний зөв! За одоо хөдлөе гэв.

Тэд хөдлөв. Сэлүүрийн чагтаг дахин хяхнаж, дахин дөрвөн сэлүүр зэрэг өргөгдөн, уснаа зэрэг бууж, завь хөвж эхлэхэд завины хоёр салаа усан зам чив чимээгүй нийлж байв. Гэвч тэд хөвж байсан биш, нэг дороо зогсоод байсан шиг санагдана. Тэд хэдийгээр урагшлан хөвөвч эргэ тойрон харанхуй манан татсан болохор мухар эргүүлэгт орсон юм шиг нэг дороо эргээд байсан шиг санагдах ажгуу. Энэ байдал дахин Мылгуны уурыг хүргэжээ. Тэрбээр учиргүй ундууцан,

- Энэ муу мананг чинь би тоохгүй, нулимж орхино. Дуулж байна уу, сахалт Эмраийн чи! Үүнээс улам хурдан явахыг би хүсэж байна. Чи олигтойхон хөдөл! Сахалт чи битгий унтаад бай, сэлүүрд, дуулж байна уу?! Энэ муу манан яадаг юм үхсэн хойноо! Гэв.

Мылгун ингэж хэлээд сэлүүрийн дээр улам навтайж

- Алив сэлүүрд, сэлүүрд! Гэж шаардав.

Эмрайн ч цаадахыгаа уурлуулахгүй гэж бодсон боловч сэтгэл хөндүүрлэн мөн тэрхүү ухаангүй нааданд орчив.

Завь улам улам хурдыг олов. Тэд хаашаа явж байгаагаа бүү мэд, юунд явж буйгаа ч бүү мэл ямар ч гэсэн манан дундуур ухас ухасхийн сэхээ сэтгээгүй хурдалж гарав. Эмрайн, Мылгун хоёр бие биенээс өрсөж зэрлэг юм шиг сэлүүрдсээр байв. Тэд тэр мананг гүйцэж, түүний хязгаар хярхагийг нэвтлэн гарч чадах юм шиг галзуу мэт улангасан сэлүүрдэж байв.

Хөлсөө гоожуулан, нүүрээ улайгасан сэлүүрчид нэгэн үе сэлрүүрийг даллан навтасхийж, нэгэн үе сэлүүрийг хүчлэн татаж өндөсхийн явахад сэлүүрийн хүрз гялалзан, усны түсэргээ ташуу хийсэж, завины хоёр талаар усан шуугьж байв.

Сэлүүрчдийн амьсгаа авах, амьсгаа гаргах, чимээ тасралтгүй сонсдоно.

Урд ч манан, ард ч манан, эргэн тойрон манан!

Мылгун хахиран нулимж байсан шиг

- Хана, хана гэж ундууцан бахирч байв.

Кирииск анхандаа завины хөдөлгөөнд хууртан сэтгэл сэргэж ирсэн боловч түргэлээд түргэлээд ямар ч ашиггүй харин ч аймшигтай болохыг даруй мэдэв. Жаал хүү айж, тэр утгагүй цуралдааныг зогсоох болов уу гэж Орган өвгөний нүүр өөд харав. Гэтэл цаадах нь огт ондоо тийш их л бодол болон харж явав. Явал яаг гэсэн байдал царайд нь тогтжээ. Уйлсан ч юм уу, өнөө нүдний нь нулимс гүйлэгнэсэн ч юм уу нүүр нь нойтон харагдана. Тэр ер юу болж буйг огт мэдээгүй юм шиг завины хидгэн дээр огтхон ч хөдлөхгүй сууна.

Тэд хаашаа явж буйгаа ч мэдэх юмгүй юунд явж буйгаа ч мэдэх юмгүй манан дундуур ухаан жолоогүй хөвсөөр байв.

Манан дунд Мулыгун

- Хана хана! Хана хана! Гэж цөхрөн хашгирсаар явав.

Тэд ийнхүү нэлээн удаан явав. Гэтэл яваандаа сэлүүрчид цуцаж амьсгааан, завины хурд буурсаар удалгүй тэр хоёр багтартлаа амьсгааадан сэлүүрээ орхив. Мылгун уруу харан суув.

Тийнхүү дэмий шавдсанаа сая ухаарчээ. Өнөө мананг ч нэвтлэн цаана нь ч гарсан юмгүй. Усан дээгүүр өнөө л тогтуун ирэлжээ. Мяралзан, өнөө л нэвтлэшгүй харанхуй манан татсаар байв. Харин тэдний завь эрчиндээ хөвсөөр эргэлдсээр байлаа.

Тэд юунд хүрэх гэж, яах гэж ингэж давхив? Нэг байрандаа байгаад байсан бол яах байсан юм бэ? Ялгаагүй, яах ч үгүй.

Хүн болгон тэгж бодов. Гэтэл Орган сая ам нээж \хоёр хоног юу ч уугаагүй, юу ч идээгүй болохоор тэнхээгээ хайрласан ч байж болох юм\ үгээ их л алгуурхан нэг нэгээр нь зөөж байсан шиг хэлсэн нь:

- За одоо миний үгийг дуулж бай. Энэ манан хэдэн хоногтоо арилахгүй байж болно. Тийм жил байдга. Тийм явдал ч байдаг, та нар ч мэднэ.

Тийм манан долоо найм хоног, заримдаа арваад хоног арилдаггүй. Энэ

ямар нэг тахал юм уу, ер хугацаагаа бодохоос нааш салдаггүй өвчинтэй адил юм. Тэр өвчин хэдий хэрийн хугацаатайг хүн мэддэггүй. Энэ манан хэрэв тийм манан бол бидний хувь заяа нэлээд бэрх болно. Борц маань тун ч жаахан үлдлээ. Усгүй бол борцны ч хэрэг юу байхав. Гэтэл ус маань ердөө өдийхөн үлджээ гэж бяцхан торхоо зайлж харуулав. Торхны ёроолд хэдхэн хуруу ус үлдсэн бололтой шалчигнаж байв.

Хүн болгон дуугай болов. Өвгөн ч дуугай болов. Өвгөн юу гэж хэлэх гэж байгаа нь тодорхой байлаа. Болж өгвөл манан сарнитал хэд хоног тэсэхийн тулд өдөрт шанаганы ёроолоор нэг удаа ус өгнө шүү гэж лав хэлэх байх. Харин тэнгис далай нээгдэж од юм уу нар үзэгдэх юм бол цаашид ямар байдалтай болох нь аяндаа тодорхой болод явчихна. Аз дайрч, гэнэт эх газартаа хүрч ч юун магад. Гэтэл үнэндээ тэдний бодсон ёсоор болов. Ондоо арга мөр яахин байх билээ! Тэс гэдэг үгийг хэлэхэд амархан, тэс гэдэг үгийг хүн оюун ухаанаараа хүлээн авч болно, гэтэл бие мах бод нь яасан ч хүлээж авахгүй шүү дээ. Гэтэл тэгж тарчилж яваа улс ердөө одоо л юм уухыг хүсэж байв. Тэгэхдээ шанаганы ёроолоор биш, бүр ихээр тун ихээр уухыг хүсэж байна.

Тэр аргагүй гэдгийг Орган ойлгож байсан тул бусдаас илүү их зовж байв. Өвгөн бол бүр хасаар байтал хатаж хоцров. Өвгөний дотор хосроод нугалаа, үрчлээ суусан бараан хүрэн царай нь цаг тутам улам тас хар, улам ширүүн болсоор байв. Нэгэнт нөмөрсөн зовлонг тэсвэрлэх гэж биеэ албадах бол өвгөнд тун ч амаргүй байлаа. Гэвч ухаан бодлоо алдаагүй явсан болохоор үндэс нь үхсэн мод хэрхэн тэсэж босоо байдагчлан тэсвэрлэж байв. Гэвч яаж тийнхүү удаан тэсвэрлэх билээ. Цаадуулыгаа аврахын тул бага ч гэсэн ямар нэг хэрэгтэй үг хэлэх нь чухал байв. Эл учраас өвгөн үгээ залгаж,

- Би бодлоо, одоо үрглэж дээшээ хараа тавьж, чих тавьж умард туйлын агукук гэдэг ууль нисэж явна уу гэж ажиглаж байх хэрэгтэй. Ганцхан тэр шувуу л ийм манантай үед далай дээгүүр нисэж чадна. Хэрэв бид эх газар, арал хоёрын хооронд яваа бол тэр шувуу л бидний замыг зааж өгнө. Ямар ч шувуу тэнгис далай дээгүүр нисэхдээ огт тийшээ хазайхгүй, шулуухан нисдэг юм. Агукук ч ялгаагүй гэв. Мылгун уруу харсан хэвээр,
- Бид эх газар арал хоёрын хооронд биш шал ондоо газар явж байвал яах билээ? гэж гунигтай асуув.
- Тэгвэл бид тэр шувууг олж харахгүй дээ гэж Орган маш тайван хариулав.

Тэр шувуу яагаад ямар хэрэгтэй далай дээгүүр нисдэг вэ гэж Кириск сонирхон асуух гэтэл Мылгун өрсөж,

- Агукук шудуу бидний дээгүүр нисэхээ мартаж орхивол яадаг билээ? аан? гэж гунигтайгаар мушилзан – Тээ тэрүүгээр ондоо газраар нисэн өнгөрвөл яах вэ? гэв.

- Тэгвэл бид тэр шувууг олж харагүй дээ гэж Орган бас л тайван хэлэв.
- Тэгвэл бид тэр шувууг олж харагүй дээ гэж Орган бас л тайван хэлэв.
- Тэгвэл бид олж харахгүй гэсэн үг үү? Тэгэхлээр бид яалаа ч гэсэн олж харахгүй болж байна уу? Тэгвэл бид энд ёрдойж байхын хэрэг юу байна? гэж Мылгун улам ихээр бухимдан өгүүлээд тас тас хөхөрч дуугай болов. Хүн бүхний дотор аягүй болж яах ийхээ мэдэхгүй таг дуугай болцгоов.

Энэхэн үед Мылгун нэг юм бодсон бололтой ухасхийн босож, завины сэлүүрийг чагтагнаас нь ганцхан алгадан суга татаж аваад завины хошуун дээр очиж сэлүүрээ барьж тэнцэн ядаж зогсоход түүнд хэн ч юу ч хэлсэнгүй. Мылгун хэнд ч хандалгүйгээд,

- Хүүе чи өлөгчин Хүүе чи салхины бөө удган аа Чи үхсэн нохойны сэг биш, үнэхээр салхины эзэн юм бол тэр салхи чинь хаана байнаа? Аль эсгүүл чи ичээндээ бүтэж үхэв үү өлөгчин минь, аль эсвэл орчлон ертөнцийн хамаг эр ноход цуглуулаад алинтай нь нийлэхийгээ мэдэхгүй болов уу, аль эсвэл цөмтэй нь толгой даралан нийлээд салхиа тавих завгүй болов уу? Аль эсвэл чи энд биднийг манан дотор нүхэнд орсон юм гшиг үхлээ хүлээгээд сууж байгааг мартаж орхив уу өлөгчин! Аль эсвэл чи, бидний хамт нэг бага хүү явааг мэдэхгүй байна уу?! Яаж ингэж болох вэ? Энэ хүү юм уухсан, ус уухсан гээд байнаа! Ус гэж ойлгоно уу? Энэ бидэнтэй яваа хүү далайд анх удаа явж үзэж байгаа юм гэж би чамд хэлж байна. Гэтэл чи биднийг яаж байна вэ? Энэ чинь шударга явдал мөн үү? Чи далайн нохойн үсхий Хоншоор биш, үнэхээр салхины эзэн хаан юм бол түүнийгээ харуул? Салхиа явуул! Дуулж байна уу? Энэ манангаа хурааж хумиж ав. Миний хэлэхийг дуулж байна уу? Шуурга, тлангила гэдэг хамгийн аймшигтай шуурга илгээж, биднийг тэнгист хөмрүүлж орхи, биднийг далайн давалгаа хамаж аваад яваг, муухай өлөгчин! Чи дуулж байна уу? Миний хэлэхийг дуулж байна уу? Би чамайг тоохгүй, сэгсгэр муухай хоншоор дээр чинь нулимж, шээж орхино! Хэрвээ чи салхины эзэн юм бол шуурга тавьж биднийг тэнгист живүүлж орхи! Биш юм бол чи адгийн муу өлөгчин гичий мөн. Харин би бол эр нохой, бас нэг эр нохой, гагцхүү чамтай нийлэхгүй май, май, чи энэ байна, май, май, хаз! хаз! Гэж харанхуй манан дотор сэлүүр далайн байдгаараа хашгирав.

Мылгун тэр слахины эзэн гэдэг хаана байдгийг үзээгүй, түүний эрх мэдэлд байдаг тэр салхи хаана нуугдаж байдгийг үзээгүй мөртлөө салхины эзэн гэдгийг тийнхүү харааж гарав. Тэр салхины эзэн гэдгийг тийнхүү доромжлохын хамт бас гуйж хоолойгоо сөөтөл, тэнхээ бартал удаан бахирч байгаад ухаан балартжээ.

Мылгун өнөө сэлүүрээ далайд хол шидэж орхиод байрандаа сууж алгаар нүүрээ даран гунигтайгаар, аймшигтайгар цурхиран уйлав. Цаадуул нь яах ч

аргагүй таг дугай байхад Мылгун нус нулимсандаа хахан цацан, бага хүүхдүүдээ нэрлэн дуудан зөндөө уйлав. Кирисктом эр хүн уйлж байхыг хэзээ ч үзээгүй тул ихэд мэгдэн айж, нүдний нулимс гүйлгэнүүлэн Органыг харж,

- Өвөө, өвөө! Ах юунд инэгж уйлж байгаа юм бэ? гэв. Орган өвгөн хүүгийн гарыг атгаж,
- Бүү ай. Гайгүй болно. Мөд уйлахаа болино. Энэ тухай чи бүү юм бод, энэ чамд хамаагүй. Одоохон гайгүй болно гэж хүүгийн сэтгэлийг засав.

Мылгун үнэхээр гайгүй болсон боловчиг нүүрээ дарсан хэвээр өмөлзөж байхад дал мөр нь салганан чичирсээр байв. Эмрайн завиа залж, усанд дээр хөвж явсан сэлүүрийг авч байранд нь чагтаганд нь углаад, их л өрөвдсөн янзтайгаар

- Мылгун чи тайвшир! Энэ мананд үйлээ үзэж явснаас далайн шуурганд дунд явсан эь дээр гэдэг чиний долоон зөв. Юу ч гэсэн жаахан харзняя, гэнэт цэлмэж ч юунаа магад. Ондоо яах вэ дээ... гэлээ. Мылгун хариу юу ч дуугарсангүй. Дээшээ харахас айж байсан шиг улам доошоо навтайн толгойгоо улам доош гудайлгаад сууж байв.

Гадаад их далайн дээгүүр өнөө л элин халин манан татаж ертөнцийн юм бүхнийг халхалсаар бөайв. Ямар ч салхи гарсангүй, ямар ч өөрчлөлт орсонгүй. Мылгун мөнөөхөн салхины бөө удганыг хичнээн бахирч, хичнээн харааж зхсэн боловч өнөө салхины бөө гэдэг нь ямар ч гэм зэмгүй юм шиг хөдөлсөнгүй. Тэр ч байтугай хилэгнэсэн ч үгүй, салхи хөдөлсөн ч үгүй, шуурга тавсан ч үгүй.

Эмрайн нэг байрандаа зогсохгүйн тулд сэлүүрээ аяархан хөдөлгөж байхад завь усан дээгүүр бараг үл мэдэг гулгав. Орган өвгөн таг дуугай өнөө хүнд дүнсгэр бодолдоо дарагдан сууна. Магадгүй, амьдралдаа эцсийн удаа өнөө Загас-эхнэрээ бодож явж ч болно.

Гэтэл Кириск хүү гэнэт

- Өвөө, Умрын ууль яагаад арал тийш нисдэг вэ? гэж аяархан асууж өвгөний сайхи гунигт бодлыг тасалжээ.
- Нээрэн, чамд ярихыг мартсан байна. Ийм их манантайд далай дээгүүр ганцхан агукук нисэж чадна. Агукук ан барихаар арал руу нисдэг юм. Заримдаа хав загасны жижигхэн зулзагыг ч шүүрнэ шүү. Агукук харанхуй манан, харанхуй шөнө ч өдөр адил хардаг айхтар хурц нүдтэй шувуу. Тийм ч учраас ууль гэдэг. Хамгийн том, хамгийн хүчтэй шувуу юм гэв.

Кириск

- Би тийм хурц нүдтэй болох юмсан! Тэгвэл би одоо аль зүгт хөвж явааг даруй харж, нутаг газартаа бушуухан харьж зөндөө ус уух юмсан! Би тийм нүдтэй болоосой... гэхэд Орган санаа алдаж
- Ай даа, амьтан болгонд онд ондоо нүд заяажээ гэв.

Хоёулаа дуугай болов. Гэтэл нэг хэдий болсон хойно Оргон өнөө яриагаа үргэлжлүүлэх гэсэн шиг хүүгийн нүүр өөд харж

- Чи тун зовж явна уу? Тэсэж үз. Чи одоо л тэсэж чадвал том анчин болно. Хүү минь тэсэж үз. Ус гэж битгий бод, ондоо юм бодоод яв. Юм уухсан гэж бүү болдоод бай гэжээ.

Кириск хүү өвгөний үгэнд орж ус гэж бодохгүйг хичээвч болж өгсөнгүй. Бодохгүй гэж оролдох тусам улам ихээр цангаж байжээ. Гэдэс өлсөж байгаа гэдэг жигтэйхэн, дотор нь муухай болж байв. Түүнээсээ болоод Мылгун дэлхийгээр нэг орилж бахирмаар санагдаж байжээ.

Тэр өдөр ингэж өнгөрсөн. Гэтэн алсаас далайн давалгаа шуугин ариун сайхан салхи үлээж, тэр муухай мананг ертөнцийн нөгөө хязгаар руу хөөж орхих болов гэж цөм цаг тутам хүлээж, цаг тутам горилон явав. Тэгвэл тэдний аврагдах зам мөр нээгдэх болно. Гэтэл тэнгисийн дээгүүр анир чимээгүй огтхон ч үгүй, ер үхсэн юм шиг болж байв. Үргэлжийн дөрвөн цагт гагцхүү юм уухсан гэж зогсоо зайгүй бодож явав. Хязгаар хярхахгүй гадаад их далайн дунд цангаж үхэх гэдэг гайхмаар хэрэг байлаа.

Үдэж тийшээ Мылгуны бие муудаад үг ч ярихгүй болж, нүд нь жигтэй гөлийв. Хоолойг нь дэвтээхи йгн тулд жаахан ус хийж өгөхөөс аргагүй болов. Гэтэл Кириск бас бүлтэлзээд байхад Орган тэссэнгүй, шанаганы ёроолд жаахан дусааж өгөв. Дараа нь Эмрайинд ч жаахан хийж өгөв. Харин өөрөө бас л дуслын төдийд балгасангүй. Энэ удаа жаахан устай торхоо бөглөн суудал доогуураа хийгээд огтхон ч цангаагүй, огтхон ч тэнхээ алдраагүй юм шиг огт хөдлөлгүй их л удаан суув. Байц хадны оройд суугаа ганц шонхор адил огтхон ч дуу гарахгүй, огтхон ч хөдлөхгүй сууна. Тэр цаашид юу болохыг хэдийн мэдэж байв. Эл учир зоригоо хөвчлөн амьдралынхаа сүүлчийн явдлын өмнө үлдсэн тэнхээгээ хэвээр хадгалан байхыг боджээ. Тэрхэн үед харин гаанс тамхигүй онц гачигдаж байжээ. Гаансаа нэрж утаа баагиулан байж өнөө Загас-эхнэрийнхээ тухайд бодож явах гэж нэн ч хүсэж байжээ.

Агуу их Загас – эхнэр чи хаана хөвнөм?

Орган өвгөн хэр хэмжээгээ мэдээж байв. Ер насан эцэслэхийн босгон дээр очиход хэдий хэрийн тэнхээ хэдий хэрийн нэр хүнд хэрэгтэй болохыг мэдэж байв. Кириск энэ хэдэн өдөр тувт хажууд наалдаж, өмөг түшиг хий жявсан тул өвгөн нэгэт шийдсэн бодлоо түр азнан явжээ. Жаал хүүг тун ч өрөвджээ. Гэвч тэр хүүгийн төлөнөө бодсоноороо болох хэрэгтэй байлаа....

Тэргүүлэг оргөн амьдралын хамгийн сүүлчийн баяргүй урт өдөр ингэж өнгөрөв.

Хэдийн үдэж болж дахин нэгэн шөнө эхлэв.

Гэтэл тэр шөнө бас л бахь байдгаараа хонов. Тэнгис далайн дээр өнөө айхтар мана бас л зууралдсан хэвээрээ хонов. Бас л таг чиг харанхуй үдэш болж, өнөө тэсэшгүй урт шөнө, өнөө л тэсэшгүй аймаар шөнө болох янз илэрхий. Гэтэл шөнө дунд гэнэт далайн шуурга ч бай, юу ч бай, салхи тавьж тэнгэр цэлмэж од харагдвал юу болно. Гэвч тэгэхийн ямар ч шинж тэмдэг алга байв. Далай дээр ямар ч давалгаа үүсэх шинж тэмдэггүй, агаарт ямар ч салхи үлээх

шинж тэмдэггүй, өнөө л эцэс төгсгөлгүй нам гүм, өнөө л эцэс төгсгөлгүй харанхуй хэвээр. Гагцхүү харанхуйд тгөөрсөн ганц завь өлсөж цангаж үхэн зовон яваа хэдэн хүн манан дунд аяархан эргэлдэж, сураг танаггүй болж бүрмөсөн сөнөхийн дуун дээр болоод байна...

Кириск хэдийд унтсаныг бүү мэд. Тэсгэлгүй цангаж, энэлэн шаналавч их л удаан унтжээ. Цангахын тэр шаналгаа нь үеийн үед гарахгүй мэт санагдана. Тэрхэн үес Зөвхөн ус! Зөвхөн ус хэрэгтэй байна. Ондoo юу ч хэрэггүй. Гэдэс өлсөх нь яваандаа намсан боловч дотор нь битүү зовооно. Харин улам ихээр цангаж, юугаар ч тайлж болшгүй байлаа.

Кириск багадаа нэг удаа хүнд өвчин тусаж, хамаг биений хөлс цутган орондоо хэвтэж байхад яг ингэж ам цангаж байсныг санав. Тэгэхэд ээж нь түүний толгойн дэргэдээс алхам ч холдохгүй, гал дөл адил халуу оргих духан дээр нь үргэлж нойтон жин тавьж, сэмхэн сэмхэн уйлж, ямар нэг залбирал шивэгнэж байсан билээ. тэгэхэд эцэг нь эзгүй, далайд явсан байв. Ээж саань ус өгөөсэй, эцэг маанл бушуухан эргэж ирээсэй гэж хүү машид хүсжээ. Гэтэл аль аль нь биелээгүй билээ. Эцэг нь алс хол явсан эх нь уух юм өгөхгүй хориглож байв. Тэгэхэд чи ямар ч гэсэн ус ууж болохгүй гэж эх нь нойтон алчуураар омголтсон уруулыг нь дэвтээж өгөхөд агшин зуур боловч цангаа гарах шиг болно. Гэтэл дахиад л тэсэшгүй цангана. Эхийн нь хэлсэн нь

- Энхрий хүү минь тэсэж үз. Өглөө болоход бие чинь гайгүй болсон байна. харин “Хөх хулгана, ус өгөөч!” гэж амандаа гуйгаад бай. Тэгвэл бие чинь хөнгөн болно. Энхрий хүү минь хөх хулганыг л гуйгаад бай, хөх хулгана чамд ус авчирч өгөг. Харин сайн гуйгаарай гэжээ.

Тэр шөнө Кириск амь тэмцэн хэвтэхдээ үнэхээр хөх хулгана

гүйж ирээд уух юм өгөх болов уу гэж горилно “Хөх хулгана ус авчирчөгөөч”, “Хөх хулгана ус авчирч өгөөч!” гэж таринийн уншлагыг шивэгнээсээр байж билээ. Сүүлдээ хамаг бие халуу шатаж дэмийрэвч “Хөх хулгана ус авчирч өгөөч!” “хөх хулгана ус авчирч өгөөч!” гэж гуйсаар байв. гэтэл өнөө хөх хулгана хүрч ирэхшүй удахыг яана. Кириск “Хөх хулгана ус авчирч өгөөч!” гэж шивнэн уйлсаар гуйсаар байв. Гэтэл хөх хулгана хүрээд иржээ. Хөх хулгана бол ойн горхины дээр үдийн алдад үүсдэг сэвшээ салхин адил баригдашгүй, сэрүүхэн амьтан байв. Хөх хулганыг сайтар харах гэдэг тун бэрх. Хөх хулгана агаар тэнгэр шиг гүн цэнхэр өнгөтэй юм шиг санагдах агаад эрвээхэй адил дэрвэн нисэж, зөөлхөн арьс үсээрээ хүүгийн хацар нүүр, хүзүү биенд нь хүрч байхад хамаг бие хөнгөрчээ. Хөх хулгана үнэхээр ус авчирч өгч байх шиг санагдан, тэр уснаас Кириск ханаж цадахыг мэдэхгүй их л удаан залгиж байхад эргэн тойрон дандаа ус бургилан, толгой хүзүүг нь шүргин байжээ...

Чингээд өглөө босоход бие хэдийгээр маш сулхан байсан боловч илаарь болж, сэтгэл хөнгөрсөн байжээ. Кириск хүүг маш муу байхад нь тэр нэгэн шөнө

умдаалж, анагааж өгсөн хөх хулганыг Киrisk огт мартаxгүй, их л удаан дурсан санаж явдаг байж билээ.

Киrisk одоо завийн ёроолд ихэд цанган, бие хатаж, дотор шатаж явахдаа тэр тухайгаа санав. Хөх хулгана бас хүрээд ирдэг болоосой! Тэр бээр энэхэн үес, мөнөөхөн умдаалагч хөх хулганад итгэх найдьарыг хүүгийн сэтгэлд ургуулсан эхийгээ туйлын уйтгар, гунигтайгаар бодож явав. Киriskийг тийнхүү юм уухын хүслэн болж, хнүдээр амьсгаадан хэвтэж байхад эх нь түүний хэрхэн тонгойн байсныг өрөвдөн санав. Тэгхээд эхийн нь царайд ямар их гуниг, ямар их үнэнч сэтгэл илэрч байсан гэж санана! Тэгэхэд эхийн сэтгэл машид түгшин, хүүгийнхээ төлөөнөө чадах бүхнээ хийхэд бэлэн байж билээ. Тэгэхэд эх нь дотроо хичнээн их айж, хичнээн мөргөн залбирч байсан билээ. Тэгвэл эх нь одоо юу болж, яаж байгаа бол? Уйлан хайлан, гаслан гэншин, тэднийгээ хүлээн далайн хөвөөнд зогсож байгаа даа... Гэтэл тэнгис далай юугаа хэлэх билээ. Ер тийм гай зовлонд учирсан улсад хэн ч тус болж чадахгүй. Гагцхүү эхнэр хүүхдүүд нь Алаг хав толгойн эгц хажууд түүдгийн гал ноцоож, аз болоход өнөө далайд сураг танаггүй алга бологсод гэнэт гараад ирэх болов уу гэж горилон хүлээж байгаа даа.

Гэтэл цаадуул нь энэхэн үед ямар ч амьдралгүй, пад харанхуй далай дээр эргэлдэн шөнийн харанхуй манан дунд амь гарах эцсийн горьдлого улам барсаар явав. Бүр орчлон ертөнцөд нар гэдэг юм бий болохоос өмнө байсан мөнхдийн манан, тулиурхан гуй онгоцонд үхлийн даваан дээр яваа дөрвөн хүн энэ хоёрын хүчний харьцаа даанч тэнцүүргүй байла. Эд бол гадаад их далайн дунд умдгүй, хоол, хүнсгүй, чигийг заах од үзэхгүй яваа улс.

Нарт ертөнцөд ийм пад харанхуй болдгийг Киrisk хэзээ ч үзсэн нь үгүй, ам цангах гэж имй хату харгис зовлон байдаг гэж Киrisk энэхэн богинохон насандаа хэзээ ч бодсон ч үгүй. Киrisk биеэ барихын тулд урьд нэгэн цагт түүийг умдаалан, эдгээсэн хөх хулганын тухай бодож явав...

“Хөх хулгана ус авчирч өгөөч!” гэж эцэс цуцахыг мэдэхгүй шивэгнэж явав. “Хөх хулгана ус авчирч өгөөч!” Хөх хулгана ус авчирч өгөөч!” гэдэг энэ гайхалтай тарнийг урьд эх нь зааж өгсөн билээ. Хачин гайхамшиг юм болоогүй ч гэсэн Киrisk хөх хулганыг мөргөн залбиран дуудсаар байв. Энэхэн үес хөх хулгана бол түүний итгэл найдвар, амны шившлэг болжээ.

Хөх хулгана ус авчирч өгөөч!

Жаал хүү тийнхүү дотроо үглэн биеэ саатуулах гэж оролдож явахдаа зүүд нойрон дундаа Орган, Эмрайин хоёрын тасархай яриаг эрхбиш чанган нэгэн үе зүүрмэглэж, нэгэн үе сэрж явав. Тэдний яриа хоорондоо маш тасархай, хачин ойлгомжгүйн дээр зарим үгээ хагас дутуу орхиж, зарим үг нь ерөөс эс мэдэгдэх ажээ. Киrisk хүү Органы сүвээнд наалдаад хэвтэж байсан тул түүний үгийг тодхон сонсов. Лрган өвгөн хэдийгээр хүнд хүнд амьсгаадан, үгээ хүчлэн гаргах боловч хоолой ам нь хоржигнох, сөөхгүй их л шургуу ярьж байв. Харин эцэг нь хол, сэлүүрчний суудалд сууж байсан болохоор түүний үг муу дулдаж байв.

- Би танд ямар заах биш, гэвч өвөө та сайн бодоорой. Та бол их ухаатай хүн шүү гэж Эмрайн хэн нэгэн түүний яриаг дуулчих вий гэсэн шиг чин санаанаасаа шивэгнэж байх нь сонсогдоно.

Орган өөрийнхөө саналыг хэвээр баримталж буй бололтой.

- Бодсоон, их бодсон, Ингэсэн нь л дээр гэв. Тэд хэсэг дугай болтол Эмрайн,
- Бид цөм нэг завинд яваа болохоор бид бүхний хувь заяа нэг л байх ёстой гэв.
- Хувь заяа, хувь заяа гэнэ. Хувь тавиангаас зайлж болохгүй гэдэг бол мэдээжийн хэрэг. Гэвч хувь заяагэдэг хүсвэл дагаж эс хүсвэл дагахгүй байж болдог зүйл. Бид нэгэнт гарцаагүй үхэхээс хойш хэн нэг нь бусдыгаа хэд хоног амьд байлгахын тулд үхэхийг яарч бас болноо. Чи өөрөө бод л доо. Ингэж явтал гэнэт тэнгэр цэлмээ гэж бодъё. Тэгээд харин гэж эцсийнхээ хүчийг шавхан, газрын эрэг хөвөө дөнгөж хартал нэг балга ус дутаж үхвэл энэ ухаантай явдал мөн үү? Энэ их гомдолтой явдал болохгүй юу? Орган ингэж их л гаслантай өгүүлэхэд хоолойд нь амьсгаа нь тээгэлдэж байв.

Эмрайн хариуд нь нэг үг хэлсэн боловч дуулдсангүй. тэд ч дуугай болов.

Кириск унтах гэж оролдон өнөө хөх хулганаа дуудсаар л байлаа. Унтах л юм бол хөх хулгана хүрээд ирэх шиг түүнд санагдаж байжээ. Гэтэл нойр эс хүрнэ.

Хөх хулгана ус авчирч өгөөч!

- Мылгун маань яаж байна? гэж Орган асуув.
- Янзаараа л хэвтэж байна гэж Эмрайн хариулав.
- Хэвтэж байна гэнээ гээд Орган жаахан азнаж байснаа, ухаан орохоор нь миний хэлснийг дамжуулаарай гэж сануулав.
- Тэгнээ өвөө! Таны хэлснийг цөмийг ёсорр нь дамжуулна гэхдээ Эмрайны хоолой чичирч хүлчэн ханиалгав.
- Мылгунд хэлээрэй, би түүнийг их хүндэтгэж байла. Мылгун бол мундаг анчин хү. Хүнээр ч муугүй хүн. Би энүүнийг ямагт хүндэтгэн үздэг байсан даа.

Тэд дахин дуугай болов.

Хөх хулгана ус авчирч өгөөч!

Чингэж байснаа эцэг нь нэг үг хэлсэн боловч Кириск огт дуулсангүй. Харин Орган хариуд нь.

- Үгүй хүлээж чадахгүй. Чи намайг харахгүй байна уу? Чадал баргадлаа. Сайн нохой нүднээс хол очиж үхдэг гэдэг. Би өөрөө. Би агуу их хүн байлаа. Үүнийгээ би мэдэж байна. Би дандаа Загас-эхнэрийг зүүдэлдэг байлаа. Үүний учрыг чи ойлгохгүй... Би тийшээгээ одохыг хүсэж байна... гэх нь сонсдов.

Тэд ямар нэгийг ярилцаж байхад Кириск хөх хулганыг дуудсаар л байлаа.

Хөх хулгана ус авчирч өгөөч!

Эцэг нь Органы хажууд дөхөж очоод ярих нь,

- Урьд буга хөллөсөн худалдаачингууд ирж сүх, элдвийн эд арилжсаныг та санаж байна уу? тэгэхэд овор том биетэй нэг өндөр шар хүн холын ямар нэг оронд нэг агуу хүн байсан, тэр хүн далай дээгүүр явган явдаг байсан гэж ярьсан даа. Тийм улс байж дээ... гэнэ.
- Тэгвэл тэр хүн агуу их хүн, агуу их улсын дотроос хамгийн их агуу хүн байх нь дэ. Харин манайд бол хамгийн агуу их нь Загас-эхнэр юм гэж Орган хариу дуугарна.

Кирииск хэдий нь унтсан боловчиг:

- Хүлээ, жаахан бод... гэв.
- Цаг болсоон. Би насалдгаа насалсан хүн... Битгий бариад бай. Би тэсэж чадахгүй, чадал алга.
- Ийм харанхуйд...
- Ямар ялгаа байна?
- Би танд хэлэх үгээ хэлж дуусаагүй байна.
- Үг дуусах гэж байдаггүй. Биднийг үхсэн хойноо ч дуусахгүй...
- Ийм харанхуйд...
- Битгий бариад бай. Тэсэхгүй нь чадал барагдлаа. Би өөрөө...
- Ийм харанхуйд...

Харин та нар жаахан тэсэж үз, тэнд бас жаахан усм бий... гэж ярилцах үгс бүдэг бадаг дуулдаж байжээ.

Нэг хүн том палбигар гараа хүүгийн толгой дээр ачархан тавив. Кирииск хүү нойрон дундуу энэ бол Органы гар мөн гэж мэдэв. тэр бүлээн, ширүүн гар Кириискийн толгойн хэмжээг тогтоож авах гэсэн шиг нэг хэдий барилан үзэв.

“”””

“”””

“”””

Кирииск тэнгис дээгүүр явган явж байна гэж зүүдлэв. Ус олж уухын тулд газрын эрэг хөвөө байх ёстой тэр зүгт ойчих ч үгүй, живэх ч үгүй алхсаар л байв. Эргэн тойрон гайхмаар хачин сайхан харагдана. Хаашаа л харвал энгүй ариун тунгалаг тэнгис цэнхэртэнэ. Нарт ертөнц дээр тэнгис далай, тэнгисийн уснаас ондоо юу ч байсангүй. Зөвхөн тэнгис зөвхөн ус! Кирииск тэр усан дээгүүр хатуу газар явсан шиг алхаж байв. Наран гийж, дөрвөн зүг найман зовхисоос далайн давалгаа алга болж буйг таахын аргагүй.

Кирииск тэнгисийн дээгүүр цорын ганцаар алхаж явав. Анхандаа бушуухан усанд хүрч, цаадуулыгаа дуудах санаатай Орган, Эмрайин сылгун гурваас түрүүлэн гүйж явсан шиг санагдаж байтал нэг мэдвэл орь ганцаараа байв. Кирииск бахирч хашгирч, тэднийгээ дуудсан боловч хэн ч хариу дуугарсангүй. Хүн ч алга, дуу шуу ч алга, сүүдэр ч алга. Тэд хаашаа алга болсныг Кирииск олж мэдсэнгүй. Тэднийг алга болохоор аймшигтай санагдав. Тэднийгээ сонстол

хашгирч чадсангүй. хаана ч аль зүгт газар эс харагдана. Кириск хүү хамаг чадлаа тас барин, хүнд ихээр амьсгаадан тэнгисийн дээгүүр хичнээн гуйвч хаашаа ч хүрсэн юмгүй, нэг л дороо байна. Юм уухсан гэж туйлын их, тэсгэлгүй их хүснэ. Гэтэл дээгүүр нь шувуу нисэж явахыг олж харав. Тэр бол Лувр гэдэг нугас байв. Лувр нугас үүр засах газар эрж, тэнгисийн дээгүүр гангар гунгар ниссэр авч өчүүхэн ч хуурай газар олсонгүй ажээ. Эргэн тойрон энгийн их давалгаа цалгилна. Лувр нугас гаслан энэлэн ийшээ тийшээ эргэлдсээр байв.

- Лувр нугас аа, газар хаана, аль зүгт байнаа? Би юм уухыг их хүсэж байна гэж Кириск хашгирав.
- Нарт ертөнцөд газар гэж хараахан байхгүй, хаана ч байхгүй. Эргэн тойрон зөвхөн давалгаа гэж Лувр нугас хариулав.
- Тэгвэл минийхэмт явсан улс хаана байна? гэж сураггүй алга бологсодоо сураглав.
- Тэд байхгүй, тэднийг эрэх хэрэггүй, тэд хаана ч байхгүй гэж Лувр нугас хариулав.

Кириск ганцаардан үгэр өгүүлж баршгүй аймшигт сэтгэл, гунигт автлаа. Тэндээс харсан зүгтээ гүйж одохгы хүсэвч явах гауар хаана ч үгүй, дөрвөн зүг найман зовхисыг гагцхүү ус, давалгаа хоёр хүрээлжээ. Лувр нугас холдон нисэж, зөвхөн хар цэг төдийхөн үзэгдэв.

- Хүүе, Лурв нугас аа, намайг аваад яваач. Намайг битгий орхиоч, би юм уумаар байна гэж хүү гуйв.

Лувр нугас дуугарсангүй. мөнөөхөн хараахан тогтож бий болоогүй газрыг эрсээр тэнгисийн дээгүүр нисэж одож удалгүй үзэгдэхгүй болов. Харин нар нүд гялбам хурц гийж байв...

Кириск гарч болшгүй гуниг, аймшгийн хүнд бэрхийг эдлэн зүүдэлж, өмөлзсөн хэвээр нүдэндээ нулимстай сэрэв. Уйлж улцайсан нүдээ сэмхэн нээж зүүдэлснээ сая мэдэв. Завь онгоц усан дээр үл мэдэг дайвалзаж байв. Эргэ тойрон хүрээлсэн харанхуй манан яльгүй бор саарал өнгөтэй болжээ. Энэ бол шөнө өнгөрч өглөө болж буйн тэмдэг юм. Кириск хөдөлж,

- Өвөө би юм уумаар байна. Би зүүд зүүдэлсэн гэж амандаа үглэн Орган өвгөн тийш гар сунгав. Гэтэл гарт нь хэн ч тааралдсангүй. Завины хидгэн дээр Органы суудал эзгүй байв.
- Өвөө! гэж Кириск дуудав. Хариу дуу гарсангүй. Жаал хүү өндийж
- Өвөө! Өвөө та хаана байна? гэж сандран бахирав.

Эмрайн ухасхийн завины хидгэн тийш дөхөж хүүгээ тэврэн элгэндээ чанга наалдуулж

- Бүү бахир! Өвөө байхгүй! түүнийг битгий дууд! Өвөө Загас-эхнэр тийшээ одсон гэв.

Кириск түүний үгэнд орсонгүй,

- Миний өвөө хаана байна? Өвөө! Миний өвөө хаана байна? гэж бахирав.

- Чи дуулж бай л даа. Бүү уйл. Тйавшир. Өвөө маань одоо байхгүй... гэж эцэг нь аргадаж ядан – Ганцхан чи битгий уйл. Чамд уух юм хийж өгөөрэй гэж өвөө чинь хэлсэн. Бидэнд жаахан ус бий. Чамайг уйлахаа зогсвол уух юм хийж өгнө. Ганцхан битгий л уйл үз. Одоохон манан арилахаар чи хараарай... гэв.

Кирииск түүний арганд орсонгүй, эцгийн гарыг тавиулах гэж цөхрөн зүтгэхэд завь дайвалзана. Эмрайн яах ч учраа олхогүй болов.

- За бид одоо хөвлөө! Чи харж бай, хөдөллөө! Хүүе Мылгун чамайг бос гэж байна шүү. Сэлье цугаараа гэв.

Мылгун сэлүүрийг авч сэлэв. Завь усан дээгүүр үл мэдэг гулгаж эхлэв. Тэд хаашаа явж буйгаа ч бүү мэл, юунд явж байгаагаа ч бүү мэл аанай нарт ертөнцийн хамаг юмыг харанхуйлан тагласан нэлэнхүй сүүнц агаан манан дотор хөвж гарав.

Тэд шинэ өдрийг ингэж угтав. Тэд одоо завиндаа гурвуул болсон байв.

Хөх хулгана ус авчирч өгөөч!

Кирискийг бага зэрэг тайвширмагч Эмрайн суудалдаа сууж, дөрвөн сэлүүр хөдлөхөд завь арай хурдан хөвж байв. гэвч тэд хаашаа хөвж байгаагаа, юунд хөвж буйгаа аанай эс мэднэ. Орган өвгөнийг алга болсонд сэтгэл ихэд донсолсон Кирииск хүү завийн хидгэн дээр өнчрөн үлдээд бас л гашуудалтайгаар өмөлзөн явав. Эмрайн, Мылгун хочр мөн хүнд их бодолд дарагдан явавч өөрснийгөө, Кирииск хүүг аварч хэрхэвч эс чадав. Ганц арга нь сэлүүрээ бариад л сэлүүрдэх! Чингээд зөвхөн нэг дор зогсохгүй, явж байхын тулд хөвж байв. Цагаан манан дунд тэдний нүүр уарай тас хар харагдана. Энэ гурван хүнийг тойрч гарахын аргагүй их гай зовлон нөмөрчээ. Энэ бол өлсөж цангахын их зовлон юм.

Тэд ганц ч үг дуугарахгүй таг дуугай явцгаав. Үг дуугарахаас айцгааж байв. Нэг хэдий болсон хойно Мылгун сэлүүрийг орхиж,

- Өнөө жаахан усаа хуваа гэж Эмрайн гунигтайгаар хэлэв.

Эмрайн бяцхан торхноос шанаганы ёроолд гоожуулж хүн болгонд хэд хэдэн балга ус өгөв. Муухай үнэртэй, ялзарсан амттай хөгзөрсөн ус байв. Гэвч тэр хөгз амттай ус нь ч одоо тун бага үлджээ. Ердөө гурав дөрөвхөн удаа жаахан жаахан балгах ус үлджээ. Энэ удаа балга ус уув гээд хэний ч амны цангаа гарсангүй, хэний ч дотор уужирсан нь үгүй.

Цаг агаар ондоо болох нь уу, үгүй юу? гэдэг мөнөөхөн мэнэрсэн зовлонт бодолдоо дарагдав. Энэ талаар хэн ч ямар ч горьдлоготой үг хэлсэн нь үгүй. Тэнхэл тамираа барж, тэнхээ тасарсан тэд өөрийн эрхгүй бие сэтгэлээ зөнд нь орхиж, хувь заяа ямараар эргэхийг номхноор хүлээн, үхлийн манан дотор ямар ч зорилгогүй хар аяндаа хөвж байв. Хувь заяа ямараар эргэхийг харахаас ондоо ямар ч арга мөр үлсдэнгүй. Манан улам ихээр дарлан тэдний санал зоригийг бүрмөсөн шантраав. Мылгун ганцхан удаа аягүй чанга харааж үзэн ядах чичирхийлсэн дуугаар,

- Ганцхан манан арилаасай, тэгвэл би үхэхэд бэлэн байна! Би өөрөө ус роу үсрээд орчино! Ганцхан энэ орчлонгийн захыг нэг харах юмсан!
Гэв.

Эмрайн дуугарсангүй, эргэж ч харсангүй. тэр юу хэлэх билээ? Эмродоо завийн дээр ахлагч, тэргүүлэгч нь болов. Гэвч ондоо ямар нэг санал хэлж огтхон ч эс чадав. Явах гээд хаашаа ч явах арга мөр байсангүй.

Цаг нэлээн өнгөрөв. Тэдний завь одоо нэгэн үе зогсон, нэгэн үе урсан, хар зөндөөн хөвж байв.

Амь алдахын аюул занал цаг ирэх тутам нэмэгдэж, үргэжл цангахын хажуугаар гэдэс өлсөх гэдэг жигтэйхэн! Цөмийн тамир тэнхээ бөхөж, бие алдрав.

Кирииск завины хэдгээ дээр нүдээ хагас дутуу аниад хэвтэж байхад толгой нь эргэж, жигтэй хүндрээд заримдаа хонгиносон хоосон ходоодны нь булчин татаж байв. Цаг үргэлж юм уухыг бодно. Ер юм уухын л шунал.

Хөх хулгана ус авчирч өгөөч!

Жаал хүү өнөө умдаалагч хөх хулганыг тарнидан дуудан ядаад түүнийгээ умартахыг хичээн өнөө Алаг хав толгойн ёроолд үлдсэн үлгэрт гардаг шиг хүршгүй хол хоцорсон аж амьдралаа дурсан санаж өөрийгөө саатуулах арга мөр эрэх болов. Гуалин дүнг адил толигор өвст толгой дээрээс хэрхэн гулган нааддаг байснаа санав. Тэр бол тун ч зугаатай сайхан наадан байлаа! Тэр наадан тоглоомд Кирииск хамгийн овтой_ хамгийн тэсвэртэй нь байв. Толгой өөд гүйж гараад тэндээс уулын хажуу руу өнхрүүлсэн гуалин адил биеэрээ өнхрөн ордог байв. Тэгж хөврөхөд хоёр гараа биеийн дагуу сайн шахаж хэвтээд биеэ хөдөлгөж газрын уруу гуалин шиг өнхөрнө. Нэг, хоёр, гурав эргэхтэй зэрэг цааш тогтохгүй аяндаа өнхөрнө. Тэгэхлээр инээд хүрэх гэдэг арга бахйгүй. Хөхөрч гарна даа! Тэнгэрийн хаяа нэг энэтээ талд, нэг тэртээ талд гарч харагдана. Тэнгэрийн үүл эргэлдэж нүд эрээлжилнэ. Ургаа мод унаж байсан шиг эргэлзэн эрээлжлэн харагдана. Юм бүхэн өөдөө гойройтон ойчиж байх шиг үзэгдэнэ. Тийнхүү инээлдэж байхад харин тэнгэрийн нар эгдүүцэн байдаг билээ. Эргэн тойрон олон хүүхэд шуугилдан чарлалдах нь сонсоно! Толгойн уруу тийнхүү улам хурдан хурлан хөврөн өнхөрч явахад хойноос гулсаж яваа хүүхдийн барайсан нүүр, атийсан хөл зэрэв зэрэв харагдан өнгөрнө. Өнхөрч өнхөрч зогсоход чих шуугих гэдэг жигтэйхэн! Зогссоны хойно хамгийн хариуцлагатай үе эхэлнэ. Юу гэвэл нэг, хоёр, гурав гэж тоолохын хооронд амжин босох хэрэгтэй. Тэгэхдээ толгой хэдий эргэвч ойчиж болохгүй. Голцуу хүүхэд болгон ойчоод өгнө. Бөөг инээдэм болно! Бусад хүүхдүүд цөм инээлдэнэ, өөрөө бас инээнэ. Босоод зогсох гэхээр хөлийн длор газар дайвалзаад ирнэ. Харин Кирииск бол эс ойчино. Тэсээд, хичээгээд хөл дээрээ тогтоод байна. Музлук охин ямагт хамт явдаг болохоор түүний дэргэд зарим сул дорой хүүхэд шиг ойчоод өгөхийг огтхон ч хүсдэггүй байв.

Хамгий сайхан, хамгийн зугуутай юм гэвэл уулын уруу Музлуктэй хамт өнхрөн буух явдал байв. Жаахан охид бас гулгаж чадна. Гэхдээ тэд их аймхай заримдаа гэзгээрээ ямар нэг юманд орооцолдож тээглэнэ. Гэвч түүнийг огтхон ч эс тоох агаад тийм наргиантай нааданд нүүр амаа шалбалахгүй гарах ч гэж байхгүй л дээ.

Кириск уулын нуруу Музлуктэй өнхрөхдөө түүнээсээ хол түрүүлэхгүй тул тохойгоо үл мэдэг тулж зориуд явдлаа удаашруулна. Тэд уулын уруу нэгэн зэрэг өнхөрч явахад бусад хүүхдүүд учиргүй инээлдэн шуугилдах агаад уулын ёроолд ороод хоёулаа мөнөөхөн “гурав” тоолохын хооронд нэгэн зэрэг хөл дээрээ босно. Тэгэхэд Музлукийг түшиж, хоёр хөл дээрээ тогтоход нь дэмжээд өгөх шиг сайхан жаргалан байхгүй. Үүнийг хэн ч тааж мэддэггүй байв. Тэд бие биенээ тулсан болж, өөрийн эрхгүй тэврэлдэн авна. Тэгэхэд Музлук жигтэй зугаатай чанга инээх бөгөөд уруул нь даган баясмаар сайхан харагддаг билээ. Музлук бол ямагт Кирискээр түшүүлэхийг бодно. Тэр толгой эргэн ойчих гэж буй дүр эсгэхэд Кириск ямагт шүүрэн авч тэврэн хоёр хөл дээр нь тогтоох учиртай байв. Тийнхүү үл мэдэх жаргалыг эдлэн, айж ичиж амраглахын сэтгэл зовиуртайг хэн ч тааж эс мэднэ. Нимгэн даавуу бошинзын цаана Музлук охины зүрх жигтэй чанга түг түг цохилох бөгөөд түүний биенд хүрэхэд дөнгөж сая урган буй жижигхэн хатуу хөх гарт нь хүрэхийн төдий Музлук охин цочиж Кирискийн биед улам түргэн наалдахад толгой эргэж манарсан нүдэнд нь далд битүү гэрэл бадардаг авай. Бүх хорвоо газар дэлхийд, тэнгэрт байдаг юм бүхэн тэдний үл иасалдах инээдэм, жаргалын дотор хамт хөвөн эргэлдэх ажгуу. Энэ бол ямар их гайхмаар аз жаргал байдгийг хэн ч тааж эс мэднэ.

Гэтэл нэг удаа тэр омгийн. Кирискээс арай ах нэгэн увайгүй зэвүүн хүү олж мэджээ. Юу гэвэл тэр хүү газрын уруу өнхрөөд толгой эргэн хөл дээрээ тогтож чадахгүй хүний дүр үзүүлэн Музлукийн дээрээс тэнэг юм шиг дарж унадаг болов. Музлук түүнээс хөндийрөн зугтаах боловчиг цаадхи нь толгой эргэн ойчих гэж буй дүр үзүүлэн хойноос нь хөөж очоод дээр нь даран уна. Кириск түүнтэй зодоо хийв. Цаадхи нь биеэр том учир хэд хэдэн удаа цохив. Гэвч Кириск бууж өгсөнгүй, дүндээ л дүн болсон доо. Кириск ямар ч гэсэн Музлук охиныг түүнд өгөөгүй билээ, тийм явдал ердөө ганцхан удаа болсон билээ....

Тийнхүү тоглож тоглож, халууцаж хөлрөөд горхин дээр очиж ус уух ч бас л жаргал даа.

Хөх хулгана ус авчирч өгөөч!

Ая, хөх хулгана ус авчирч өгөөч!

Тэнд ойрхон нэгэн горхи урсана. Тэрхүү ойн горхи яг хүүхдүүдийн тоглодог тэр тушаа ил задгай урсана. Горхины ус чулуун дээгүүр хоржигнон урсахдаа ч ойн бүрэнхий, ойн сэрүүнийг эрхбиш санагдуулдаг билээ. Горхийн хоёр талаар өтгөн өвс ногоо сагсайж, эргийн бүр ирмэг дээр ургасан нь горхийн усанд дүрэгдэн, турьхан иш ганхан ганхан үзэгдэх бөлгөө. Горхийн усан зарим

газар наранд гялалзан, зарим газар далайн хөвөөнөө өнгийх эгц эргийн доогуур шурган, зарим газар өтгөн өвс ногоо, удын бутан дотогуур шугран урсаар тэнгист цутгана.

Кириск Музлук хоёр горхи хүртэл гүйлдэн, эргийн өвсийг налуулан нэгэн зэрэг тонгойн ууцгана. Юун гар угаах, юун алгаараа утган уух, зүгээр л буга цус ууж байсан шиг толгойгоо тонгойлгон хоржигнон урсаж, хацар нүүрийг энхрийлэн гижигдэгч урсгалд нүүрээ дарж байгаад залгилж гарна. Тэгж уухад хичнээн жаргалтай сайхан гэж бодно!

Хөх хулгана ус авчирч өгөөч!

Ая, хөх хулгана ус авчирч өгөөч!

Хоёр мөрөөрөө нягт наалдаад ус руу тонгойн горхийн дэргэд хэвтэхэд түргэн урсгалт горхинд дүрсэн гар нь нэг хүний хоёр хоёр гар адил нийлэн харагдана. Тэд тэндээс холдохыг хүсдэггүй байв. Тэд горхийн ус руу тонгойгоод байхыг хүсдэг байв. Түргэн урсгалт горхийн дотор жирэлзэх дүрсээ харж инээмсэглэнэ. Тэдний дүрс усан дотор хачин мурий сарий болоход бие биеэ харж инээнэ.

Хөх хулгана ус авчирч өгөөч!

Хөх хулгана ус авчирч өгөөч!

Ая, хөх хулгана ус авчирч өгөөч!

Музлук горхийн дээр тонгойсон хэвээр жаламгар нүдээ баяртай жишүүлэн харахад Кириск урдаас нь мөн тийм янзаар харж инээмсэглэнэ. Тэгэхээр нь Музлук хойшоо бай гэсэн шиг мөрөөрөө түлхээд авах боловч Кириск үл зайлна. Тэгэхээр нь Музлук амандаа ус балгаж нүүр рүү нь шүршинэ. Тэгэхээр нь Кириск бүр томоор ус балгаж бүр нарийхан гожигдуулан урдаас нь шүршинэ. Чингээд л бөөн хөөцөлдөөн шуугилдаан болно доо хөөрхөхий. Тийнхүү бие биендээ ус үсэргэн, хамаг хувцсаа норгон норгон горхийн дотуур өөд сөөргөө гүйлдэн хөөцөлдөн нааддаг билээ.

Хөх хулгана ус авчирч өгөөч!

Энэ явдал дахин хэзээ ч ирэхгүй болно гэж бодохоос Кириск маш хүнд байв. Амьсгаа нь улам бүр давхцан заримдаа ходоод нь таталдана. Кириск сэмхэн уйлж, өвдөхдөө сэмхэн атиганаж, мөнөөхөн хөх хулгана дуудан

Хөх хулгана ус авчирч өгөөч

Гэж шивэгнэсээр байв.

Кириск тийнхүү элдвийг бодон өлсөх цангахыгаа мартахыг хичээх болов. Эргэн тойрон ондоо бослон юм үгүй. Урьдын адил зэвхий цагаан манан бүрхээд огтхон ч хөдлөх янзгүй. Тэд цөм тэнхээ тамираа бараад байр байрандаа тэрийн хэвтэв. Гэтэл гэнэт завь хүчтэй дайвалзан,

- Хүүе Мылгун чи яаж байна! Болиоч! Гэж эцэг нь сандран бахирав. Кириск эргэн хараад гайхаж хоцров. Мылгун завины хашлаганы дээгүүр тонгойн далайн уснаас шанагаар утган ууж байв.
- Болиоч! Гэж Эмрайн шанагыг булаан авах санаатай ухасхийн очтол цаадхи нь урдаас нь далайлгаж,
- Надад битгий ойрт, сахалт хар. Ална шүү! гэв.

Мылгун тийнхүүамандаа хүргэхийн аргагүй далайн давстай гашуун ус ханцуй энгэр рүүгээ асган цутган залгилж байв. Хорё гар нь салгана чичирч сүүлдээ шанагатай усаа биен дээрээ хөмрүүлж орхив. Мылгуны царай зэрлэг араатны адил харагдав.

Чингээд шанагаа завийн ёроолд чулуудаж түрүүлгээ харан унаж аахилан хэржигнэж хэвтэв. Их удаан хэвтэв. Гэвч түүнд туслах ямар ч арга байсангүй. Кириск айхдаа хомоол адил болж, агийн хэвтэхэд ам нь улам ихээр цангаж, ходоод нь улам ихээр хатгаж байв. Царай алдаж урвайсан Эмрайн арга буюу сэлүүрээ авч харанхуйн манан дундуур нэг тийш хөдлөв. Үүнээс ондоо арга мэх түүнд байсангүй.

Мылгун нэгэн үе нам болж, нэгэн үе дагжин чичирч цангаж үхэхийн зовлонд нэрвэгдэн хоолой амаа хэржигнүүлэв. Гэвч нэг хэдий болсон хойно өндийж,

- Дотор шатлаа! Гэж хэнхдэг цээжээ урж гарав.
- Одоо яадаг билээ? Чамдаа яаж тус болдог билээ? Бас жаахан ус бий, чамд жаахан хийж өгөх үү? Гэж Эмрайн бяцхан торхтой ус руу дохив.
- Үгүй, одоо нэгэнт өнгөрсөн. Уг нь би яаж ийгээд шөнө болгож, манай талийгаач өвөө шиг явчих гэсэн юм. гэтэл шөнө хүргэж чадахгүй нь. Одоо яая гэхэв. Харин дэмий юм л хийхгүй юмсан. Уг нь тэр усыг чинь бүгдийг уучмаар байна. Одоо нэгэнт өнгөрсөн. Би явлаа. Одоо би өнгөрсөн, надад чадал байна, би өөрөө явчина гэв.

Эзгүй хоосон далай дунд эцэс ч үгүй, зах ч үгүй манан дунд аандаа үхэх гэж буй хүний тийм үгийг сонсоход аймшигтай бөгөөд тэсэшгүй байв. Эмрайн өөрийн найз, өөрийн дүү Мылгуныхаа сэтгэлийг амруулах гэж хэдэн үг хэлэх гэсэн боловчиг наадах нь дуулахыг хүссэнгүй. Өөрт оногдсон зовлонг ганц цохилтоор тас цохих гэж шийдэн яарч байв. Мылгун солиотой хүн шиг,

- Эмрайн чи надад юм хэлж хэрэггүй, одоо нэгэнт өнгөрсөн. Та хоёр, эцэг хүү хоёр өөрснөө шийд. Тэгсэн нь дээр. Та хоёр намайг уучлаарай. Та хоёр эцэг хүү хоёр үлд!Цаана чинь жаахан ус бий. Харин би бол нэг алхаад л гүйцээ... гэж өөдөө босож завины ирмэг дарж тногойж байгаад адхин хүчээ хөвчлөн найгалзаж, Эмрайныг духаараа харж байгаад,
- Сахалт чи надад битгий саад болоорой. Ингэх хэрэгтэй юм. Нанад бүү саад бол! Баяртай! Тан нар гэртээ хүрч ч магад. Харин би одоо... чи шуудхан холдоод өгөөрэй. Намайг хүлээх, харах явдалгй, шуудхан...

хэрэв завьтайгаа ойртож очвол чинв хөмрүүлж орхино шүү. Сахалт чи одоо сэлүүрд, хүчтэй сэлүүрд. Дуулж байна уу, хөмрүүлж орхино шүү.. гэв.

Эмрайн мылгуны энэ сүрдүүлсэн, гуйсэн үгэнд орохгүй байж болсонгүй. Завь онгоц чив чимээгүй манан, чив чимээгүй усыг зүсэн шулуухан хурдлав. Кириск гашуудалтайгаар уйлж,

- Мылгун ах аа! Мылгун ахаа! Хэрэггүй гэж бахиртал Мылгун завины цаад руу шулуухан онхолдон унав. Чингээд далайн мөтсэй усанд хахан цацан,
- Зайл! Цаашаа холд! Гэж бахирав.

Мылгун харанхуй манан дотор дороо үзэгдэхгүй болов. Эргэн тойрон нам гүм болтол далайд живж буй хүний эцсий удаа бахирах дуун гарахад Эмрайн тэссэнгүй

- Мылгун! Мылгун! Гэж дуудан цурхиртал уйлж завиа түүн тийү залав.

Тэр даруй эгэж очсон боловч Мылгун байсангүй. Тэнд юу ч болоогүй юм шиг усны сандал хов хоосон, амар жимэр байв. Тэр хүн чухам хаахна живснийг олж мэдэхэд бэрх болсон байв.

Чингээд үлдсэн хоёр нь өдрийн үлдсэн хугасыг хаашаа ч ясвангүй, тэндээ эргэлдэн өнжив. Тэд санаа сэтгэл хоосрон, гашуун уйтгарт дарагдан хоёулаа уйлж гарав. Эцгийгээ уйлахыг Кириск амьдралдаа анх удаа үзэв. Урьд нь эцгийгээ тийнхүү уйлж байхыг хэзээ ч үзээгүй билээ.

Өдөр барагдаж үдэш болж байгаа бололтой. Энэ бол зөвхөн тэгж санагдаж буй хэрэг. Хэрэв тэнгисийн дээгүүр, харанхуй манангийн дээгүүр нар аялан яваа бол өдийд лав жаргадаг газартаа амар жимэр жаргаж байх ёстой. Энэхэн үес аажим аажмаар улам бүр харанхуйлан буй нягт манан дотор сураг танаггүй болсон орь ганц завь эргэлдсээр байв. Одоо тэр завинд хоёрхон хүн эцэг хүү хоёр үлджээ.

Үдэш орой болж буй мэт санагдмагц Эмрайн уснаасаа уух болов гэж шийдлээ. Кирискийг үзвэл чухам тэр цагийг хүлээн ядаж яваа нь илт байв. Хөөрхий хүү нь ганц ч үг дуугарахгүй, биеэ хүчлэн өлсөх цангахын зовлонг тэвчин яваа нь илт байв. Мылгуны үхсэн явдал ундны тухай бодлыг нь нэлээн саатуулжээ. Гэвч ам цангахын энэлэлийг санамсаргүй түр мартсаны хариуг авах гэсэн шиг юм уух хүслэн нь улам давхар ихээр оргилон иржээ.

Үдэш орой болж уснаасаа уух цаг болоход Эмрайн дусал ч ус дэмий асгахгүйн тулд өнөө нэвшингэ уснаасаа туйлын болгоомжтой гоожуулан хийж, эхлээд Кирискт өгөв. Жаал хүү шанагатай усыг шүүрэн авч өөрт ноогдсоныг галзуу юм шиг дор нь залгилав. Дараа нь Эмрайн өөртөө хийхдээ бяцхан модон савны дөнгөж ёроолд жаахан ус үлдсэнийг олж мэдэв. Ундны ус тужн бага үлдсэн байх ёстой гэж Эмрайн мэдэж байсан мөртөө үүнийг үзээд царай нь үнсэн хөх болов. Эмрайн одоо өөрийн хувьд оногдох усыг уух гэж

яарсангүй, шанагатай усаа барьж бодол болов. Гэтэл санаанд нь гэнэт аягүй юм орж сэтгэл донслоод тэр жаахан усыг уусан ч байсан ч ямар ч утгагүй болжээ.

- Май үүнийг барьж бай гэж шанагатай усаа хүүдээ бариулав. Уг нь тэгдэггүй байжээ. Шанагатай ус барьж байх мөртөө өөрөө зүрхлэн балгахгүй байна гэлэг бол жаал хүүгийн хувьд там гэсэн үг. Эмрайн барга ёроол нь гарсан модон сваа сайтар бөглөж байранд нь тавиад
- Наадхаа уучих гэж хүүдээ өгөв.
- Та яах юм бэ? гэж Кириск гайхав.
- Би сүүлд нь ууна. Чи юм санах хэрэггүй, уучих гэж Эмрайн маш тайван өгүүлэв.

Кириск тэрхүү нэг хүний хувьд хүртэх үмхий усыг бас л дор нь ууж орхив. Амны цангаа гарч санасандаа хүрсэнгүй боловч дотор нь бага зээрг уужрах шиг болжээ.

- За яаж байна? гэж эцэг нь асуув.
- Арай дээр боллоо гэж хүү талархан шивэгнэв.
- Чи бүү ай. Хүн амандаа дуслын төдий ус амсалгүйгээр хоёр гурав хонож чаддаг. Үүнийг санаж, ер юу ч болж байсан айх явдалгүй. Гэтэл Кириск түүний үгийг тасалж,
- Та яагаад өөрөө уусангүй вэ? гэв.

Ийм асуултанд гэнэт тулгарсан Эмрайн сандарч, бодоод

- Тийм ээ гэж товчхон дуу гарав.
- Юм идэлгүйгээр хэд хоног явж болох вэ? Бид чинв аль хэдийнээс юм идсэнгүй шүү дээ.
- Ганцхан ус л байвал болно. Гэвч чи тийм юм бүү бод. Алив, эндээс жаахан явъя. Би чамтай үг ярилцах гэсэн юмсан гээд Эмрайн завины сэлүүрийг хяхтнуулан хөдлөв. Тэр газар үг ярилцаж болохгүй байсан шиг тэд манан дундуур алгуурхан хөвөн холдов. Эцэг нь сэтгэлээ чангалах хэрэгтэй байлаа. Бодохоос гол руу хүйт оргиж байсан өнөө яриагаа үүсгэхэд биеэ бэлдэхийн тулд ондоо газар явсан нь арай дээр юм шиг түүнд санагджээ. Эмрайн зөвхөн өөрөө сэлүүрдэхээр үл барам хүүдээ бас сэлүүрд гэжээ. Тэд хаашаа ч яваад яах юм билээ. Кирискийг сэлүүрд гээд ч яах юм билээ дээ. Жаал хүү өнөө далайд явдаг том завины хэтэрхий хүнд сэлүүрийг даахгүй байв. Өрөөсөн сэлүүрээр болч яахав, хос сэлүүр болохоор би? нь даанч гүйцэхгүй байв. Эмрайн ч цаг ирэх тутам тамир алдаж, жаал хүүч мөн тамирджэ. Эл учир эцэг нь өнөө шийдсэн явдалдаа арга буюу яарч байв.

Кириск үг дуугарахгүй, эргэж ч харахгүйгээр завины хүнд сэлүүрийг таамаг татсан болж явав. Эмрайн урдаа бөгтийн бөөгийн яваа хүүгээ араас нь хараад \одоо үзвэл хүү нь хөөрхий, аргагүй л сульдгархан харагджээ\ уруулуу тас зуув. Түүнийг хараад Зүрх шимшрэн зүрх нь халуун цусаар лугшиж байхыг

Эмраийн мэдэж байв. Тэрбээр ондоо арга мөр байхгүй гэж мэдэвч яриагаа эхэлж зүрхэлсэнгүй.

Манан дунд юу ч үзэгдэхгүй болов. Эмраийн хүнд дүнсгэр бодолд дарагдан хөвсөөр байв. Түүнд үнэхээр тун бага цаг үлдэв. Эмраийн хэдийгээр чийрэг, хэдийгээр заяанаасаа лужир эо боловч өлсөж цангахын эрхээр тэнхээ тамир нь түргэнээ идэгдэж, түргэнээ барагджээ. Тэрхэн үед хүүдээ бас юм бодуулах зав гаргахын хамт өөрөөб хоёр хөл дээрээ босох чадалтай дээрээ, зориг самбаа гаргах чадалтай дээрээ шийдсэн мэхээ хийх хэрэгтэй байв.

Одоо завиа орхиж, Орган Мылгун хоёрынхоо хойноос орохоос ондоо арга байхгүй гэж Эмраийн ойлгож байв. Ингэх нь хүүгийн амийг аварч чадахгүй юм гэлээ гэхэд бяцхан модон торхны ёроолд үлдсэн жаахан усны хэрээр хэдэн өдөр боловч амьд байлгах ганц боломж мөн гэж бодож байв. Энэ шөнө юм уу маргааш манан арилах уу, үгүй юу гэдгийг Эмраийн яаж мэдэх билээ. Ер нь хүү нь юу болох, эрт юм уу орой хэзээ нэгэн цагт тэнгэр засралаа гэхэд тэнгис далайд орь ганцаар үлдсэн хүү нь ямар аргаар, яаж амь гарч чадах вэ гэдгийг Эмраийн яахин мэдэх билээ. Үүнийг хэн ч хариулж чадахгүй. Тун ч найдлага багатай, тэр ч байтугай биелэгдэхгүй байж үл болох газаргүй. Ганц горьдлого бол хэрэв тэнгэр цэлмээд цагаан арьстан улсын том онгоц санамсаргүй тааралдвал хүү нь аврагдаж юу магад! Цагаан арьстан хүмүүс заримдаа үүгээр үзэгддэг тэдний суудаг эргээс алс хол гадаад их далайгаар явж өөрсдийн ямар нэг ажлаар ямар нэг харь холын орноос гарч, ямар нэг харь холын ондоо оронд хүрдэг гэж Эмраийн урьд нь дуулсан билээ. Эмраийн бол өөрөө тэдэнтэй хэзээ ч тааралдаж байсангүй. гэвч өнөө нарт ертөнц даяар алдартай худалдаачингууд энэ тухай ярьсан нь бий. Тэр ч байтугай тэдний зарим нь цагаан арьстангуудын мөнөөхөн уул адил асар том завиар явж үзсэн мэтээр ярьдаг билээ. Гагцхүү тийм шайхамшигт учрал тохиолдож, хэрэв тэнгэр засраад зам тааралдаад цагаан арьстан хүмүүс гадаад их далайд ганц бяцхан төнхмөл завь явж байхыг олж харах юм бол амь гарч болно. Энэ нь хэдийгээр лавтай бус, бараг эс биелэгдэх туйлын хоосон горьдлого боловч ямар ч гэсэн нэг л горьдлого мөн.

Эмраийн хүүгээ ганцаар нь орхихын өмнө энэ тухай түүнд хэлэх гэж завдан явав. Ямар ч гэсэн өөрийн ухаантай явсан цагт эцсийнхээ амьсгалыг хураан хураатал завинаасаа салж болохгүй гэдгийг Кирискт итгүүлэн, сайтар захиж хэлэх нь чухал байлаа. Ус ундаа дуусаж, хэрэв үхэх үйл ирэх юм бол завиндаа үхэх хэрэгтэй, тэрнээс биш Орган өвгөн, Мылгун хоёр арга мухардаад далайд үсэрсэн шиг, эцэг нь арга мухардаад далайд үсрэх гэж байгаа шиг тэнгис далайд үсэрч болохгүй гэж сайтар захих хэрэгтэй байлаа. Ондоо ямар ч арга зам байсангүй. Хувь тавилангийн лгшин аясыг дагаж эвлэрэх хэрэгтэй шүү дээ. Гэтэл арван нэгэн настай жаал хүү нэвтлэшгүй харанхуй манан, хязгаар хярхаггүй далай дунд ганц завьтай ор ганцаар үлдээд яваандаа өлсөж, цангаж үхэх болно гэж бодохоос Эмраийны дотор бачимдав. Тийм явдалтай эвлэрч

болохгүй. Даанч санаанд багтамгүй хэрэг байлаа. Тэгэхлээр нь Эмрайн хүүгээ ганцаар нь орхиж чадахгүй нь хамт үхвэл дээр гэж бодов.

Удалгүй харанхуй болов. Тэнгис далайн дээр аанаа л нэвтлэшгүй пад харанхуй шөнө болов. Өдөр манан дундуур аль нэг тийш хөвж явах гэдэг утгагүй хэрэг байсан бол шөнө бүр ч утгагүй хэрэг. Тэдний завь нэгэнэ дороо аяархан намалзана. Бас лттэнгэр арилах ямар ч шинж тэмдэг алга. Тэнгис далай ямар ч амь амьсгаагүй гөлийсөн хэвээр авай.

Шөнө эцэг хүү хоёр завины ёроолд бие биедээ сайтар шахалдан хэвтэв. Хэн хэн нь унтсангүй. Хэн хэн нь өлсөж цангахын энэлэлд тарчлан хойшид юу болох хувь тавилангаа бодож хэвтэв...

Кириск тийнхүү эцэгтэйгээ наалдаад хэвтэж байхад нь эцэг нь энэ хэдэн хоногт айхтар турж эцээд бие нь бага, тэнхээ тамир ч үгүй болсон нь эрс мэдэгджээ. Зөвхөн сахал, ширүүн сахал л үлджээ. Тэр шөнө Кириск эцэгтээ наалдан эцгээ өрөвдөн нулимсаа сэмхэн сэмхэн залгин хэвтэхдээ эцгийгээ урьд хожид хэзээ ч мэдээгүй ихээр хайрлах сэтгэл төржээ. Хайрын тэр сэтгэлээ үгээр гаргаж ер чадахгүй байв. Тэр хайр нь түүний сэтгэл зүрхэнд, түүний цусанд түүний цохилох зүрхэнд нуугдаж байв. Кириск урьд нь эцэгтэйгээ адилхан, эцгийгээ дууриасандаа ямагт бахархан, эцэг шигээ хүн болохыг мөрөөддөг байв. Гэтэл одоо энэ хүн бол миний эцэг, миний эх үүсвэр юм, би бол түүний залгамж нь юм гэж ухаарчээ. Эл учир эцгээ өөрийн нэгэн адил айхтар ихээр өрөвдөв. Хөх хулганыг үнэн сэтгэлээсээ дуудаж, надад миний эцэгт ус авчирч өгөөч! гэж залбиран гуйж байв.

Хөх хулгана бидэнд ус авчирч өгөөч!

Хөх хулгана бидэнд ус авчирч өгөөч!

Гэтэл эцэг нь хэдийгээр цангахын зовлонг цаг ирэх тутам улам хүнд ихээр массаж, тэрхүү энэлэн цангахын маыг бие махбод нь даахгүй болсоор байсан боловч усны тухай огтхон ч бодсонгүй, ондоо юм бодож явав. Хамаг дотор нь халуу шатаж тас эвхрээд хамагбулчин шөрмөс нь төмөр адил татаж, буцаж тавихгүй байлаа. Толгойд вн бөөн юм шуугина. Мылгун эцсийн эцэст хэрхэн тарчилж байсныг тэр сая ойлгов. Гэвч тэр тухай болохгүй, оондоо юм бодож явав. Ус бодох, ханатал ус уухыг хүсэх бол одоо түүний хувьд нэгэнт утгагүй болжээ. Хэрэв хүү нь хамт яваагүй, хамгийн сүүлчийн тэр харанхуй шөнө бөөрөнд нь наалдан хэвтэж хүүгээ орхих сэтгэл хүрдэгсэн бол тэрхүү гарч болшгүй шаналгааг аль хэдийн тасалж чадах байлаа. Эцэг нь одоо гагцхүү хүүгийнхээ төлөө түүний амь нас аврагдах ямар ч боломжгүй байг хамаагүй тэр гай зовлонг эцсийн бололцоогоо баран бартал сөрөхдөө сөрж, хүүгээ нэг хэдийхэн хугацаагаар билээ ч амьд явуулахны тулд санамсаргүй тэмцэж горилж явав. Энэ бүхний тусын тулд эцсийн удаа зориг гарган шалав түргэн шийдэх хэрэгтэй байв. Гэтэл чухам хүүгээ бодохоос тийнхүү шийдсэндээ хүрч чадахгүй, хүүгийнхээ хувь заяаг зөнд нь орхиж зүрхлэхгүй байлаа. Юу гэвэл зоригоо чангалавч санасандаа хүрэх хүчин чадал нь барагдаж байв.

Хүүгийн эцгийнхээ дэргэд байх хугацаа барагдаж байв.

Үүнийгээ хүүдээ яаж, ямар үгээр таниулах вэ? Өөрийн нь тусын тулд түүнийг орхих гэж байгааг яаж хэлэх вэ?

Хүүгийн нь эцгийнхээ дэргэд байх хугацаа баргадлаа.

Гэтэл Кириск эцгийнхээ тэгж бодож явахыг тааж мэдсэн шиг

- Аав аа! гэж шивэгнэн биед нь улам чанга наалдаж, мөнөхөн хөх хулганаа дуудан явав.

Хөх хулгана бидэнд ус авчирч өгөөч!

Хөх хулгана бидэнд ус авчирч өгөөч!

Эмрайн шүүд тас зууж, гашуудан ёоловч юу ч хэлж зүрхэлсэнгүй. Дотроо хүү минь баяртай гэж салах ёс гүйцэтгэж явав. Гэтэл тэгж бодох тусам өнөө эцсийн алхам хийхээр босох гэдэг цулам шаналгаатай болж байв. Түүний өнгөрүүлсэн бүхий л амьдрал энэ шөнийн нь явдлын түрүүч байсныг тэр шөнө Эмрайн ойлгов. Трэбээр эцсийнхээ чадлыг шавхан өөрийн оронд хүүгээ үлдээхийн тулд төрж, үүний тулд үхэх учиртай байжээ. Эмрайн дотроо хүүтэйгээ салах ёс гүйцэтгэж байхдаа энэ тухай бодож олов. Тэр бээр өөрийн хувьд шинэ нээлт хийж, амьсгаагаа хураан хураатал өөрийн оронд хүүгээ үлдээхийн тулд бүх амьдралдаа ийм л хүн явжээ. Энэ тухай урьд нь боддоггүй байсан бол тэгж бодох шалтгаан гараагүй хэрэг.

Энэ бодол нь тэнгэрт цахилгаан гялбахын адил толгойд нь гялбан орж ирэхийн төдий урьд болсон нэгэн явдал санаанд нь оржээ. Жрьд, талийгаач мылгун, тэр овгийн бас бус улсны хамт ойд мод унагаж байхад тохиолдсон нэгэ явдлыг одоо санаж учргы ойлгов. Тэгэхэд олон хүн мол унагаж байв. Гэтэл нэг аваргатом мод унагаж байх үед Эмрайн огт санаандгүй зогсож байтал олон бүгдээр нэгэн зэрэг,

- Зайлаарай! Гэж бахиралдав.

Эмрайн санаандгүй байсан тул мэгдэн зогсов. Зугатаагаад зугатаагаад хожимдсон байжээ. Өнөө аварга том мод уг үндсээ нажигнуулан, моддын оройн ногоон мөчир найлзуурыг тасар татан, тэнгэрийг зуран дээрээс нь алгуурхан ойчих нь тэр. Энэхэн агшинд Эмрайн ганцхан юм. Кириск хүүгээ бодож байв. Тэгэхэд Псулк охин төрөөгүй, тэднийх ганцхан хүүтэй байв. Зайлшгүй үхлийн босгон дээр тулж ирсэн тэрхэн хоромд Эмрайн ондоо юм болсон ч үгүй, гагцхан миний хүү бол намайг залгамжлан үлдэх хүн мөн гэж бодож амжжээ. Сайхи мод догшин сүртэй нажигнан унахдаа Эмрайныг арай дарсангшүй, харин навч найлзуурынхаа салхи, тоосоор булж орхижээ. Улс сая санаа амарч, ашгүй амьд гарлаа шүү! Эмрайн минь бэртсэнгүй амьд гарлаа шүү! гэж баярлаладж байж билээ.

Одоо тэр явдлыг санаад чухам хүүтэй болсноор өдийд ийм хүн болсноо ойлгов. Амьдралдаа эцгийн хайраас илүү сайхан юм, илүү хүчтэй юм олж үзээгүйгээ ойлгов. Үүнийг Кириск хүүдээ ярихыг хүссэн боловч сэрээх сэтгэл хүрсэнгүй. Жаал хүү тэртэй тэргүй бие муу явав.

Хүүгийн эцэгтэйгээ хамт байх хугацаа барагдаж байв...

Хөх хулгана бидэнд ус авчирч өгөөч!

Хөх хулгана бидэнд ус авчирч өгөөч!

Хүүгийн эцэгтэйгээ хамт байх хугацаа баргадаж байв...

Эмрайн бас хоёр гурван нандин дурдатгал бий. Түүнээсээ хагацах гэдэг их бэрх байв. Цаг улам хомсдож буйг мэдэвч тэр тухай лурсан санахгүйгээр үхэхийг бас хүсэхгүй байв. Одоо завиа орхих цаг болов гэж бодон бодон мөнөөхөн дурдатгалаа дурсан санаж байв...

Эмрайн бол анхнаасаа эхнэртээ их хайртай билээ. Гайхмаар жигтэй юм! Эмрайныг далайд явахдаа босож явсан юмыг эхнэр нь гэртээ байхдаа мөн бодсон байдаг байв. Бүр анхнаасаа тийм янзтай байв. Эр нөхөр нь эхнэрийнхээ санаа бодлыг мэддэгийн нэгэн адил эр нөхөр нь далайд явахдаа юу бодож явсныг эхнэр нь мэддэг билээ. Бие биенээсээ хол байж тийнхү бодсон санаснаа мэдэлцдэг тэдний хоорондын нууц, ондоо хүн мэддэгүй ойр дотнын жаргал байв.

Кириск гараагүй, эхнэр нь хүүхэд олсны дөнгөж шинж тэмдэг мэдэгдэхэд Эмрайн далайд явж ирээд эхнэртээ

- Бид хоёр хүүтэб болох болов уу? гэжээ.
- Аяар! Ад албин дуулж орхино шүү! гэж эхнэр нь айвч нүд нь баяр баясгалантайгаар дүүрч - Чи яаж мэдэж байгаа юм гэв
- Чи өнөөдөр тэгж бодсон доо. Чи хүүтэй болох юмсан гэж тун хүсдэг шүү.
- Чи яадаг вэ?
- Чиний юу бодсоныг би мэддэг гэж чи мэднэ шүү дээ. Би ч бас тэгж бодсон.
- Би яагаад тэгж бодсон бэ гэвэл чиний тэгж бодсоныг мэдээд тэр. Чи л хүүтэй болохгы их хүсдэг дээ.

Санасан хэрэг бүтэж, тэдний зөн совин ёсоор болов. Кириск харахад төрөөгүй байсан боловч мөд удахгүй нярайлах болж, хоног ойртсоор байв. Тэр үед Эмрайны эхнэр түүний далан нөхөөс болсон хууичн арьсан өмдийг өмсөөд явдаг байв. Түүнийгээ, чиний ан гөрөөнд явсан хойгуур энэ гэрийн дотор эр хүний нэр амьсгаа явж байг, тэгэхгүй бол төрөх хүүхдийн өсөж торниход нь муу болно гэж тайлбарладаг билээ. Тэр үед эхнэр нь эр нөхрийнхөө хуучин муу арьсан өмдийг өмсөөд явахдаа ч хүсэх мэт хөөрхөн харагддаг байв. Хамгийн хөөрхөн хамгийн хүсүүштэй хүүхэн байв!

Тэр хоёр ямар шуу хүүхдийн эцэг эх болдог бол гэж бодож явсан тэр өдрүүдэд бол баяр түгшүүр төрүүлсэн алдарт сайхан өдрүүд байлаа.

Тэр нь энэ Кириск хүү байлаа.

Гэтэл одоо хүүгээсээ, ер түүнтэй холбоотой юм бүхнээс үүрд хагацах болоод байв.

Урьд Кириск хүүг жаххан байхад нь эх нь нэг өдөр яагаад ч вьм сэтгэл бүхмидэхдаа чи төрөөгүй байхдаа дээр байсан юм гэхэд хүү туйлын гомджээ.

Чингээд эцгийнгээ ан гөрөнөөс буцаж ирэхэд дэргэд нь наалдаж,

- Би төрөөгүй байхдаа хаана байсан юм бэ? гэж асуусан билээ.
- Мөн ч инээдэмтэй юм хэлнэ шүү!... Тэгэхэд эцэг эх хоёр нь зг дуугүй, зөвхөн нүдээрээ инээлдэж байв. Ялангуяа эцэг нь хүүгийнхээ асуусныг яач хариулж чадахгүй, тэр төрөөгүй байхдаа хаана байсан гэдгийг хүүдээ тайлбарлан хэлэх арга ухаанаа мэдэхгүй байхад эхнэр нь их л бахтай зугаатай байв.

Одоо миний хүү нарт ертөнцөд төрөөгүй байхдаа миний дотор миний цусанд миний бэлхүүсэнд байгаад тэндээс урсан эхийн хэвлийд орж, намайг яг дууриаж биеийг олсон юм. Одоо намайг алга болоод өгөхөөр чи үлдэж чиний хүүхдүүд намайг дууриан гарах болно гэж эцэг нь хүүдээ хэлэх байсан биз.

Үнэхээр ингэж хэлэх байсан биз. Үхэхийн өмнө чухам ингэж хэлэх гэдэг жаргал байсна биз! Гэтэл одоо юм бүхэн эцэс төгсгөл болжээ. Омог овог нь эцэс төгсгөл болжээ. Кириск одоо хамгийн цаанадаж нэг хоёр хоног амьд байна биз, түүнээс цааш чадахгүй гэдгийг Эмрайн сайн мэдэж байв. Хамгийн муухай гай, хамгийн золгүй явдал тэрхүү үр үндэс удам угсаа тасрах явдал юм. Тэрнээс биш хүүгийнхээ амь насны төлөө завийн дээрээс ус руу унах юу ч биш байлаа...

Бас чамд хэдэн өдөр амьд явах цаг хугацаа олгосон Орган, мылгун хоёрынхоо ачийг санаарай гэж хүүдээ эцсийн удаа итгүүлэн хэлэхийг Эмрайн туйлаас хүсэв. Тэр улс одоо байхгүй, хэн хүн тэднийг дурсана уу, эс дурсана уу, тэдэнд ялгаагүй. Гэвч чи бол дурсах хэрэгтэй. Үхэхийн өмнө агшин зуурч гэсэн тэр тухай дурсах хэрэгтэй юм. Үхсэн ч, тийм улсыг дурсаж үхэх ёстой юм шүү!

Гэвч үүнийг хүү нь өөрөө тухайлж мэдэх биз гэж Эмрайн бодов.

«»»»»»

«»»»» «

«»»»»»»»

Кириск сэрвэл урд урд шөнийнхөөс дулаахан унтсан байхад ихэд гайхжээ. Түүнийг эцгийн нь хүрмээр хучсан байв. Кириск нүдээ нээж өндийн харвал эцэг нь алга байв. Хүү ухасхийн босож, завины дээгүүр хий тэмтрэн аймаар муухай чарлав. Түүний чарлах дуун анир чимээгүй манант тэнгисийн дээгүүр эмгэнэлтэйгээ хадав. Орь ганц хөвгүүний туйлын цөхрөлтэйгээр чалрах дуун удаан тасалдсангүй. Кириск тэнхээ тамираа баран баран аймшигтай муухай чарлаж, завины ёроолд ойчоод толгойгоороо завины ёроол мөргөн мөргөн уйлав. Энэ бол түүнийг орхин одсон эцгийн ачийн хариу дуун, түүний хайр ивэгээлийн дуун, эцгийнгээ гашуудсан уй гашуудлын дуун байв.

Жаал хүү завины ёроолд хэвтээд толгойгоо өндийлгөсөнгүй, нүдээ ч харсангүй. Харах ч газаргүй, орох ч газаргүй болжээ! Эргэн тойрон өнөө л

цагаан манан. Харин энэ удаа тэнгисийн ус үл мэдэг цалгин, завь онгоц нэгэн дороо дайвалзан эргэж байв.

Кирииск өөрийгөө унтаж хоцров, хэрэв унтаж хоцроогүйсэн бол эцгийгээ тавихгүй байж, гараараа , шүдээрээ зуураад ч билээ тавихгүй байж, хамт үхсэн ч хамаагүй, тэр дороо өлсөж цангаж үхсэн ч хамаагүй бай, гагцхүү ингэж аймаар ор ганцаараа үлдэхгүй бйаж гэж өөрийгөө зэмлэн зэмлэн уйлав. Шөнө гэнэт нэг юм хүчтэй угзран нэг юм хүчтэй түлхэх шиг болж завь дайвалзан хөдлөхөд нойрон дундуу мэдсэн мөртөө сэрэх минь яав даа би, ухасхийн босож хашгирах минь яав даа гэж өөрийгөө хараан, зэмлэн уйлав. Тэгсэн бол хаанаас эцгийгээ далайд унагах вэ Тэгсэн бол хоёулаа хамт тэр хар ойл эргүүлэгт үсэрчихгүй юу

Дараа нь аажим аажмаар сэтгэл саатавч хамаг би?э чичрүүлэн уйлж байтал нэг хэдий болсон хойно өнөө гашуудалдаа түр мартагдсан цангахын их зовлон хариугаа ваах гэснэ шиг улам айхтар оргилон гарч иржээ. Кирииск зүүд нойрондоо ч усгүй хатаж энэлэн шаналж байснаа санав. Цангахын зовиур хамаг биеийг эзэмдэн цангахын зовиур хамаг биеийг тарчилган түүнийг багалзуурдаж ирэв. Тэгэхээр нь Кирииск бараг сохроор тэмтрэн өнөө модон торхондоо хүрч үзвэл бөглөөг авахад хялбар болгон сулруулж орхиод дэргэд нь шанага тавьсан байж. Уснаас хийж юу ч бодож саналгүй залгилтал наалдсан уруул нь салж, хоолой амны булчин таталдах нь гайгүй болов. Дахин хийж уумаар санагдсан боловч бодоод биеэ барьж чадав. Дахин хоёрын зэрэг удаа уух ус үлдэв.

Дараа нь гэдрэг суугаад миний эцэг яагаад юу ч хэлэлгүй яваад өгөв гэж гуниглан бодов. Эцэг нь байсан бол усанд живж үхэх гэдэг амархан байлаа. Одоо орь ганцаар үлдсэн болохоор айхын эрхэнд хамаг гар хөл хөшиж, завины ирмэг дээгүүр давж унах гэдэг аймшигтай санагдана. Гэвч зоригоо чангалж байгаад живнэ дээ гэж тэр шийдэв.

Хэдийн үд дунд юм уу, арай ч үд өнгөрсөн байж магадгүй байв. Кирииск манангийн дотро гэгээ орсон байдраар тэгж бодож байв. Тэгэхлээр үд дундын наран хаана нэгтээ гийж байх нь. Гэвч нарны туяа гадаад их далайн дээр зууралдан суусан Агуу их зузаан мананг нэвтлэн эс чадна. Манангийн өнгө хуурай түлээний утаа адил арай шингэн, арай цэнхэрдүү болж байв. хэдий тийм авч ялгаагүй хорь гучин сажин газраас цааш юу ч харагдахгүй, эргэн тойрон гагцхүү бараан ус гүвэлзэн харагдана.

Хаашаа ч хөвөх газаргүй, хөвье гэсэн ч Кирииск сэлүүрээ өргөж даамааргүй байв.

Эцгийн нь сэлүүр, Мылгуны сэлүүрийг завины ирмэг дагуулан нямбай гэгч зэрэгцүүлэн тавьсныг Кирииск их л гунигтай харав. Орь ганц жаал хүүг эргэн тойрон гагцхүү сэтгэлийг зэвүүцүүлэгч аргалшгүй догшин аймшиг битүү хүрээлэн байв.

Үдэш орой болсон хойно дахин юм уумаар тэсгэлгүй санагдаж, өлсөж тамирдснаас толгой эргэж эхэлжээ. Хөдлөх ч дургүй, ийш тийш харах ч дургүй болжээ. Хараад хараад харах юм ч алга. Тэр ч байтугай өнөө бяцхан торхтой

усандаа ч хүрэхэд бэрх болжээ. Өвдгөөрөө мөлхөж явснаа ядраад жаахан зогсов. Мөд удахгүй хөдөлж чадахгүй болно гэдгээ Кирииск ягштал мэдэж байв. гараа нүүрэндээ аваачиж үзвэл жирхний хатаасан арьс шиг жигтэйхэн, нарийхан болсныг үзээд айх шиг болжээ.

Энэ удаа уувал зохих хэмжээнээсээ арай илүү ус уув. Торхны ёроолд ганцхан удаа уух жаахан ус үлдэв. Түүнээс цааш юм уухгүй болно. Дусал ч усгүй болно. Гэвч одоо яасан ч ялгаагүй! Ус усан ч, уугаагүй ч үргэжл юм уумаар, ханатлаа уумаар санагдана. Өнөө айхтар өлсөх нь гайгүй болж, харин ходоод нь хүнд ихээр нухлан өвдөж огт намдахгүй болов.

Кирииск хэд хэдэн удаа ухаан балартсан авч сүүлд нь дахин сэрэв. Түүний завь тэнгисийн саянаас сэргэж эхэлсэн урсгалд туугдан мана дундууд аяндаа хөвж байв.

Кирииск нэгэн үе далайн усанд живж үхье гэж үнэнээсээ шийдэв. Гэтэл чадал хүрсэнгүй. Завины ирмэгээс барьж хоёр өвдөг дээрээ өндийтөл хоёр гар нь завины гадна тал руу унжсан хэвээр дүүжлэгджээ. Биеэ завийн дотроос татан гаргаж хэрхэвч даасангүй. Сүүлд нь бүр ч тамирсдан тул өнөө үлдсэн усаа балгах гэж оролдсон ч үгүй.

Завины ёроолд дахин хэвтээд мөнөөхөн умдаалагч хөх хулгана дуудан дуудан уйлж байв.

Хөх хулгана надад ус авчирч өгөөч!

Гэвч хөх хулгана гарч ирсэнгүй, харин тэр нэгэн зун нүцгэн шалдан горхийн усанд шумбаж байсан нь дахин санагдав. Тэгэхэд Кирииск долоотой, түүнээс илүүгүй байв. Тэр зун жигтэй халуун, ойн цоорхойд нар тэсэхүйеэ бэрх шарж байв. Тэд тэнд жимс түүгээд буцахдаа горхийн усанд орцгоосон билээ. Кириискийн ээж, ээжийн нь дүү бүсгүй хоёр ч усанд шумбав. Тэд Кириискээс төдийлөн ичихгүй хамаг хувцсаа тайлаад борхон гуя гялалзуулан хөхөө алгаараа дарцгаан горхийн усанд орцгоов. Гэтэл ус цалгиулан үсэргэж хачин жигтэй чарлалдан шуугилдаж байв. Кирииск горхийн хөвөөгөөр гүйж эргийн дээрээс усанд харайн ороход тэд ялангуяа эх нь унан тусан инээж, “Хараач! хараач! Эцэгтэйгээ туйлын адилхан, яг биеэрээ шүү!” гэж цаадахдаа ярьж байв. Тэгээд тэд өвөр хоорондоо чанга чанга шивэгнэлдэн цовоос сэргэлэн инээлдэж байж билээ... Горхийн ус ямар барагдах биш дээ, горхийн уснаас ханатал ууж болно, горхийн усанд хичнээн ч умаж болно...

Хөх хулгана надад ус авчирч өгөөч!

Гэтэл Кирииск нэг мэдвэл өнөө горхийн дэргэд дахин очоод байсан шиг санагджээ. Бас халуун зун болж Кирииск шалдалж усанд умбаж байх шиг санагдав. Гэтэл эргийн дээгүүр гүйж байгаад харайн орвол хүйтэн сэрүүн урсгал огт мэдэгдсэнгүй, ямар нэг баригдах юмгүй, биегүй ус юм уу манан шиг юманд орчихжээ. Чингээд манан дотор умбаж явахад тийм усанд жигтэй зэвүүн хүйтэн байв. Эх нь инээхийн оронд уйлж, “Хараач! хараач!” Эцэгтэйгээ адилхан шүү!”

гэж хэн нэгэнд өгүүлэн уйлж, гашуунаар уйлж байв... Ээжийн нь гашуун нулимс хацар нүүрийг нь дагаад урсаж байна.

“””

“””

“””

Шөнө далайн давалгаа шуугьж, завины бөөр рүү ёврон дайвалзуулахад Киrisk сэрэв. Сэрээд харвал түүний дээр од үзэгдсэнд жаал хүү баярлан аяархан дуу алдав. Тэр хэдэн хоногт анх удаа тэнгэрийн од олж харав. Тэнгисийн дээгүүр нэвсийх үүлэн чөлөөгөөр харанхуй тэнгэрт их л өндөрт од гялалзана. Тэр ч байтугай сах хэд хэдэн удаа үзэгдэн үүлний цаагуур түргнээ далд орж байв.

Гэнэт од мичид, сар, салхи, давалгаа, амьдрал хөдөлгөө бий болсны үзээд жаал хүү хирдхийн цочжээ. Зарим газар манан хурсан хэвээр тийм газар ороход бас л бүрэнхий харанхуй нөмрөн авах боловч удалгүй өнгөрч байв. Агуу их манан хөдөлж, өнөө хөшсөн байдлаасаа гараад салхи, давалгаанд хөөгдөн орчлонгийн дээгүүр хөвөлзөж эхэлжээ.

Жаал хүү нудимтсай нүдээр од өөд харав. Гэвч завиа сэлүүрдэх ямар ч чадал тэнхээ байсангүй. Од мичдээр чаж замаа олдог аргыг тэр мэдэхгүй байв. Одоо хаашаа хөвөх, ер хаана байгаа, цаашид юу болохыг мэдэхгүй байв. Гэвч ялгаагүй, далайн давалгаа шуугиж, салхи хөдлөн, завь онгоц долгионы дээгүүр хөвж эхлэхэд маш баяртай хөөртэй болов.

Орчлон ертөнц цэлмэж, тэнгис далайн цалгин хөдөлж ирэхээр жаал хүү баярлан гунин уйлав. Амны устай, ямар нэг идэх юмтайсан бол ийм амьдларыг үзээд бас ч хайрлах байлаа. Гэтэл байрнаасаа өндийх чадалгүй болж, тоотойхон хоног үлдсэн тул мөд цаагаж үхнэ гэдгээ хүү мэдэж байв.

Завь онгоц давалгааны дээгүүр улам ч хурдан үаламгай хөвөв. Ямар ч далуургүй, ямар ч урсгалыг даган хөвнө. Тэртээ алсад тэнгэр далайн савслага үл мэдэг тэмдэгрэн, шөнийн харанхуй улам сөхөгдөөдхурсан их манан тааралдах нь улам хомсдсоор байв. Хаая харанхуй мананд оровч өнөө бүхнийг халхлагч манан дотор ямар нэг санаанд багтамгүй амьтан адил юм чив чимээгүй жирэлзэн, салхины аясаар үүсэн замхарч, манан буданг тал тал тийш хөөн сарниулав.

Үүлэн цаанаас сар шагшаймагц тэнгисийн мандал ив илхэн хяралзан гялтагнаж, лахин харанхуйлавч, удалгүй дахин ил гарч байв. Киrisk ду дуугай жирвэлзэх оддыг харж хаал хүүгийн бодсон нь: Та нарын аль нь амь сахигч одод юм бол? Аль нь Орган өвгөнийх, аль нь Мылгун ахынх, аль нь миний эцэг Эмрайины од юм бол? Энэ хэдэн хоног бид та нарыг олж харсангүй. Од та нар ч манан дотор биднийг үзсэнгүй. Одоо би ганцаар үлдсэн. Хаашаа хөвөхийгөө мэдэхгүй болов. Гэвч одоо надад айх юм алга. Юу гэвэл тэнгэрт түгсэн та бүхнийг би харж байна. Харин гагцхүү аль нь хэний заяаны од болохыг би мэдэхгүй юм. Гэвч ийм явдал болсон нь та нарын буруу биш. Биднийг далайд

явж байхыг та нар хасангүй. Агуу их манан биднийг халхалж байв. Би одоо ганцаар үлдэв. Бусад маань урсаад явчихсан, гурвуулаа урсаад явчихсан. Тэд од та нарыг лнц хайрладаг байв. Тэд газар дэлхий дээр зам мөрөө олхоын тулд та нары олэ харахыг тун их хүсэж тун ч их хүлээж байлаа. Од гэдэг хэзээ ч хүнийг хөөддөггүй гэж Орган өвөө хэлсэн билээ. Өвөө одоор замаа олоход намайг сургах гэж хүсдэгсэн. Гэвч ийм явдал болсон нь та нарын буруу биш. Би одоо ман удахгүй үхлээ. Надад уух ус алга. миний чадал бүрмөсөн барагдлаа, би хаашаа явахыгаа мэдэхгүй байна... надад одоо жаахан, тун жаахан ус үлдсэн, түүнийгээ одоо ууж орхино, тэгээд л цааш нь тэсч чадахгүй, арга бахйгүй! Би өнөөдөр борцны хүүдийнээс Гэсгийг таслан зажлав, тэр бол хав загасны арьсаар хийсэн хүүдий юм. Гэвч дахиад чадахгүй, бөөлжис хутган, дотор урван гарчих гээд байх юм. Би одоо эцсийнхээ жаахан усыг уух минь. хэрэв бид дахин бие биеэ харж чадахгүй бол манай Орган өвөө, Мылгун ах, миний эцэг Эмрайн нар од та нарт тун ч хайртай байсныг та нарт хэлэх гэсэн юм. Хэрэв би бөглөө болгож чадвал дахин хагацамз...”

Удалгүй нэг их зурвас мананд дахин шургав. Юм бүхэн далдлагдаг дахин үзэгдэхгүй болов. Кирискийн завь салхи, давалгаанд туугдан, урьдын адил хөвсөөр байв. Гэвч одоо бол Кирист өөрцгүй! Жаал хүү ялзарч үмхийрсэн усныхаа үлдэгдлийг уугаад завины хитгэн дээр Орган өвгөний суудал дээр очиж хоосон торхныхоо ёроолд хэвтэ.в Үхэхийг завдан хэвтэ.в Одоо бол түүнд ямар ч мананаас айх юм алга. Гагцхүү од үзэгдэхгүй болов, тэнгэрийн ододтой дахин салах ёс гүйцэтгэж амжихгүй байж болно гэж хамарсан болдож байв. хамаг бие нь улам улам муудав.

Кириск бараг солиорч, унтсан унтаагүйн хооронд хэвтэ.в ЦУаг хэдүй өнгөрснийг бүү мэд. Шөнө дунд өнгөрсөн ч бай жмагад, өглөө болох дөхөж байж ч магадгүй, үүнийг хэлэхэд бэрх байлаа. Тэнгисийн дээгүүр салхинд хийсэх утаа адил сиймхий униар татжээ.

Хүний хувь зохиол гэж байдаг бол байдаг байна. Жаал хүү сонсож ч болно, соносхгүй байж ч болно. гэнэт сонсчээ. нэг мэдвэл шувууны далавч исгэрэн шуугиж, манан дунд ямар нэг амьтсан маш доогуур нисэн өнгөрөх нь сонсдов. Кириск цочин сэрээд ухасхийн харвал нэгэн том гэгчийн шувуу өргөн далавчаа дэвэн дэвэн нисэж явахыг олж харвай. Кирикс хүү

- Агукук, агукук! Гэж дуу алдан хашгирч байхдаа умарт туйлын тэрхүү ууль шувуу аль зүгт нисэж байгааг ажиглан амжиж, салхины чигийг тогтоож амжжээ. Салхи зүүнээс, ар шил рүү нь тухайлбал зүүн чихний нь араас үлээж байжээ. Кириск хүү өнөө шувууны араас,
- Агукук! Гэж хашгирах зуураа Орган өвгөний залуурыг хэдийн шүүрэн аваад завиа өнөө умрын ууль шувуу ниссэн зүг залав.

Кириск хүү залуурын сэлүүрээс зуурч, үлдсэн хүчээ шавхан сэлүүрдэж гарав. Тэрбээр ондоо юу ч бодолгүй зөвхөн салхины чиг, зөвхөн явах чигээ дотроо бодож явав.

Кирикс тэр умрын ууль чухам хаанаас аль зүг нисэж явааг мэдсэнгүй. Арлаас эх газар руу нисэн яваа юм уу аль эсвэл эх газраас арал тийш нисэж яваа юм бүү мэд. Гэвч энэ шувуу бол тэнгис далайн дээгүүр гагцхүү шулуун шугамаар нисдэг шувуу. Шөнө ч бай, манантай ч бай нисэж чаддаг хамгийн чадаотай шувуу гэж Орган өвгөн ярьсныг Кирикс мартаагүй байв. Кирикс хүү одоо түүний хойноос дагав.

Завь онгоц долгионоос давж, салхи ч тогтвортой. Кирикс хүү зөвхөн слахины чиг, явах чигээ сайтар тогтоон авсан байлаа. Харанхуй манан сийрч, тэнгисийн хаяа үл мэдэг гэгээрэв. Урд нь чанх урд нь харанхуй хөх тэнгэрт ганц онц туяатай од гэрэлтэж байв. Тэр од чанх урд нь гялалзаж байхыг Кирикс хэдийн агласан билээ. Тэр одыг хараанаас алдалгүй, тэр одны зүг явах ёстой юм байна гэж Кирикс гадарлав. Яагаад гэвэл мөнөөхөн агукук гэдэг умрын ууль тийшээ нисэн одсон билээ. Кирикс тэр одны нэрийг мэдэхгүй боловчиг түүнийг нүд салгалгүй ширтэн, салхи ар шилнээс үлээн буй гэж сайтар тогтоон салхины чиг, слахины хүч, түүний урсгалыг сайтар тогтоож авав.

“Салхи аа! Чи энэ чигээрэ салхилаад бай. Битгий намдаарай. Чи ямар нэртэйг би мэдэхгүй юм, үүнийг надад Орган өвгөн хэлж өгч чадах байлаа. Гэвч хамаагүй надтай ах дүү бололц. Битгий намд ондоо тийш битгий гуйваарай. Чи бол хэрэгтэй чигтээ хэдэн хоногоор салхилж чадна шүү дээ. Салхи минь, надад тус бол, битгий намдаарай. Би чиний нэрийг мэдэж аваад нэрээр чинь нэрлэж байх болно. харин одоо чамайг Органы салх гэж нэрлэе, чи дуртай байна уу? Орган өвөөгийнхөө нэрээр нэрлэе. Хойшид чамайг дандаа Органы салхи гэж нэрлэж байя. Чи ч намайг мэдэж авах болно...”

Тэр аятайхан салхинд ингэж ярьж, зориг сэтгэлээрээ хөгжөөн, тэр чигээ алдалгүй үлээж байхыг салхинд итгүүлж явав. Гэхдээ өнөө чиглэн яваа замыг заагч одноос нүд эс салган,, “Од минь ээ, би чамайг хайрлаж байна. Чи миний өмнө маш хол, маш өндөрт гэрэлтэн байна. Чи хамгийн сайхан том од юм! Чамайг битгий бөх, тэр байрандаа гэрэлтээд бай гэж би гуйж байна. Би чиний тэр зүг хөвж явна. Агукук хэмээх умрын ууль чиний зүг ниссэн. Тэр шувуу арлын зүг нисэж яваа юм уу аль эсвэл эх гарын зүг нисэж яваа юм уу би мэдэхгүй. Арал тийш ч явсан байг хамаагүй, би тэр арал дээр очиж үхнэ. Од чи битгий холд, битгий бөх! Чи ямар нэртэй од болохыг би мэдэхгүй юм, надад битгий хорсоорой. Чиний нэрийг олж мэдэж амжаагүй явна. Чи ямар нэртэй од болохыг миний эцэг Эмрайин хэлж өгөх л байсан юм даа. Чамайг би эцгийнхээ нэрээр Эмрайины од гэж нэрлэе, чи дуртай байна уу? Чамайг тэнгэрт гиймэгц би чамтай мэндлэн нэрээр чинь шивэгнэж байх болно. Эмрайины од чи надад тус бол. Тэнгэр гэгээрэхийн өмнө бүү бөх, үүлэн цаагуур битгий нуугдаарай...”

Кирикс замыг заагч одондоо ингэж ярив. Бас далайн давалгаанд ярьсан “Давалгаа гуай та одоо сайхан харагдж байна, миний энэ Каяк хэмээх гуй онгоцыг туугаад бай. Би таныг Мылгун ахын давалгаа гэж нэрлэе. Давалгаа та агукук уулийн ниссэн зүг давалгаалдаг тань сайн байна. Та бол хэрэгтний зүгтээ

удаан давалгаалж чадна шүү дээ. Мылгун ахын давалгаа та битгий намдаарай, энэ чигээсээ битгий хазайгаарай. Би уг нь сэлүүрдээд явж чадах боловч одоо даанч тэнхээ тамир алга. Би таныхаа дур зоригоор рөвж явааг харна уу? Хэрэв би амьд гарах юм бол давалгаа та Органы салхин дагуу, Эмрайины одны зүг долгиолж байгаа энэ чигийг тань насан турш мэдэж авах болно. Мылгун ахын салхи сайн сайхны зүг салхилж байсан шүү гэж би хүн бүхэнд уламжлан хэлнэ. Мылгун ахын салхи миний нэрийг тогтоож аваарай.

Битгий явчаарай, намайгаа бүү орхиорой...”

“”””

“”””

“”””

Тэнгэрийн олон оддын дотроос Эмрайины од их л удаан гийж байв. Үүр хяраалж байхад ч огторгуйд ганцаар гэрэлтэж байв. Тийнхүү маш тод тунгалаг гэрэлтэж байснаа өглөөний бор тэнгэрт аажмаар бөхөв. Гэвч тэнгэрт тэр тушаа энхрий цагаан толбо дааварласаар байлаа.

Ингэж өглөө болов. Тэнгисийн дээр наран мандав. Кирииск нэгэн үе баярлан нэгэн үе айж байв. Наран мандахад баярлаад тэнгисийн хязгаар хярхаг үзэгдэхгүй байхав айв. Тэнгис далай нарны туяан дор бүдэгхэн солонгорон туяарч усны өнгө бараг хав хар харагдах бөгөөд сэтгэлд багтамгүй хоосон эзгэй харагдана. Кирииск залуурын сэлүүрээс чичрэн зуурч, салхинд гуйвалтгүйгээр мөнөөхөн сэтгэлдээ тогтоож авсан зүг хөвөх гэж хичээв. Энэ бол маш зүдэргээтэй ажил байлаа.

Гэтэл хүүгийн толгой эргэж, хамаг юм нүдний өмнө дайвалзаад иржээ....

Түүний завь одоо ямар ч залуургүй хар зөндөө хөвж байв...

“””””

“””””

“””””

Кирискийг ухаан ороход нар тэнгисийн нөгөө захад очсон байв. Кирииск юмнаас татаж тулсаар завины хидэг тийш очих тролгойн эргээ гарахыг хүлээн нүдээ аниад хэсэг суув. Тэгээд нүдээ нээв. Завь давалгааны дагуу хөвсөөр байв. Тэнгис далай аанай долгион цалгилж түүний дээгүүр тоо томшгүй цагаан гялбаа мяралзана. Кирииск урагшаа хараад нүдээ арчин гөлрөв. Яг урдаас нь тэнгисийн бараан хөх нуруун дээгүүр хөөрхий Алаг хав толгой харагдав. Алаг хав толгой урдаас нь айсуй. Агуу их Алаг хав толгой минь ээ!

Тэнгисийн зах хязгаар газрын эрэг овон товонтой бор цэнхэр зураас адил харагдана. Гэвч цагаан толгойт, цагаан цавьт Алаг хав толгой бусдаас өндөр харагдах агаад Алаг хав толгойн ёроолыг эмжин мөнөөхөн далайн давалгаа буцлан бургилж байх нь илхэн харагдав. Эргийн цахлай шувууд ганганах дуун дуулдав. Цахлай шувуу Кирискийг хамгийн түрүүнд олж харжээ. Толгойн дээр асаасан дохионны түүдэг гал унтраад цэнхэр утаа суунаглаж байв.

Далайн хөвөөний Алаг хав толгой минь ээ!
Би чинь Орган өвөөгөө алдчихаад
Эмрайн эцгээ алдчихаад
Мылгун арыгаа алдчихаад
Ганцаараа буцаж явнаа!
Тэд яасан бэ гэж надаас бүү асуу
Юу ч гэсэн надад уух юм аль!

Энэ бол түүний нэрэмжит дууны эхний зг гэж Кириск ойлгож байв. Энэ дуугаа насан туршид дуулан явах болно.

“”””

“””””

“””””

Харанхуйн дунд тэнгис далай энэлэн хурхирч, эргийн хавцлын мөргөн мөргөн буцна. Хатуу чулуун хөрс тэнгисийн давалгааны балбалтыг сөрөн сөрөн хүчлэн уухилна.

Тэнгис газар хоёр анх бий болсон цагаас хойш, нарт ерөтнцөд өдөр шөнө гэж болдог болсон цагаас хойш ингэж үргэлж тэмцэлдэж ирсэн бөгөөд хойшид ч газар ус гэж бөайсан цагт ингэж өдөржин шөнөжин сөргөлдөж байх буй за.

Өдөржин шөнөжин шүү....

“””””

“””””

“””””

... Газар дэлхий дээр бас нэг шөнө өнгөрөв.

Тэнгисийн дээгүүр Органы салхи шуугиж, Мылгун ахын давалгаа бөмбөрөн, гэгээрэн буй тэнгэрийн хаяанд Эмрайны од гэрэлтэн байлаа.

Ингээд газар дэлхий дээр бас нэг өдөр болов.

ТӨГСӨВ.